



**ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**



**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ**

“ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БОДЛОГО, ХӨТӨЛБӨР 2019-2020”

/хууль тогтоомжийн эмхтгэл/

Албан хэрэгцээнд зориулан эмхтгэв.

**Улаанбаатар хот
2020 он**

**“ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН
БОДЛОГО, ХӨТӨЛБӨР 2019-2020”**
/хууль тогтоомжийн эмхтгэл/

Хэвлэлд бэлтгэсэн:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр
эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын
ахлах шинжээч Д.Хадхүү

Хянан тохиолдуулсан:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр
эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын
дарга Ц.Амартөгс

Цаасны хэмжээ:	А6
Хэвлэлийн хуудас:	10 х.х
Хэвлэсэн газар:	“Ахeрpoint” ХХК

Улаанбаатар хот
2020 он

ЭМХТГЭЛИЙН АГУУЛГА

№	Хууль, тогтоомж, тушаал шийдвэр		Огноо, дугаар	Хуудасны дугаар
1.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль	Монгол Улсын хууль	2011.06.17	4
2.	Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр батлах тухай	Засгийн газрын тогтоол	2019.4.13	32
3.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам		2016.05.23 №276	43
4.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам		2011 №375	50
5.	Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж, санхүүжилт /тарифаар тооцож/ олгох журам	Хөдөлмөрийн сайдын тушаал	2014.05.27 №А/123	54
6.	Орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл батлах тухай	ХЭҮЗ-ийн тогтоол	2019.07.04 №02	60
7.	“Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих 2019-2020 оны хөтөлбөр”-үүдийг батлах тухай /нэмэлт, өөрчлөлтийг тусгав/		2019.01.14 №01	67
8.	Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих хөтөлбөр, арга хэмжээний нэмэлт, өөрчлөлтүүд		2020.01.31 №01	105
9.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг 2019-2020 онд хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамж батлах тухай /нэмэлт, өөрчлөлт/	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал	2019.03.05 № А/83	109
10.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай		2019.03.05 № А/82	134
11.	Хөдөлмөрийн зах зээлийн статистик үзүүлэлтүүд	ҮСХ, ХНХЯ		147



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 6 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлж, түүний төрөл, хэлбэр, хамрах хүрээ, санхүүжилт, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцоотой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомж

2.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай, Нийгмийн халамжийн тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. “ажил хайгч” гэж ажилгүй, ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж, хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн биржид бүртгүүлсэн болон хандсан иргэнийг;

3.1.2.“ажилгүй иргэн” гэж ажилгүй, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэнийг;

3.1.3.“ажилгүй” гэж Төрийн албаны тухай хуульд заасан төрийн улс төрийн болон төрийн жинхэнэ албан тушаалд ажиллаагүй, түүнчлэн Хөдөлмөрийн тухай хуульд заасан хөдөлмөрийн гэрээ, контракт, Иргэний хуулийн[8] 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр ажиллах гэрээ, тэдгээртэй адилтгах гэрээгээр ажил гүйцэтгээгүй, хувиараа ажил, үйлчилгээ эрхлээгүй байхыг;

3.1.4.“ажил хийхэд бэлэн” гэж Хөдөлмөрийн тухай хуульд заасан хөдөлмөрийн гэрээ, контракт, Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр ажиллах гэрээ, тэдгээртэй адилтгах гэрээ байгуулахаас татгалзахгүй байхыг;

3.1.5.“ажил идэвхтэй хайж байгаа” гэж аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага, хөдөлмөрийн биржид бүртгүүлж ажлын байрны талаар мэдээлэл авах, ажлын зар, цахим хуудсаар ажил олгогчид хандах, нийтийн үйлчилгээний газрын мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар тавих зэрэг ажил олох оролдлого хийснийг;

/Энэ заалтад 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

3.1.6.“ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн” гэж хөдөлмөрийн гэрээ цуцлах мэдэгдэл авсан, эрүүл мэндийн шалтгаанаар ажлаа өөрчлөх шаардлагатай болсон, эрхэлж байсан хувийн аж ахуй нь эрсдэлд орсны улмаас сэргээх боломжгүй болсон тухайгаа аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага, хөдөлмөрийн биржид мэдэгдэж, бүртгүүлсэн иргэнийг;

/Энэ заалтад 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

3.1.7.“ажил олоход хүндрэлтэй иргэн” гэж хөдөлмөр эрхлэлтийн нэмэлт үйлчилгээ, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэн болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3.1-д заасан иргэн, хорих ангиас суллагдсан болон хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан иргэн, 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа иргэнийг;

3.1.8.“хувиараа хөдөлмөр эрхлэгч” гэж дангаараа болон бусадтай хамтран аж ахуй эрхэлж, татварын албанд бүртгүүлэн бизнесийнхээ үйл ажиллагаанд нөлөөлөх шийдвэрээ хараат бусаар бие даан гаргадаг иргэнийг;

3.1.9.“малчин” гэж мал аж ахуй эрхэлж үндсэн орлогоо олдог иргэнийг;

3.1.10.“ажилд зуучлах” гэж ажил хайж байгаа иргэнд хүсэл сонирхол, мэргэжил, ур чадварт нь тохирсон ажил олоход, ажил олгогчид эрэлт хэрэгцээнд нь нийцсэн ажилтан олоход туслалцаа үзүүлэх үйлчилгээг;

3.1.11.“бизнес инкубацийн үйлчилгээ” гэж хувиараа хөдөлмөр эрхлэгч болон хувиараа хөдөлмөр эрхлэхийг хүссэн иргэн, түүнчлэн малчинд мэдээлэл, мэргэжлийн зөвлөгөө өгөх, аж ахуй эрхлэх ур чадвар эзэмшүүлэх, үйлдвэрлэлийн байр түрээслүүлэх зэргээр дэмжлэг үзүүлж, аж ахуй эрхлэх таатай орчныг бүрдүүлэхийг.

3.1.12.“бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч” гэж 50 хүртэл сая төгрөгийн үйлдвэрлэлийн хөрөнгө, эсхүл үйлчилгээний борлуулалтын орлого бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэнийг.

/Энэ заалтыг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмсэн/

4 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зарчим, төрийн бодлогын чиглэл

4.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд дараах зарчим баримтална:

4.1.1.иргэнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, эрүүл мэндийн байдал, хөрөнгө чинээ, боловсрол, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь үл ялгаварлах;

4.1.2.хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ адил тэгш, нээлттэй, ил тод байх;

4.1.3.иргэн сайн дурын үндсэн дээр хөдөлмөр эрхлэлтэд хамрагдах;

4.1.4.ажил олоход хүндрэлтэй иргэдийн хөдөлмөрлөх тэгш эрх, адил боломжийг хангах;

4.1.5.нийгмийн түншлэлийг дэмжих;

4.1.6.олон нийтийн оролцоонд тулгуурлах.

4.2.Төрөөс хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар дараах бодлогын чиглэлийг баримтална:

4.2.1.хүн амын хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх, ажиллах хүчний хөдөлмөр эрхлэлтийн тогтвортой түвшинг хангах;

4.2.2.ажиллах хүчнийг хөрөнгө оруулалт, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн хөгжүүлэх;

4.2.3.хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн иргэний мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх;

4.2.4.хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, судалгааг хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүртээмжийг нэмэгдүүлэх, чанар, үр ашгийг дээшлүүлэх;

4.2.5.ажиллах хүчний дотоодын зах зээлийг эзэмших, гадаадын зах зээлд мэргэшил, чадвар дээшлүүлэх;

5 дугаар зүйл. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг дэмжих

5.1.Төрөөс хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг дэмжих талаар дараах арга хэмжээг жил бүр авч хэрэгжүүлнэ:

5.1.1.үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд гаргах талаар судалгаа хийх, гэрээ, хэлэлцээр байгуулах;

5.1.2.экспортлох зориулалттай үйлдвэрлэл эрхлэх болон ажлын байр олноор нэмэгдүүлэх жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид эхний ээлжид зээл олгох, бий болгосон ажлын байрны тоог харгалзан татварын хөнгөлөлт үзүүлэх;

5.1.3.алслагдсан болон эдийн засгийн сул хөгжилтэй бүс нутагт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих, эсхүл төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан зарчмаар хөрөнгө оруулах;

5.1.4.Засгийн газраас тодорхойлсон бусад арга хэмжээ

5.2.Энэ хуулийн 5.1-д заасан арга хэмжээг аж үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тодорхойлж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлнэ.

/Энэ хэсэгт 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

/Энэ хэсгийг 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

6 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны төрөл, хэлбэр

6.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа нь дараах төрөлтэй байна:

6.1.1.хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ;

6.1.2.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ.

6.2.Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ:

6.2.1.ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;

6.2.2.ажилд зуучлах;

6.2.3.ажилгүйдлийн тэтгэмж олгох;

6.2.4.нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээнд хамруулах;

6.2.5.бусад үйлчилгээ.

6.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг дараах төсөл, хөтөлбөрийн хэлбэрээр хэрэгжүүлнэ:

6.3.1.хөдөлмөрт бэлтгэх;

6.3.2.хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах;

6.3.3.малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг дэмжих, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих;

6.3.4.ажил олгогчийг дэмжих;

6.3.5.нийтийг хамарсан ажил зохион байгуулах;

6.3.6.ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;

6.3.7.хууль тогтоомжид заасан, түүнчлэн Засгийн газрын болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн шийдвэрээр тодорхойлсон бусад төсөл, хөтөлбөр.

6.4.Ажилгүйдлийн даатгалын тэтгэмж олгох нөхцөл, журмыг Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулиар зохицуулна.

6.5.Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үнэ төлбөргүй байна.

7 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хамрах хүрээ

7.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, ажил олгогч энэ хуульд заасны дагуу хамрагдана.

/Энэ хэсэгт 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

8 дугаар зүйл.Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ

8.1.Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд тодорхой ажил, мэргэжил, ажлын байрны талаарх мэдээ, мэдээллийг иргэдэд хүргэх, ажил, мэргэжлээ сонгох болон хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах нөхцөлийн талаар зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах үйлчилгээ хамаарна.

8.2.Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлийн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг ганцаарчилан болон хэсэг, бүлгээр зохион байгуулна.

8.3.Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг тухайн сургуулийн захиргаатай хамтран тусгайлсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.

8.4.Хөдөлмөрийн бирж ажил, мэргэжлийн чиг баримжаа олгоход ашиглах гарын авлага, түгээмэл мэргэжил бүрээр танилцуулга бэлтгэж, мэдээллийн сан бүрдүүлнэ.

8.5.Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын агуулга, сургагч багшид тавих шаардлагыг хөдөлмөрийн болон боловсролын

асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд тогтооно.

*/Энэ заалтыг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмсэн/
9 дүгээр зүйл.Ажилд зуучлах*

9.1.Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага, хөдөлмөрийн бирж нь бүртгэсэн ажил хайгч болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэнийг ажил олгогчийн эрэлт хэрэгцээг үндэслэн ажилд зуучилна.

/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

9.2.Хөдөлмөрийн хувийн биржийг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүний эрх олгосон байгууллага бүртгэж, мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбоно.

/Энэ хэсэгт 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмэлт, 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан/

9.3.Энэ хуулийн 9.1-д заасан үйлчилгээний хүрээнд иргэнийг ажилд зуучлах боломжгүй бол хөдөлмөрийн хувийн бирж уг иргэнийг хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээнд хамруулахаар аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага, сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтанд мэдэгдэнэ.

/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

9.4.Энэ хуулийн 9.2-т заасан мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсон хөдөлмөрийн хувийн биржид уг нэгдсэн сүлжээнд бүртгэгдсэн ажил хайгчдаас ажилд зуучлуулсан болон оруулсан хүний тоогоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас тогтоосон тарифаар тооцож санхүүжилт олгох бөгөөд хөдөлмөрийн хувийн бирж нь ажилд зуучлуулсан иргэнээс шууд ба шууд бус байдлаар үйлчилгээний төлбөр авахыг хориглоно.

9.5.Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж, санхүүжилт олгох журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭ

10 дугаар зүйл.Хөдөлмөрт бэлтгэх

10.1.Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ нь ажил олоход хүндрэлтэй иргэн, сургууль завсардсан, хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхдэд хүнтэй харилцах ур чадвар эзэмшүүлэх, хөдөлмөрийн харилцааны мэдлэг олгох, хөдөлмөрийн дэг журам, үйлдвэрлэлийн горимд дасан зохицоход нь

туслах зэрэг зайлшгүй хэрэгцээт багц үйлчилгээ, дэмжлэг, туслалцааны хэлбэртэй байна.

10.2.Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээний үйлчилгээ, дэмжлэг, туслалцааг хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

11 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах

11.1.Хөдөлмөр эрхлэлтийн сургалт нь иргэнд үйлдвэрлэл дээрх сургалт, мэргэжлийн болон давтан сургалт, явуулын болон зайны сургалт, шавь сургалтын зэрэг хэлбэрээр богино хугацаанд мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх, хөгжүүлэх зорилготой байна.

/Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

11.2.Хөдөлмөр эрхлэлтийн сургалт нь ажилгүй иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, сургууль завсардсан, хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхдэд богино хугацаанд мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх, хөгжүүлэх зорилготой байна.

/Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

11.3.Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага нь Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 14.5-д заасан журмын дагуу гэрчилгээ авсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй хамтран хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг зохион байгуулж болно.

/Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

11.4.Энэ хуулийн 11.2-т заасан иргэний сургалтын зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас бүрэн болон хэсэгчлэн санхүүжүүлнэ.

11.5.Энэ хуулийн 11.2-т зааснаас бусад иргэн хөдөлмөр эрхлэлтийн сургалтад өөрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын зардлаар, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуульд заасан Ажилгүйдлийн даатгалын сангийн зардлаар хамрагдаж болно.

11.6.Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдсан иргэний мэргэжлийн ур чадварыг үнэлэх, шалгах, баталгаажуулах ажлыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүний эрх олгосон байгууллага зохион байгуулах бөгөөд мэргэжлийн ур чадварыг үнэлэх, шалгах, баталгаажуулах журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Заегийн газрын гишүүн батална.

/Энэ хэсэгт 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хууль, 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмэлт, 2012 оны 8 дугаар сарын

17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

11.7.Гадаад улсад хөдөлмөр эрхэлж, төдөрхөй мэргэжлийн үр чадвар эзэмшсэн иргэний хүсэлт, нотлох баримт бичгийг үндэслэн мэргэжлийн үр чадварыг нь хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүний эрх олгосон байгууллага үнэлж, баталгаажуулна:

/Энэ хэсэгт 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хууль, 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмэлт, 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

11.8.Ялтан, хугацаат цэргийн алба хаагчид зориулан хөдөлмөр эрхлэлтийн сургалтын төслийг хэрэгжүүлж болно.

12 дугаар зүйл. Малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих

/Энэ зүйлийн гарчигт 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

12.1. Малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих арга хэмжээ нь иргэний ганцаараа болон бусадтай хамтран аж ахуй эрхлэх санаачилгыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамруулах, жижиг зээл, санхүүгийн дэмжлэг, бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлэх зэрэг арга хэрэгслээр дэмжин туслах хэлбэртэй байна.

/Энэ хэсэгт 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

12.2. Малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих зориулалттай жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох бөгөөд уг сангаас олгох жижиг зээлийг банкаар дамжуулан олгоно.

/Энэ хэсэгт 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

12.3. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчид таван сая хүртэл, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнд арван сая хүртэл төгрөгийн зээлийг 2 жил хүртэл хугацаагаар олгоно.

/Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

12.4. Ажил олоход хүндрэлтэй иргэн материал, түүхий эд, үр, бордоо, мал, тэжээвэр амьтан, тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл

зэргийг худалдан авахад зориулж жижиг зээл авсан бол зээлийн хүүгийн төлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нөхөн төлнө.

/Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

12.5.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас энэ хуулийн 12.2-т заасны дагуу олгож байгаа зээлийн хүүгийн хэмжээ нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн мөнгөн хөрөнгийг байршуулсан банкны зээлийн хүүгийн доод түвшингээс бага байна.

12.6.Энэ хуулийн 12.2-т заасны дагуу олгож байгаа жижиг зээлд батлан даалт гаргаж болно.

/Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

12.7.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам, жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн хэмжээг Засгийн газар тогтооно.

/Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

12.8.Бизнес инкубацийн үйлчилгээг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ:

12.8.1.бизнесийн санаа олсон иргэнийг аж ахуй эрхлэх сургалтад хамруулах, төсөл боловсруулахад нь туслах, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;

12.8.2.бизнесийн төсөл боловсруулж, шалгарсан иргэнд шаардлагатай тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн байр түрээслүүлэх, тодорхой хугацаагаар түрээсийн хөнгөлөлт үзүүлэх;

12.8.3.бизнесийн мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, түншлэлийн харилцаа холбоо тогтооход дэмжлэг үзүүлэх;

12.8.4.энэ хуулийн 12.4-т заасан зээл олгох, хөнгөлөлт үзүүлэх, бичил үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих;

/Энэ заалтад 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан/

12.8.5.бусад.

12.9.Гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэн ажлын байр бий болговол түүнд бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлж, энэ хуулийн 12.3, 12.4-т заасан зээл, хөнгөлөлт үзүүлж болно.

13 дугаар зүйл.Ажил олгогчийг дэмжих

13.1.Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ нь ажил олоход хүндрэлтэй иргэнийг ажиллуулахтай холбоотой гарсан зардлыг ажил олгогчид бүрэн болон хэсэгчлэн нөхөн төлөх, ажил олгогчийн бий болгосон ажлын байранд тухайн иргэнийг тогтвортой ажиллахыг урамшуулах зорилго бүхий санхүүгийн дэмжлэгийн хэлбэрээр хэрэгжинэ.

13.2.Ажилгүйдлийн даатгалын сангаас тодорхой нөхцөл, шаардлагыг

хангасан ажил олгогчид ажлын байр хадгалах зорилгоор санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

13.3.Энэ хуулийн 13.2-т заасан санхүүгийн дэмжлэг олгох нөхцөл, шаардлагыг Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулиар тогтооно.

13.4.Гэрээний үндсэн дээр бусдаар малаа маллуулж байгаа мал бүхий иргэнийг энэ хуулийн 13.1-д заасан ажил олгогчид хамааруулна.

14 дүгээр зүйл.Нийтийг хамарсан ажил зохион байгуулах

14.1.Нийтийг хамарсан ажлыг ажилгүй иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн болон ажилгүй иргэнийг түр хугацаагаар ажиллуулах, орлого нэмэгдүүлэх төрөл бүрийн арга хэмжээний хэлбэрээр зохион байгуулна.

14.2.Нийтийг хамарсан ажлын хөтөлбөрийг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага орон нутгийн нөөц бололцоо, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсруулж, нутгийн захиргааны байгууллага болон аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулна.

/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

14.3.Байгалийн гамшиг, давагдашгүй хүчний шинжтэй бусад нөхцөл байдлын улмаас учирсан хор уршгийг арилгах, нөхөн сэргээх зорилгоор аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагаас нийтийг хамарсан ажлын түр хөтөлбөр хэрэгжүүлж болно.

/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

14.4.Нийтийг хамарсан ажлын хөлс, тухайн ажлыг гүйцэтгэхтэй холбоотой хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас, бусад зардлыг орон нутгийн төсвөөс болон аж ахуйн нэгж, байгууллага гаргана.

14.5.Нийтийг хамарсан ажлын нэг цагийн хөлс, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлын хэмжээг ажлын онцлогийг харгалзан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

14.6.Нийтийг хамарсан ажлын нэг цагийн хөлс нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байна.

15 дугаар зүйл.Ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

15.1.Ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор энэ хуульд зааснаас гадна дараах дэмжлэг үзүүлнэ:

15.1.1.Ажил олоход хүндрэлтэй иргэнд хөдөлмөр эрхлэлтийн

сургалтад хамрагдах хугацаанд нь хоол, унааны зардлын хөнгөлөлт үзүүлж, уг зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэх;

15.1.2.хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан иргэнийг үйлдвэрлэл дээрээ дадлагажуулан үндсэн ажилтнаар нэг жилээс доошгүй хугацаагаар үргэлжлүүлэн ажиллуулж байгаа ажил олгогчид дадлагын хугацааны сургалтын зардлыг нөхөн олгож, нэг жилийн цалин хөлстэй тэнцэх хэмжээний санхүүгийн дэмжлэгийг нэг удаа олгох;

/Энэ заалтад 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

15.1.3.ажил-олоход хүндрэлтэй иргэн, хувиараа болон өрхийн аж ахуйн хэлбэрээр хөдөлмөр эрхлэх бол түүнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нэг сая хүртэл төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг нэг удаа олгох;

/Энэ заалтыг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

15.1.4.хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 6 сараас дээш хугацаагаар ажилгүй байгаа иргэнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг нэг удаа олгох;

15.1.5.хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан иргэнийг ажлын байраар хангаж, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх талаар тодорхой санаачилга гаргаж, үр дүнд хүрсэн ажил олгогчийг тусгай болзлын дагуу Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл шалгаруулж, урамшуулах.

15.2.Малгүй болон цөөн малтай иргэнийг 12 сараас доошгүй хугацаагаар туслах малчнаар ажиллуулан, мал маллах арга ажиллагаанд сургаж, малжуулсан малчинд тухайн иргэнд төлсөн хөдөлмөрийн хөлсний хэмжээг нь харгалзан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нэг сая хүртэл төгрөгийн санхүүгийн дэмжлэг нэг удаа үзүүлж болно.

/Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

15.3.Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага, хөдөлмөрийн бирж нь ажилд зуучилсан ажил олоход хүндрэлтэй иргэн, түүний ажил олгогчтой гэрээ байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

/Энэ хэсэгт 2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЭЛ

16 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн тогтолцоо

16.1. Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн тогтолцоо нь хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн сүлжээ, түүний программын болон техникийн хангамж, мэдээлэл цуглуулах, түгээх үйлчилгээ, мэдээллийн эх үүсвэрээс бүрдэнэ.

17 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан

17.1. Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь ажиллах хүчний талаарх мэдээ, мэдээлэл, ажлын байрны болон ажил хайгч, ажилгүй иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэгч болон уг үйл ажиллагаанд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай холбогдсон бүртгэл, мэдээллийг агуулна.

18 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сүлжээ

18.1. Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сүлжээ нь хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл цуглуулах, боловсруулах, хадгалах, хамгаалах, түүнээс мэдээлэл түгээх, цахим хуудас, түүнд суурилсан программ болон техник хангамж, мэдээллийн бусад арга хэрэгслээс бүрдэнэ.

19 дүгээр зүйл. Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сүлжээний үйл ажиллагааг хариуцах байгууллага

19.1. Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээ, мэдээллийг нэгтгэх, боловсруулах, хадгалах, хамгаалах болон хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сүлжээний үйл ажиллагааг мэргэжил, арга зүй, технологийн хувьд хариуцаж, хэвийн ажиллуулах чиг үүргийг энэ хуулийн 29.5-д заасан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

19.2. Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сүлжээний үйл ажиллагааны болон аюулгүй байдал, хамгаалалтын журам, стандартыг тогтоох, хяналт тавих, программ болон техник хангамжийг хөгжүүлэх чиг үүргийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

/Энэ хэсэгт 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

20 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн эх үүсвэр ба бүртгэл

20.1.Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн эх үүсвэр нь иргэн, ажил олгогч, түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэгч болон уг үйл ажиллагаанд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байна.

20.2.Ажил олгогч нь ажиллах хүч болон ажлын байрны холбогдолтой мэдээллийг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн биржид гарган өгөх, эсхүл түүний бүртгэл, мэдээллийн сүлжээнд бүртгүүлж, мэдээллээ байршуулах, мэдээлэлд оруулж байгаа өөрчлөлтийг тухай бүрд нь хийж байх үүрэгтэй бөгөөд ажил олгогч нь нийт ажлын байрныхаа талаарх мэдээллийг оны эхэнд нэг удаа, шинээр бий болсон болон байхгүй болсон ажлын байрны талаарх мэдээллийг улирал тутам, сул чөлөөтэй ажлын байрны талаарх мэдээллийг тухай бүр нь энэ хуулийн 20.7-д заасан маягтын дагуу харьяалах аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн ажилтан, хөдөлмөрийн биржид гаргаж өгнө.

20.3.Ажил олгогч энэ хуулийн 20.2-т заасан ажлын байрны талаарх мэдээллээ үнэ төлбөргүй өгнө.

20.4.Иргэн өөрөө интернэтийн орчинд болон хөдөлмөрийн биржид очиж мэдээллийн санд бүртгүүлж, мэдээллээ байршуулах ба хэрэгцээт мэдээллээ олж авч болно.

20.5.Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэгч болон уг үйл ажиллагаанд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын болон ажил олоход хүндрэлтэй иргэний талаарх бүртгэл, мэдээллийг нэгтгэж, хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд оруулна.

/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

20.6.Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь улсын бүртгэл, статистик, татвар, нийгмийн даатгал, халамжийн асуудал эрхэлсэн холбогдох байгууллагатай тайлан, мэдээ, мэдээлэл, холбогдох баримт бичгийг харилцан үнэ төлбөргүй солилцоно.

20.7.Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн маягтыг статистикийн төв байгууллагын даргын зөвшөөрснөөр хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ТАВДУГААР БҮЛЭГ

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САН

21 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

21.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлэх

зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг байгуулна.

21.2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар тогтооно.

22 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогын эх үүсвэр

22.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ:

22.1.1.улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө;

22.1.2.орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө;

22.1.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү;

22.1.4.гадаадын иргэнийг гэрээгээр ажиллуулсан ажил олгогчийн төлөх ажлын байрны төлбөр;

22.1.5.гадаад улс, олон улсын байгууллагаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор олгосон зээл;

22.1.6.гадаад улс, олон улсын байгууллага, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдээс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд оруулсан хандив, тусламж;

22.1.7.хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр;

22.1.8.жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдсөн хөрөнгө;

/Энэ заалтыг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмсэн/

22.1.9.бусад эх үүсвэр.

/Энэ заалтын дугаарт 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

22.2.Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого бүрдүүлэх үйл ажиллагааг Нийгмийн даатгалын тухай хуулиар зохицуулна.

23 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарцуулалт

23.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг дор дурдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулна:

23.1.1.ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;

23.1.2.ажилд зуучлах;

23.1.3.хөдөлмөрт бэлтгэх;

23.1.4.хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах;

23.1.5.ажил олгогчийг дэмжих;

23.1.6.нийтийг хамарсан ажил зохион байгуулах;

23.1.7.малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих;

/Энэ хэсэгт 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

23.1.8.ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;

23.1.9.хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сүлжээг бүрдүүлэх, ажиллуулах, шинэчлэх;

23.1.10.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон салбар зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих, хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, үндсэн эрхийн хэрэгжилтийг хянах, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, сурталчилгаа явуулах, гарын авлага, хэвлэмэл материал бэлтгэж хэвлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлгэх;

23.1.11.хууль тогтоомжид заасан, түүнчлэн Засгийн газрын болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн шийдвэрээр тодорхойлсон бусад хөтөлбөр, төслийг санхүүжүүлэх.

~~23.1.12.сумын иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зориулалтаар сум хөгжүүлэх санд хөрөнгө хуваарилах.~~

/Энэ заалтыг 2012 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн ба 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

23.1.13.мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих зориулалтаар мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд хөрөнгө хуваарилах.

/Энэ заалтыг 2014 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн бөгөөд үүнийг 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/

23.2.Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлогоос төвлөрүүлсэн хөрөнгийг Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу зарцуулна.

23.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

~~23.4.Энэ хуулийн 23.1.12-т заасан хөрөнгийн хэмжээг Засгийн газар төгтөөнө.~~

/Энэ хэсгийг 2012 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн ба 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

23.5.Энэ хуулийн 22.1.7-д заасан төлбөрийг тухайн орлогыг бүрдүүлсэн орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулна.

/Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмсэн/
24 дүгээр зүйл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого, зарлагын төсөв

24.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд улсын төсвөөс жил бүр хөрөнгө хуваарилна.

24.2. */Энэ хэсгийг 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

24.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд тухайн жилд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг ажилгүйдлийн түвшин, ажиллах хүчний оролцооны болон хөдөлмөр эрхлэлтийн түвшинг харгалзан Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал батална.

24.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тухайн жилийн төсвийн хуваарийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн саналыг харгалзан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

24.5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн батлагдсан төсвийг аймаг, нийслэл, дүүрэгт хуваарилахдаа хүн амын тоо, ажилгүйдэл, ядуурлын түвшин, хамрагдах хүний тоо зэргийг үндэслэнэ.

25 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тайлан, тэнцэл гаргах

25.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого, зарлагын тайланг дор дурдсан хугацаанд гаргаж ирүүлэх:

25.1.1. улирлын тайланг дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан аймгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад дараа улирлын эхний сарын 5-ны өдрийн дотор, аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад;

/Энэ заалтад 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт, 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан/

25.1.2. хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улирлын нэгдсэн тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, нийгмийн даатгалын төв байгууллагад.

/Энэ заалтад 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

26 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн бүртгэл, тайлангийн маяг

26.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн бүртгэл, тайлангийн маягтын загварыг санхүү, төсвийн болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

27 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцоо

27.1.Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцоо нь хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн ажилтан /хөдөлмөрийн алба/, хөдөлмөрийн биржээс бүрдэнэ.

/Энэ хэсэгт 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт, 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

27.2.Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл нь нийгмийн зөвшилцлийн байгууллага байна.

27.3.Хөдөлмөрийн бирж нь хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний байгууллага байх бөгөөд хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сүлжээнд холбогдсон төрийн, төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагаас бүрдэнэ.

28 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл

28.1.Засгийн газар, ажил олгогч болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгууллагын төлөөлөл бүхий Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийг байгуулж, ажиллуулна.

28.2.Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болонаймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн энэ хуулийн 28.1-д заасан гурван талын төлөөлөгчдийн тоо адил байна.

28.3.Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн дүрмийг ажил олгогч болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгууллагатай зөвшилцөн Засгийн газар, хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрмийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл /цаашид “Үндэсний зөвлөл” гэх/ батална.

28.4.Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг талуудын санал болгосноор Ерөнхий сайд 4 жилийн хугацаагаар батлах бөгөөд Үндэсний зөвлөл дараах бүрэлдэхүүнтэй байна:

28.4.1.Засгийн газрыг төлөөлж хөдөлмөрийн, санхүү, төсвийн болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тус бүр нэг хүн;

28.4.2.ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний үйлдвэрчний эвлэлийн байгууллагаас гурван хүн;

28.4.3.ажил олгогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгууллагаас гурван хүн.

28.5.Үндэсний зөвлөлийн дарга нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

28.6.Үндэсний зөвлөлийн орлогч даргыг энэ хуулийн 28.1-д заасан гурван тал зөвшилцөж, аль нэг талын төлөөлөгчөөс хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар батална.

28.7.Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн гишүүнээр хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын дарга, ажилтныг оруулахыг хориглоно.

28.8.Үндэсний зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

28.8.1.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих;

28.8.2.төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого, стратеги, хөтөлбөрийн талаар санал боловсруулах, хэлэлцэх, энэ хуулийн 6.3.1-6.3.4, 6.3.6-д заасан төсөл, хөтөлбөрийг хэлэлцэн батлах;

28.8.3.хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тайлан, мэдээлэл болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд хийсэн хөндлөнгийн байгууллагын хяналт, шинжилгээ, үнэлгээний тайланг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах, шаардлагатай асуудлыг холбогдох байгууллагад оруулж шийдвэрлүүлэх;

28.8.4.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийг хуваарилах асуудлыг хэлэлцэж, зөвлөмж гаргах, тус сангийн орлого, зарлагын байдалд хяналт тавих;

28.8.5.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хагас болон бүтэн жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах;

28.8.6.хөдөлмөр эрхлэлтийн болон ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц, үр дүнд хийсэн хяналт, шинжилгээний дүнг хэлэлцэх, түүнд үндэслэн хууль тогтоомж, хөтөлбөрийг боловсронгуй болгох талаар зөвлөмж гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх;

28.8.7.гадаадын иргэнийг гэрээгээр ажиллуулсан ажил олгогчийн төлөх ажлын байрны төлбөрийн хэмжээг тогтоох, тухайн жилд авах гадаадын мэргэжилтэй ажилчдын хэрэгцээг тодорхойлох асуудлаар

зөвлөмж гаргаж, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

28.9.Үндэсний зөвлөлийн гишүүдэд ажлын оролцоог харгалзан улирал тутам урамшуулал олгож болох бөгөөд уг урамшууллын хэмжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

29 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага

29.1./Энэ хэсгийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

29.2./Энэ хэсэгт 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ хэсгийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

29.3.Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын даргыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө.

/Энэ хэсгийг 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

29.4.Сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтныг аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

/Энэ хэсгийг 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

29.5.Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд Хөдөлмөрийн төв бирж ажиллана.

/Энэ хэсэгт 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

/Энэ хэсгийг 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

29.6.аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага нь улсын төсвөөс санхүүжинэ.

/Энэ хэсэгт 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт, 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан/

29.7.аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагын дүрмийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

/Энэ хэсэгт 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт,

2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан/

29.8./Энэ хэсгийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

29.9.Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага энэ хуульд зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

29.9.1.энэ хуулийн 22.1.2-т заасан хөрөнгийг аймаг, нийслэл, дүүргийн төсөвт жил бүр тусгуулах талаар санал боловсруулах;

29.9.2.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих;

29.9.3.харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийт ажлын байр, шинээр бий болсон, байхгүй болсон болон сул чөлөөтэй ажлын байрны талаарх мэдээллийг ажил олгогчоос гаргуулан авах;

29.9.4.ажил хайгчийг тохирох ажлын байранд зуучлах;

29.9.5.энэ хуулийн 9.2-т заасан санал, дүгнэлт гаргах, хөдөлмөрийн хувийн биржийн үйл ажиллагаанд хяналт тавих;

29.9.6.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомжийг байгууллага, иргэнд сурталчлах;

29.9.7.аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд ажил олоход хүндрэлтэй иргэдийн бүртгэл, хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээний судалгаа гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх;

29.9.8.ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх;

29.9.9.хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, ажиллуулах, шинэчлэх;

/Энэ заалтыг 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/

29.9.10.мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх;

/Энэ заалтыг 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/

29.9.11.жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль тогтоомж, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийг дэмжих арга хэмжээний хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх;

/Энэ заалтыг 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/

29.9.12.хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад сурталчлах, хяналт тавих.

/Энэ заалтыг 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/

29.9.13.энэ хуулийн 22.1.7-д заасан төлбөрийг төвлөрүүлэх, зориулалтын дагуу зарцуулах, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах;

/Энэ заалтыг 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн/

29.9.14.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

/Энэ заалтын дугаарт 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хууль, 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

29.10.хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуульд зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

29.10.1.хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн урт болон богино хугацааны төлөв байдлыг судлах, хэтийн тооцоо боловсруулах;

29.10.2.хөдөлмөрийн зах зээлийн талаарх мэдээллээр иргэн, ажил олгогчийг хангах, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, ажилд зуучлах;

29.10.3.хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэний талаарх мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, нийтэд үйлчлэх;

29.10.4.энэ хуулийн 9.2-т заасан санал, дүгнэлт гаргах;

29.10.5.хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сүлжээнд холбогдсон байгууллагыг программ хангамж болон мэргэжил, арга зүй, техникийн удирдлагаар хангаж, мэдээллийн нэгдмэл орчинд үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх;

29.10.6.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

29.11.Хөдөлмөрийн бирж нь энэ хуульд зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

29.11.1.хөдөлмөрийн зах зээлд оролцогчийг бүртгэх, мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх;

29.11.2.ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох;

29.11.3.ажилд зуучлах;

29.11.4.нийт болон сул чөлөөтэй ажлын байр, шинээр бий болсон, байхгүй болсон ажлын байрны, түүнчлэн ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэний зэрэг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулан авч хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулах;

29.11.5.хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах;

29.11.6.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

29.12.Хөдөлмөрийн бирж нь нэг цэгийн үйлчилгээний танхим, техник хэрэгслэлээр хангагдаж, хэрэглэгчид мэдээллийн интернэтийн орчинд ажиллах боломжийг хангасан, зохих мэдлэг, ур чадвар эзэмшсэн үйлчилгээний ажилтантай байх нийтлэг шаардлагыг хангасан байна.

29.13.Сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан /хөдөлмөрийн алба/ нь энэ хуульд зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

/Энэ хэсэгт 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хууль, 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

29.13.1.нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд ажилгүй иргэн, ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй болон ажил олоход хүндрэлтэй иргэн, хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд хамрагдах иргэн болон үйлчилгээ үзүүлэгч, ажил олгогчийн бүртгэлийг хөтөлж, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулах;

29.13.2.нутаг дэвсгэрийн хэмжээнд ажиллах хүчний болон ажлын байрны холбогдолтой мэдээ, мэдээллийг ажил олгогчоос гаргуулан авч, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага, эсхүл хөдөлмөрийн биржид хүргүүлэх;

/Энэ заалтад 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

29.13.3.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдах иргэний хэрэгцээг тодорхойлох;

29.13.4.хөдөлмөрийн зах зээлийн талаарх мэдээллээр иргэн, ажил олгогчийг хангах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомжийг сурталчлах;

29.13.5.хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, мэргэжлийн боловсрол, сургалт, жижиг, дунд үйлдвэрийн талаарх хууль тогтоомж, төсөл, хөтөлбөрийг сурталчлах, хэрэгжилтэд хяналт тавих.

/Энэ заалтыг 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/

29.13.6.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

/Энэ заалтын дугаарт 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

30 дугаар зүйл.Төрийн захиргааны төв байгууллага, Хурлын болон Засаг даргын бүрэн эрх

30.1.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг боловсронгуй болгох, үр дүнг дээшлүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

30.1.1.төрийн бодлогын үндэслэл, чиглэлийг боловсруулж, хууль тогтоомж, дүрэм, журам, төсөл хөтөлбөрийн болон бусад шийдвэрийн төсөлд тусгуулах, шийдвэрлүүлэх, бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэр гаргах;

30.1.2.хууль тогтоомж, дүрэм, журам, төсөл, хөтөлбөрийн болон бусад шийдвэрийн хэрэгжилтийг хангах, хяналт шинжилгээ, үнэлгээ, салбарын хүрээний болон салбар дундын зохицуулалт хийх;

30.1.3.хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний стандарт, нормативыг боловсруулах, батлах, хэрэгжилтэд хяналт тавих.

30.1.4.хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдалд дүн шинжилгээ хийх, чиг хандлагыг тодорхойлох, богино, дунд хугацааны болон хэтийн зорилтыг боловсруулах;

30.1.5.хөдөлмөр эрхлэлтийн байгууллагыг бодлогын удирдамж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих;

30.1.6.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны эх үүсвэр, төсөв, тусгай зориулалтын сан, төсөл, хөтөлбөрийн хөрөнгийн төлөвлөлт, хуваарилалтыг хийх, зарцуулалтад хяналт тавих, үнэлж дүгнэх;

30.1.7.хөдөлмөрийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхижуулах сургалт зохион байгуулах;

30.1.8.хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн хөдөлмөр эрхлэлтийн сургалтын бодлого боловсруулж, хэрэгжилтийг хангах;

30.1.9.Үндэсний зөвлөлийн зөвлөмж, санал, дүгнэлтийг хэлэлцэх, хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх;

30.1.10.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээр уг хөрөнгийг нөхөн төлүүлэх, санхүүжилтийг зогсоох, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

30.1.11.ажилгүйдлийн даатгалын тэтгэмжтэй холбогдсон иргэний санал, гомдлыг судалж шийдвэрлэх;

30.1.12.хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад шаардлагатай мэдээлэл, тооцоо, судалгааг төрийн болон төрийн бус байгууллага, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

30.1.13.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих, хэрэгжилтийг тайлагнах;

/Энэ заалтыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/

30.1.14.хөдөлмөр эрхлэлтийн мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, төлөв байдлын болон ажиллах хүчний ур чадварын хэрэгцээний судалгааг тодорхой давтамжтайгаар хийх, мэргэшсэн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх, хэтийн тооцооллын загвар боловсруулах,

/Энэ заалтыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/

/Энэ заалтад 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

30.1.15./Энэ заалтыг 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

30.1.16.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогыг бүрдүүлэх, хөрөнгийн хуваарилалтын төслийг боловсруулах, батлуулах, хөрөнгийг баталсан хуваарийн дагуу зарцуулах, хяналт тавих, тайлагнах;

/Энэ заалтыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/

30.1.17.аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага, хөдөлмөрийн бирж, гадаадад ажиллах хүч илгээх болон гадаадаас ажиллах хүч авахад зуучлах байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах;

/Энэ заалтыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/

/Энэ заалтад 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

30.1.18.хууль тогтоомжид заасан бусад эрх.

/Энэ заалтын дугаарт 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

30.2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

30.2.1.энэ хуулийн 22.1.2-т заасан хөрөнгийг аймаг, нийслэл, дүүргийн төсөвт жил бүр тусган батлах;

30.2.2.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нийтлэг үйлчилгээ, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээ авах;

30.2.3.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтын хэрэгжилтийн талаар тайлан, мэдээллийг сонсох, энэ хуулийн 30.3-т заасан бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй бол Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32.2-т заасан арга хэмжээг авах;

30.2.4.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

30.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

30.3.1.энэ хуулийн 22.1.2-т заасан хөрөнгийг аймаг, нийслэл, дүүргийн төсөвт тусгуулах талаар жил бүр санал боловсруулах;

30.3.2.хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг уялдуулан зохион байгуулах, хянах;

30.3.3.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдах ажил олоход хүндрэлтэй иргэдийн талаарх мэдээлэл, судалгааг гаргаж, хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээг тодорхойлох, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамруулах;

30.3.4.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

31 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд аж ахуйн нэгж, байгууллага, иргэний оролцоо, эрх, үүрэг

31.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд оролцогч иргэн энэ хуульд зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй байна:

31.1.1.хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд хамрагдах хүсэлтээ сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн ажилтан, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн биржид гаргаж бүртгүүлэх, бүртгүүлсний дараа аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, ажилтан, хөдөлмөрийн биржтэй холбогдох журмын дагуу идэвхтэй харилцаж, хамтран ажиллах;

31.1.2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас энэ хуульд заасны дагуу олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, үр дүнгийн болон санхүүгийн тайланг сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад заасан хугацаанд ирүүлэх;

/Энэ заалтад 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

31.1.3.аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага болон хөдөлмөрийн биржээс санал болгосон ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээнээс сонголт хийх.

/Энэ заалтад 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

31.2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд оролцогч аж ахуйн нэгж, байгууллага нь энэ хуульд зааснаас гадна дараах үүрэгтэй байна:

31.2.1.ажил олгогч нь нийт болон сул чөлөөтэй ажлын байр, шинээр бий болсон болон байхгүй болсон ажлын байрны талаарх мэдээллийг энэ хуулийн 20.7-д заасан маягтын дагуу тогтоосон хугацаанд, ажиллагчдынхаа ур чадварыг хөгжүүлэх сургалтын хэрэгцээг

тухай бүр аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад ирүүлэх;

/Энэ заалтад 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

31.2.2.Хөдөлмөрийн тухай хуулийн 40.5-д заасан нөхцөлөөр ажилтнуудыг бөөнөөр халах, цомхотгох тохиолдолд энэ тухайгаа харьяалах аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад нэг сараас доошгүй хугацааны өмнө мэдэгдэх;

/Энэ заалтад 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

31.2.3.сул чөлөөтэй ажлын байранд аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага, хөдөлмөрийн биржээс санал болгосон иргэнийг ажилд авсан бол шийдвэр гарснаас хойш ажлын 5 өдрийн дотор тухайн байгууллагад эргэж мэдэгдэх;

/Энэ заалтад 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

31.2.4.Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүний хөдөлмөр эрхлэлтийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай тайлан, мэдээг аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад улирал тутам гаргаж ирүүлэх;

/Энэ заалтад 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

31.2.5.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, үр дүнгийн болон санхүүгийн тайланг сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад тогтоосон хугацаанд ирүүлэх;

/Энэ заалтад 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

31.2.6.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

31.3.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага болон хөдөлмөрийн биржээс санал болгосон иргэнийг ажлын байрны шаардлагад нийцүүлэн сонгож ажилд авах, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээнд өөрийн сонголтын дагуу оролцох эрхтэй.

/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

31.4.Хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан иргэний талаарх мэдээллийг холбогдох байгууллагаас тухай бүр харьяалах аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр

эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад мэдэгдэж, уг байгууллага иргэний хүсэлтийн дагуу бүртгэж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамруулна.

/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

32 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт

32.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд дараах эрх бүхий байгууллага, албан тушаалтан хяналт тавина:

32.1.1.Улсын Их Хурал, Засгийн газар, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд;

32.1.2.мэргэжлийн хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу мэргэжлийн хяналтын байгууллага.

32.2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд хөндлөнгийн байгууллагаар жил бүр хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлгэнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

33 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

33.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд дараах захиргааны шийтгэлийг хөдөлмөрийн улсын байцаагч буюу шүүгч ногдуулна:

33.1.1.энэ хуулийн 4.1.1-д заасныг зөрчсөн албан тушаалтныг 50000-250000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 500000-1000000 төгрөгөөр торгох;

33.1.2.энэ хуулийн 9.2, 9.4.-т заасныг зөрчсөн бол хохирлыг нөхөн төлүүлж, гэм буруутай албан тушаалтныг 100000-250000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 500000-1000000 төгрөгөөр торгох;

33.1.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, эсхүл хууль бусаар ашигласан бол хохирлыг нөхөн төлүүлж, албан тушаалтныг 500000-1000000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 1000000-2500000 төгрөгөөр торгох;

33.1.4.энэ хуулийн 20.2-т заасан үүргийг биелүүлээгүй албан тушаалтныг 250000-500000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 1000000-1500000 мянган төгрөгөөр торгох;

33.1.5.энэ хуулийн 31.2.2-д заасан үүргийг биелүүлээгүй албан тушаалтныг 50000-250000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 500000-1500000 төгрөгөөр торгох.

33 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

33.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт

хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

33.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулахаар заасан бөгөөд үүнийг 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/

34 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

34.1.Энэ хуулийг 2011 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

34.2.Энэ хуулийн 13.2 дахь хэсгийг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 159

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 бодлогын баримт бичгийн 2.2.1-д заасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.3-г заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг 1 дүгээр хавсралт, “Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг Засгийн газрын 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 27 дугаар тогтоолын 26 дугаар хавсралт болгон 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний зөвлөл (С.Чинзориг)-д даалгасугай.

3. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх болон бусад шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг холбогдох сайд нарт үүрэг болгосугай.

4. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүжүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд

С.ЧИНЗОРИГ

Засгийн газрын 2019 оны 159 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

АЖИЛГҮЙДЭЛ, ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Гурван тулгуурт хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зорилтууд нь Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр (цаашид “Хөтөлбөр” гэх)-ийг боловсруулах үндэслэл болно.

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-д тусгагдсан “Ядуурлын бүх төрлийг эцэс болгоно”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэх мэдлэг, ур чадвартай залуу үеийг төлөвшүүлж, ажилгүйдлийн түвшинг бууруулна” гэсэн зорилтууд, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Гэр бүлийг дэмжин тэтгэх, иргэн бүр эрүүл, боловсролтой, ажилтай, орлоготой байх нөхцөл бүрдүүлэхэд бүх талаар анхаарч, ажилгүйдэл, ядуурлыг бууруулан, хүн амын дундаж орлоготой хэсгийг нэмэгдүүлж, иргэдийнхээ амьжиргааг сайжруулах” гэсэн зорилтууд, Гурван тулгуурт хөгжлийн бодлогод дэвшүүлсэн 22-27 дугаар зорилтууд ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглэж байна.

Монгол Улсад сүүлийн жилүүдэд ядуурлын түвшин нэмэгдэх хандлагатай байгаа нь Үндэсний статистикийн хорооноос хийсэн судалгааны дүнгээс харагдаж байгаа бөгөөд ядуурлын түвшин 2014 онд 21.6 хувь байсан бол 2016 онд 29.6 хувь болж, 8 пунктээр өссөн байна.

Ядуурлын түвшингээс дээгүүр орлоготой байгаа иргэдийн нэг хүнд ногдох сарын дундаж хэрэглээ дунджаар 290,0 мянган төгрөг, уг шугамнаас доогуур орлоготой байгаа иргэдэд 108,0 мянган төгрөг байна. Ядуурлын түвшингээс доош буюу сард 146,0 мянган төгрөгөөс бага хэрэглээний зардалтай иргэдийн тоо 634 мянгаас 907.5 мянга болж нэмэгдсэн байна.

Иргэдийн хэрэглээ буурч, ядуурал нэмэгдэхэд нөлөөлж байгаа хүчин зүйлсийн нэг болох хөдөлмөр эрхлэлтийн байдлыг авч үзэхэд 2014-2017 онд ажиллах хүчний оролцооны түвшин 62.1-ээс 61.1 хувь, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 57.2-оос 55.8 хувь болж буурч, ажилгүйдлийн түвшин 7.9-өөс 8.8 хувь болж нэмэгджээ. 2018 оны IV улирлын байдлаар ажилгүйдлийн түвшин 6.9 хувь болж буурсан ч нийт ажилгүй иргэдийн тоонд төдийлөн өөрчлөлт орохгүй байна.

Ядуурлын шалтгаан нь иргэдийн мэдлэг, боловсрол, ур чадвар, хөдөлмөрийн хандлагын дутагдалтай байдал, эрүүл мэнд, амьдралын

нөхцөл боломж муу зэрэг олон шалтгаанаас үүдэлтэй байгааг харгалзан ядуурлын түвшингээс доогуур орлоготой өрх, иргэдийн амьжиргааны нөхцөл байдал, эрэлт хэрэгцээ, чадавх боломжид тохирсон ажилгүйдлийг бууруулах, ядуурлаас гаргахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

2.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь зарчмыг баримтална:

2.1.1 эдийн засаг, нийгмийн хөгжил, төсөв, хөрөнгө оруулалт, татвар, зээлийн болон бүс орон нутаг, салбарын бодлогуудтай уялдсан байх;

2.1.2. нөөц бололцоонд тулгуурласан, судалгаа шинжилгээнд үндэслэсэн байх;

2.1.3. иргэдийн хөдөлмөрлөх тэгш эрх, адил боломж, олон нийтийн оролцоог хангасан байх;

2.1.4. төрийн болон хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих;

2.1.5. хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ нь хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн, хүртээмжтэй, чанартай, нээлттэй, ил тод байх.

Гурав. Хөтөлбөрийн зорилго

3.1. Хөтөлбөрийн зорилго нь Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Гурван тулгуурт хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зорилтуудыг хангах хүрээнд салбар дундын уялдаатай бодлого, үйл ажиллагааг дэмжиж, зорилтот бүлэг, ядуурлын түвшин өндөр бүс нутаг, аймгуудын иргэдэд чиглэсэн нийгмийн халамжийн бодлого хэрэгжүүлэх, ажлын байрыг хадгалах, шинээр ажлын байр бий болгох замаар иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг ажилтай, орлоготой болгох, төр хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлж, эдийн засгийн үр өгөөжийг зөв, хүртээмжтэй ашиглан зохион байгуулалттайгаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад оршино.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилт

4.1. Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараахь зорилтуудыг хэрэгжүүлнэ:

4.1.1. эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах;

4.1.2. экспортын баримжаатай болон бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг зохион байгуулалттайгаар дэмжиж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах;

4.1.3. эдийн засгийн тэргүүлэх салбаруудын дэмжлэгтэйгээр ажилгүйдэл, ядуурлыг бууруулах;

4.1.4. төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжиж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах;

4.1.5. хүний хөгжил, нийгмийн хамгааллын бодлогоор ажилгүйдэл, ядуурлыг бууруулах.

Тав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.1.1. эдийн засгийн хүртээмжтэй, оролцоотой, шударга тогтолцоог бий болгож, салбар хоорондын бодлогын уялдааг хангах;

5.1.2. бүс нутаг, хөрш орнуудтай эдийн засгийн интеграцид нэгдэх замаар гадаад худалдааны шинэчлэл хийж, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих худалдааны сүлжээг бий болгох;

5.1.3. эдийн засгийн өсөлтийг дэмжсэн нэгдсэн тээвэр, логистик, дэд бүтцийг хөгжүүлж, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчинг бүрдүүлэх;

5.1.4. санхүүгийн тогтвортой байдлыг хангах, төсөв, мөнгөний бодлогыг оновчтой хослуулах замаар инфляцийг зорилтот түвшинд байлгах;

5.1.5. зээлийн хүүг бууруулах, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгож, хэрэгжилтийг эрчимжүүлэх;

5.1.6. татварын орчныг шинэчлэх замаар хөрөнгө оруулалтыг дэмжиж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах;

5.1.7. хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ажиллах хүчин бэлтгэж, хөдөлмөрийн нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх;

5.1.8. төсөв, мөнгөний бодлогоор ажлын байрны шингээлт ихтэй эдийн засгийн салбарыг дэмжиж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх;

5.1.9. хүн ам төвлөрсөн хот суурин газрын ажилгүйдлийг иргэнийг ажлын байраар хангасан аж ахуйн нэгж, байгууллагад эдийн засгийн болон санхүүгийн дэмжлэг, хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх.

5.2. Экспортын баримжаатай болон бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг зохион байгуулалттайгаар дэмжиж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.2.1. үндэсний экспортлогч томоохон компаниудад орон нутгаас түүхий эд, бүтээгдэхүүнийг тогтвортой бэлтгэн нийлүүлэх сүлжээ, тогтолцоог бий болгож, үйл ажиллагааг нь эдийн засгийн болон санхүүгийн дэмжлэг, хөнгөлөлт, урамшууллын бодлогоор дэмжих;

5.2.2. хүнсний үйлдвэрлэлийн түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, үйлдвэрлэх загвар төслүүдийг орон нутгийн онцлогт тулгуурлан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх (сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах, мал нядлах, мах, махан бүтээгдэхүүн, дайвар бүтээгдэхүүн боловсруулах, загасны аж ахуй, зөгийн аж ахуй, төмс, хүнсний ногоо тарих, хадгалах, боловсруулах, хүлэмжийн аж ахуй, жимс, жимсгэнэ боловсруулах, үр тарианы аж ахуй, талх, нарийн боовны цех, цэвэр ус үйлдвэрлэх, ургамлын цай үйлдвэрлэх болон бусад);

5.2.3. хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, үйлдвэрлэх загвар төслүүдийг

орон нутгийн онцлогт тулгуурлан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх (арьс ширний анхан шатны тордолтын цех, арьс ширэн жижиг эдлэлийн цех, ноос, ноолуур бэлтгэн нийлүүлэх, яс боловсруулах цех, сүлжмэлийн цех, эсгий, эсгий эдлэлийн цех, оёдлын цех, мод, модон эдлэлийн цех, ойн хаягдал түүхий эд боловсруулах цех, модны үрсэлгээ, суулгацын аж ахуй, техник, тоног төхөөрөмжийн үйлчилгээний цех, мал бордох болон бусад);

5.2.4. хөтөлбөрийн 5.2.2, 5.2.3-т заасан төслүүдийг бизнесийн загвар төлөвлөгөө, зураг төсвийн дагуу зохион байгуулж, хэрэгжүүлэх;

5.2.5. барилгажуулах, орон сууц барих төсөл хэрэгжүүлж, ядуурлын түвшингээс доогуур болон ойролцоо байгаа иргэдийг аюулгүй, ая тухтай орон сууцтай болоход дэмжлэг үзүүлэх (монгол гэр төсөл, түрээсийн орон сууц төсөл, үйлдвэрлэл үйлчилгээний барилга барих төсөл, инженерийн шугам сүлжээ барих төсөл, барилгын модон эдлэл, мужааны цех болон бусад).

5.3. Эдийн засгийн салбаруудын дэмжлэгтэйгээр ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.3.1. малчид, ногоочдын аж ахуй эрхлэх газрыг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох;

5.3.2. аймаг, сумдын нөхөрлөл, хоршоо, иргэд гэр бүлээрээ ба хувиараа бизнес эрхлэхийг санхүүгийн болон зах зээлтэй холбох, өртгийн сүлжээний кластер байгуулах энэхүү хөтөлбөрийн зохион байгуулалттай ажлын байр бий болгох төслүүдийг улс, аймгийн бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээнд холбох;

5.3.3. үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг шууд худалдаалах төвийг сумдад байгуулж, борлуулалтын сүлжээ бий болгох;

5.3.4. жижиг, дунд үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг дэмжих нийтийн өмчийн хадгалалт борлуулалтын цогцолбор байгуулах;

5.3.5. хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, барилгын салбарын бага, дунд, эцсийн шатны боловсруулалт хийсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслүүдийг хэрэгжүүлэх;

5.3.6. хоршоонд гишүүнээр элсэн ажиллах хүсэлтэй ажилгүй, ядуу өрх, иргэдийн саналыг нэгтгэн бүртгэж, зуучлах үйл ажиллагааг зохион байгуулах;

5.3.7. ядуурал, ажилгүйдлийн мэдрэмжтэй төсөв зохиох арга зүйн сургалт зохион байгуулах;

5.3.8. аялал жуулчлалын дэд бүтэц, өрсөлдөх чадварыг дээшлүүлж, тухайн бүс, орон нутгийн байгаль, нийгэм, эдийн засгийн онцлог, орон нутгийн иргэдэд түшиглэсэн соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэн, малчид, хөдөөгийн ядуу өрхийн ногоон үйлдвэрлэл эрхлэх ур чадварыг дээшлүүлэх, ажлын байр, иргэдийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

5.3.9. байгаль хамгаалах ажилд орон нутгийн иргэдийн оролцоог хангаж, ногоон ажил эрхлэлтийг дэмжин тодорхой эрхэлсэн ажилгүй, бага орлоготой иргэдийн оролцоотой байгалийн нөөцийн менежментийн нөхөрлөл байгуулахад дэмжлэг үзүүлэх;

5.3.10. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг байгаль хамгаалах хоршоо, нөхөрлөл, аж ахуйн нэгжийг дэмжих үйл ажиллагаатай холбох;

5.3.11. компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг томоохон үйлдвэр дагасан жижиг, дунд үйлдвэрийн аж ахуйн нэгжийн хөгжлийг дэмжиж, төрөлжсөн кластераар дамжуулан орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах;

5.3.12. нөхөрлөл, хоршоо, аж ахуйн нэгжид орон нутгийн түгээмэл тархацтай ашигт малтмал, байгалийн дагалдах түүхий эдийг ашиглах хязгаарлагдмал эрхийг зохион байгуулалттай олгох, байгалийн нөөц баялгийг байгаль, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл багатай ашиглах, уул уурхайн нөхөн сэргээлт, байгаль хамгааллын ажилд орон нутгийн иргэд, нөхөрлөл, аж ахуйн нэгжийг оролцуулж, ажлын байрыг нэмэгдүүлэх;

5.3.13. экспортын тасралтгүй, найдвартай үйл ажиллагааг хангах, тээвэр, логистикийн дэд бүтцийг хөгжүүлэх;

5.3.14. хот төлөвлөлт, газар зохион байгуулалтын хөтөлбөр хэрэгжүүлэх.

5.4. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжиж ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.4.1. төрийн нийгмийн хариуцлагын хүрээнд өрхийн аж ахуй, нөхөрлөл, хоршоо, үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг төрийн худалдан авалтаар дэмжих, төрийн үйлчилгээний ажилд ажилгүй, бага орлоготой, ядуурлын түвшингээс доогуур хэрэглээтэй өрхийн гишүүнийг зуучлах ажлыг зохион байгуулах;

5.4.2. компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд аж ахуйн нэгжүүд ажилгүй, бага орлоготой, ядуурлын түвшингээс доогуур хэрэглээтэй өрхийн гишүүнийг ажлын байраар хангах, ажилчдын цалин урамшууллыг өрхийн амьжиргааг хангах түвшинд хүргэх;

5.4.3. хоршооны хариуцлагын хүрээнд хоршооллын хөгжлийн туршилтын хөтөлбөр хэрэгжүүлж, ажилгүй, бага орлоготой иргэдийг хоршооны гишүүнээр элсүүлж, хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд татан оролцуулах;

5.4.4. төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний хэрэгжилтийг урамшуулах системийг хэрэгжүүлэх (зээлийг бодлогоор дэмжих, төрийн худалдан авалтад давуу эрх олгох, хөгжлийн санхүүжилтэд хамруулах, олон нийтэд сурталчлах, нийгмийн хариуцлагатай хоршоо, компанийн өргөмжлөл олгох зэрэг урамшуулал);

5.4.5. нийгмийн хариуцлага өндөр, шилдэг төрийн болон хувийн байгууллага, аж ахуйн нэгжийг олон нийтэд сурталчлан алдаршуулах.

5.5. Хүний хөгжил, нийгмийн хамгааллын бодлогоор ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.5.1. ядуу өрхийн багаас доош боловсролтой, ажил эрхлээгүй өрхийн тэргүүлэгч, насанд хүрсэн гишүүдийг мэргэжилтэй ажилтан бодлогын хүрээнд мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг ахиулах сургалтад хамруулах;

5.5.2. ядуу өрхийн хүүхдийг цэцэрлэг, сургуульд бүрэн хамрагдах, боловсролтой болох боломжоор хангах, мэргэжлийн, дипломын сургалтын тэтгэлэгт хамруулах замаар ядуурлаас ангид боловсролтой, мэдлэгтэй монгол хүнийг бэлтгэхэд анхаарах;

5.5.3. ядуу өрхийн сургуулийн бага ангийн хүүхдийн ном, сурах бичгийн түрээсийн тогтолцоо, эргэлтийн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, хүүхдийн дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлт үзүүлэх, дотуур байранд амьдрах хоол, унааны зардлын тодорхой хувийг улсаас төлөх;

5.5.4. өрхийн гишүүдийг боловсролын үйлчилгээнд хамруулахад холбон зуучлах;

5.5.5. ядуу өрх, иргэдэд хүргэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах зорилгоор жилд нэг удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах, алслагдсан орон нутагт явуулын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх;

5.5.6. ядуу өрхийн хүүхдийн эрх, эрүүл мэндийг бүх шатанд хамгаалах, бага наснаас эрүүл амьдрах зан үйлд төлөвшүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулах;

5.5.7. ядуурлын түвшингээс доогуур хэрэглээ, орлоготой өрх, иргэний хөдөлмөрийн насны гишүүдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь төрөөс хариуцах, эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд шаардлагатай тусламж, үйлчилгээнд хамруулах;

5.5.8. олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бусад төрөл, эрүүл мэнд зэрэг шаардлагатай нийгмийн үйлчилгээнд хамруулахад холбон зуучлах;

5.5.9. өвчлөлтөөс болон донтолтоос хамааралтай ядууралд өртсөн иргэдийг оношилгоо, эмчилгээнд хамруулах, нийгэмшүүлэх, эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүдэд хамрагдахад дэмжлэг үзүүлэх;

5.5.10. ядуурлын түвшингийн хамгийн доогуур хэрэглээтэй нэн ядуу иргэдэд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээг хүртээмжтэй хүргэж, туйлын ядуурлыг бууруулах;

5.5.11. ядуурлын түвшингээс доогуур хэрэглээтэй өрх, иргэдийн эрэлт хэрэгцээ, чадавх, нөхцөл боломжийг нь тодорхойлж, амьжиргааг нь дээшлүүлэх хөгжлийн төлөвлөгөөг өрх бүрд боловсруулж, тэдэнд шаардлагатай хөдөлмөр, нийгмийн халамжийн болон бусад нийгмийн үйлчилгээнд хамруулах;

5.5.12. нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагддаг хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдах, ажил эрхлэх нөхцөлт халамжийн тэтгэмж, хүнс тэжээлийн дэмжлэг, урамшуулал олгох тогтолцоог бий болгох;

5.5.13. ядуурлын түвшингээс дээгүүр хэрэглээтэй боловч ядууралд өртөх эрсдэлтэй хүн амыг ажилд зуучлах, ажлын байрыг нь хадгалах, ур чадварт тулгуурласан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, жижиг зээл олгох, санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг цогц байдлаар хэрэгжүүлэх;

5.5.14. аймаг, сум, хороо, багийн нутаг дэвсгэрийн хэмжээнд ядуу өрх бүрийн амьжиргааг дээшлүүлэх, тэднийг хөгжүүлэх, хамгаалахад чиглэсэн үйл ажиллагааг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хүрээнд зохион байгуулах;

5.5.15. ядуурлын түвшингээс доогуур болон ойролцоо хэрэглээтэй өрхийн сургуулийн насны хүүхдэд дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлт үзүүлэх;

5.5.16. ядуурлын түвшингээс доогуур хэрэглээтэй ядуу иргэн, өрхөд сарын өрхийн хэрэглээний ядуурлын түвшин хүртэлх нэмэлт тэтгэмжийг төрөөс нөхөн олгох, хөдөлмөрийн насны гишүүдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь төрөөс хариуцах;

5.5.17. орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран өрхийн болон хувиараа үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийг нийгмийн даатгалд заавал даатгуулах чиглэлээр сургалт сурталчилгаа хийх, бараа, бүтээгдэхүүнийг борлуулахад дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэх чиглэлээр жижиг зээл, санхүүгийн тусламжид хамруулах.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

6.1. Хөтөлбөрийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

6.1.1. I үе шат: 2019-2021 он хүртэл;

6.1.2. II үе шат: 2022-2024 он хүртэл.

Долоо. Хөтөлбөрийн үр дүн

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

7.1.1. зорилтот бүлгийн ядуу өрх, иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн, орон нутгийн онцлогт тохирсон үйлдвэрлэл, нөхөрлөл, хоршоо, бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлсэн байна;

7.1.2. ядуурлын түвшин өндөр бүс орон нутагт үйлдвэрлэлийн төслүүд хэрэгжүүлэх замаар иргэдэд шинээр ажлын байр бий болгосон байна;

7.1.3. хөтөлбөрт хамрагдсан ядуурлын түвшингээс доогуур орлоготой өрх, иргэдийн орлого нэмэгдэж, ядуурлаас гарсан байна;

7.1.4. хөдөлмөр эрхлэлт, ажлын байр нэмэгдүүлэх болон үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн байна;

7.1.5. ядуурлын түвшингээс доогуур орлоготой ядуу өрх, иргэний хэрэгцээ, нөхцөл байдалд тулгуурлан нөхцөлт нийгмийн хамгааллын тусламж дэмжлэгийг хүргэсэн байна.

Найм. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

8.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт

№	Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин* 2018	Хүрэх түвшин* 2019-2021	Хүрэх түвшин* 2021-2024	Мэдээллийн эх үүсвэр
Зорилт 1							
1.	Нэг хүнд ногдох үндэсний орлого	Үндэсний нийт орлогыг нийт хүн амын тоонд хуваасан мөнгөн дүн	ам.дол	3771.0	4000.0	4500	Үндэсний статистикийн хороо. Үндэсний тооцооллын эмхэтгэл
2.	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	Хөдөлмөрийн насны ажил эрхэлж байгаа хүн амын хувь	хувь	57.8	60	63	Үндэсний статистикийн хороо. Ажиллах хүчний судалгаа
3.	Ядуурлын түвшин	Үндэсний жишсэн дундаж орлого (хэрэглээгээр тооцсон ядуурлын шугамаас доогуур орлого) хэрэглээтэй өрх, гэр бүлд амьдарч байгаа иргэдийн хувь	хувь	29.6	25.6	20.0	Үндэсний статистикийн хороо. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
Зорилт 2							
1.	Ажиллах хүчний оролцооны түвшин	Эдийн засгийн идэвхтэй хүн амын хөдөлмөрийн насны хүн амд эзлэх хувийн жин	хувь	61.9	63.0	65.0	Үндэсний статистикийн хороо. Ажиллах хүчний судалгаа

2.	Бизнес эрхлэлтийн үзүүлэлт	Өрхийн аж ахуй эрхлэх боломжтой болсон малчин өрхийн эзлэх хувь	хувь	56	60	65	Үндэсний статистикийн хороо. Хөдөлмөр эрхлэлтийн статистик
3.	Шинээр бий болсон ажлын байрны тоо	Үйлдвэрлэлийн төслүүд хэрэгжүүлэх хүрээнд шинээр бий болсон ажлын байрны тоо	тоо	-	4500	10000	ХНХЯ, Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр
Зорилт 3							
1.	Үйлчилгээний салбарын ажил эрхлэлтийн түвшин	Үйлчилгээний ажил эрхэлж байгаа иргэдийн эзлэх хувийн жин	хувь	52.3	55.0	58.0	Үндэсний статистикийн хороо. Ажиллах хүчний судалгаа
Зорилт 4							
1.	Хоршооны үзүүлэлт	Боловсруулах үйлдвэр, барилга, үйлчилгээ эрхэлж байгаа хоршооны эзлэх хувь	хувь	46	50	55	ХХААХҮЯ, Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр
Зорилт 5							
1.	Эрүүл мэндийн харьцангуй үзүүлэлт	Амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь	хувь	31.7	35.0	40.0	Эрүүл мэндийн үзүүлэлт, Эрүүл мэндийн хөгжлийн төв
2.	Суурь болон мэргэжлийн боловсролд хамрагдалтын түвшин	Бүрэн дунд болон мэргэжлийн сургалтад хамрагдсан суралцагчдын эзлэх хувь	хувь	90.1	92.0	93.0	Үндэсний статистикийн хороо. Боловсролын статистик

3	Улсын мөнгөн шилжүүлэг, тусламж, дэмжлэг	Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламжийн үйлчилгээнд хамрагдсан хүн амын эзлэх хувь	хувь	37.7	36.0	35.0	Үндэсний статистикийн хороо.
---	--	--	------	------	------	------	------------------------------

Нийгэм, эдийн засгийн судалгаа

Ес. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр

9.1. Хөтөлбөрийн санхүүжилт нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

9.1.1. улсын болон орон нутгийн төсөв;

9.1.2. олон улсын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

9.1.3. олон улсын хандив, зээл, тусламж;

9.1.4. гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;

9.1.5. дотоодын аж ахуйн нэгж, байгууллагуудын хандив, зээл, тусламж;

9.1.6. Засгийн газрын холбогдох тусгай сангууд;

9.1.7. бусад эх үүсвэр.

Арав. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ

10.1. Төрийн захиргааны байгууллага хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулна.

10.2. Төрийн захиргааны байгууллага хөтөлбөрийн 10.1-д заасан хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг жил бүрийн I дүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.

10.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтэд үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 5 дугаар сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 276

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай. /Энэ тогтоолын хавсралтад Засгийн газрын 2017 оны 64 дүгээр тогтоол, Засгийн газрын 2018 оны 70 дугаар тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт орсон/

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2011 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 375 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгох журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Хөдөлмөрийн сайд

Г.БАЯРСАЙХАН

Засгийн газрын 2016 оны 276 дугаар
тогтоолын хавсралт

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГААС ЖИЖИГ ЗЭЭЛ ОЛГОХ, ТҮҮНД БАТЛАН ДААЛТ ГАРГАХ, ХҮҮГ НӨХӨН ТӨЛӨХ, САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.2, 12.4, 12.6, 12.8.4, 12.9-т заасны дагуу иргэн, аж ахуйн нэгжид жижиг зээл олгох, зээлд батлан даалт гаргах, зээлийн хүүг нөхөн төлөх болон бусад санхүүгийн дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгох, зээлийн хүүгийн төлбөрийг нөхөн төлөх, зээлд батлан даалт гаргах үйл ажиллагаа нь өрхийн болон хувиараа хөдөлмөр эрхлэх, хоршоо, нөхөрлөл байгуулах, бичил аж ахуй эрхлэх, өргөтгөх, ажлын байр шинээр бий болгох, хадгалах боломжийг бүрдүүлэхэд чиглэнэ.

Хоёр. Жижиг зээл олгох

2.1. Жижиг зээлийг бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид олгоно.

Иргэн бусадтай хамтран нөхөрлөл, хоршоо, 8-10 гишүүнтэй бүлэг байгуулж аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжиж болно.

2.2. Энэ журмын 2.1-д заасан иргэдийн бүлэг жижиг зээл олгох, зээлд батлан даалт гаргах үйл ажиллагаанд бүлгийн гишүүдийн хурлаас томилсон эрх бүхий төлөөлөгчөөр дамжуулан оролцоно.

2.3. Иргэн, аж ахуйн нэгж жижиг зээл хүссэн өргөдлөө холбогдох төслийн хамт аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтанд хүргүүлнэ. Төсөл нь дараах шаардлагыг хангасан байх бөгөөд төслийг сонгон шалгаруулах удирдамжийг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. */Энэ заалтын 2 дахь өгүүлбэрийг Засгийн газрын 2018 оны 70 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

2.3.1. хүрэх үр дүн, зорилт тодорхой байх;

2.3.2. ажиллах хүч, техник, тоног төхөөрөмжийн нөөц, боломж болон үйл ажиллагаа явуулах ажлын байр, орчныг сайтар тооцсон байх;

2.3.3. төслийн хүрээнд орон нутгийн онцлог, давуу талд түшиглэн өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл эрхлэхээр төлөвлөсөн байх;

2.3.4. зээлийн мөнгөн дүнгийн 40 болон түүнээс дээш хувьд

хүрэлцэхүйц барьцаа хөрөнгөтэй байх;

2.3.5. төслийн хүрээнд байнгын ажлын байр бий болгож, цаашид хадгалах боломжтой байх.

2.4. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан нь иргэн, аж ахуйн нэгжийн зээл хүссэн өргөдлийг судалж, энэ журмын 2.3-г заасан шаардлагыг хангасан тохиолдолд зээл олгох саналаа тодорхойлолтын хамт банкинд хүргүүлнэ.

2.5. Банкаас жижиг зээл олгох шийдвэр гарсны дараа аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан зээлдэгчтэй ажлын байр бий болгох, өргөтгөх, тогтвортой хадгалах талаар гэрээ байгуулж, зээлдэгчийн санхүүгийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх сургалт, уулзалтыг зохион байгуулах бөгөөд бизнес, аж ахуйн үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллана.

2.6. Жижиг зээл олгох банкиг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сонгон шалгаруулах бөгөөд шалгарсан банктай гэрээ байгуулж, тухайн жилд төсөвлөсөн зээл, зээлийн батлан даалтын хөрөнгийг дансанд нь байршуулна. Жижиг зээл олгох банкинд тавих шаардлага, түүнийг сонгон шалгаруулах удирдамж, банктай байгуулах гэрээний загвар, жижиг зээлийн санхүүжилтийг аймаг, дүүрэгт хуваарилах аргачлалыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. */Энэ заалтад Засгийн газрын 2018 оны 70 дугаар тогтоолоор 2 дахь өгүүлбэрийг нэмсэн/*

Гэрээнд зээлийн хөрөнгийг банкны дансанд байршуулах болон зээл олгох нөхцөл, зээлийн хөрөнгийн үлдэгдлийг эргүүлэн татах хугацаа, хариуцлагыг тодорхой заана.

2.7. Жижиг зээл олгох банк дараах нөхцөлийг хангасан байна:

2.7.1. Монголбанкаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, заавал байлгах нөөцийн шаардлагыг сүүлийн 10 сард хангасан байх бөгөөд энэ талаар Монголбанкны дүгнэлтийг хавсаргасан байна;

2.7.2. зээлийн үйл ажиллагаатай холбоотой аливаа эрсдэлийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн өмнө хариуцах баталгаа гаргасан байх;

2.7.3. жижиг зээлийн хүүгийн хэмжээ тухайн банкны зээлийн хүүгийн доод түвшингээс бага байх бөгөөд гэрээний туршид банкны олгож байгаа хүүгийн доод түвшингээс доогуур байх;

2.7.4. энэ журмын 2.6-д заасан сонгон шалгаруулалтын үеэр тавьсан бусад шаардлагыг хангасан байх.

2.8. Банкнд байршуулсан зээлийн хөрөнгөд аливаа хүү, төлбөр төлөхгүй. */Энэ заалтыг ЗГ-ын 2017 оны 64-р тогтоолоор хүчингүй болсонд тооцсон/*

2.9. Банк иргэн, аж ахуйн нэгжийн зээл авах болон зээлийн батлан даалтад хамрагдах хүсэлтийг ажлын 5 хоногт багтаан судалж шийдвэрлэнэ.

2.10. Жижиг зээлийг 24 сарын хугацаатай олгох бөгөөд үндсэн зээлээс чөлөөлөх хугацаа 6 сар хүртэл байна.

2.11. Жижиг зээлийн хэмжээ иргэнд 10.0 сая хүртэл, иргэдийн бүлэгт нэг гишүүнд 2.0 сая хүртэл, аж ахуйн нэгжид 20.0 сая хүртэл төгрөг байна.

2.12. Зээлийг хуваарийн дагуу төлж, зориулалтын дагуу зарцуулсан, үйл ажиллагаа нь тогтворжиж, гэрээнд заасны дагуу ажлын байр шинээр бий болгож тогтвортой хадгалсан, ажилчдаа нийгмийн даатгалд даатгуулсан зээлдэгч Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дахин зээл авах тохиолдолд зээлийн хугацааг 36 сар, үндсэн зээлээс чөлөөлөх хугацааг 12 сар хүртэл болгон нэмэгдүүлж, зээлийн хүүд хөнгөлөлт үзүүлнэ.

Зээлийн хүүгийн хөнгөлөлтийн хэмжээг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жижиг зээл олгох банкттай тохирч, энэ журмын 2.6-д заасан гэрээнд тусгана.

2.13. Зээлийн хөрөнгөөр өртөг шингэсэн үйлдвэрлэл эрхэлж, нэмүү өртгийн сүлжээнд хамрагдсан зээлдэгч Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дахин зээл авах тохиолдолд зээлийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлж болно.

2.14. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй бөгөөд зээлээ төлж дууссан боловч ашиглалтын явцад зээлийг зориулалтын бусаар ашигласан нь тогтоогдсон тохиолдолд тухайн зээлдэгчийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дахин жижиг зээл авах эрхийг 36 сар хүртэл хугацаагаар хязгаарлана.

Гурав. Зээлд батлан даалт гаргах

3.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.2-т заасан малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих зориулалтаар олгосон жижиг зээлд батлан даалт гаргана.

3.2. Энэ журмын 3.1-д заасан батлан даалтыг банкны зээл олгох бусад шалгуур үзүүлэлтийг хангасан ч барьцаа хөрөнгийн дутагдалтай иргэн, аж ахуй нэгжийн авч байгаа жижиг зээлд гаргах бөгөөд нэг зээлдэгчид гаргах батлан даалтын хэмжээ олгох зээлийн 60 хүртэлх хувьтай тэнцүү байна.

3.3. Зээлийн батлан даалтын хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

3.3.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө;

3.3.2. гадаад, дотоодын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө;

3.3.3. бусад.

3.4. Зээлд батлан даалт гаргах нөхцөл, талуудын эрх, үүрэг, хариуцлага, батлан даалтын төлбөр төлөх, батлан даалтыг түдгэлзүүлэх, зогсоох,

хяналт тавих, тайлагнахтай холбогдсон харилцааг “Батлан даалтын гэрээ”-нд тусган хэрэгжүүлнэ.

“Батлан даалтын гэрээ”-ний загварыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

Дөрөв. Зээлийн хүүг нөхөн төлөх

4.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.4-т заасан ажил олоход хүндрэлтэй иргэн материал, түүхий эд, үр, бордоо, мал, тэжээвэр амьтан, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авахад зориулж жижиг зээл авсан бол хүүгийн төлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нөхөн төлөх бөгөөд ийнхүү төлөхдөө иргэний хүсэлт, зээлийн гэрээ, зээл, зээлийн хүүгийн төлбөрийг банкинд төлсөн баримт болон санхүүгийн бусад баримтыг үндэслэнэ.

4.2. Энэ журмын 4.1-д заасан иргэний хүсэлтийг мөн журмын 2.9-т заасан хугацаанд судалж шийдвэрлэнэ.

4.3. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага (сан) энэ журмын 4.1-д заасан зээлийн хүүгийн төлбөрийн тухайн жилд ногдох хэсгийг жил бүрийн эхний улиралд багтаан зээлдэгчид нөхөн төлнө.

Тав. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх

5.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6.3.7, 28.8.2-т заасны дагуу Засгийн газар болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан төсөл, хөтөлбөрийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг олгоно.

5.2. Энэ журмын 5.1-д заасан санхүүгийн дэмжлэгийн төрөл, хэмжээ, нөхцөл, шаардлагыг тухайн төсөл, хөтөлбөрт, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөх хуваарийг төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэрээнд тус тус тусгана.

5.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.1-д заасан малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнд ганцаараа болон бусадтай хамтран аж ахуй эрхэлхэд зориулж үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн хэмжээ нэг төсөлд 5.0 сая хүртэл төгрөг байх бөгөөд зорилтот бүлгүүдийн онцлогт тохируулж эргэн төлөлтийн хэмжээг 50-иас дээш хувь байхаар Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хүрээнд тогтоон хэрэгжүүлнэ. */Энэ заалтад ЗГ-ын 2017 оны 64-р тогтоолоор өөрчлөлт орсон/*

5.4. Хүн амын зорилтот бүлгийн иргэдэд олгох санхүүгийн дэмжлэг нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төсөлд заасны дагуу санхүүгийн дэмжлэг үзүүлсэн 6 дахь сараас эхэлж 48 хүртэлх сарын хугацаанд сар бүр эргэн төлөх нөхцөлтэй байна. */Энэ заалтад Засгийн газрын 2017 оны 64 дүгээр тогтоол, Засгийн газрын 70 дугаар тогтоолоор тус тус өөрчлөлт орсон/*

5.5. Энэ журмын 5.3-т заасан этгээдийн санхүүгийн дэмжлэгт дахин хамрагдах хугацаа 24 ба түүнээс дээш сарын дараа байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна:

5.5.1. гэрээний хугацаа бүрэн дууссан байх;

5.5.2. санхүүгийн дэмжлэгийн үр дүнг тооцсон байх;

5.5.3. санхүүгийн дэмжлэгийн хөрөнгийг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан болон эргэн төлөлтийг төлж барагдуулсан байх.

5.6. Энэ журмын 5.3-т заасан этгээдийн санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтийг мөн журмын 2.9-т заасан хугацаанд судалж шийдвэрлэнэ.

Зургаа. Хяналт тавих, тайлагнах

6.1. Энэ журамд заасны дагуу жижиг зээл олгосон, батлан даалт гаргасан, хүүг нөхөн төлсөн болон санхүүгийн дэмжлэг үзүүлсэн талаарх мэдээллийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 17.1-д заасан хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд тухай бүр бүртгүүлж, мэдээллийн сан үүсгэнэ. Бүртгэлийн маягтыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

6.2. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага энэ журмын 6.1-д заасан мэдээллийн санд тулгуурлан сар бүр тайлан бэлтгэж дараа сарын 3-ны өдрийн дотор хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь нэгтгэн мөн сарын 10-ны дотор хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Тайлангийн маягтыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална. */Энэ заалтад ЗГ-ын 2017 оны 64-р тогтоолоор өөрчлөлт орсон/*

6.3. Энэ журмын 6.1, 6.2 дахь заалтын хүрээнд банк аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтныг тогтоосон хугацаанд мэдээллээр тогтмол хангаж, хамтарч ажиллана.

6.4. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан улирал тутам нийт зээлдэгчийг хамруулан зээлийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт, шалгалт хийнэ. Хяналт, шалгалтын дүнг тухай бүр хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь нэгтгэн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. */Энэ заалтад ЗГ-ын 2017 оны 64-р тогтоолоор өөрчлөлт орсон/*

6.5. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан банкны жижиг зээл олгох,

зээлд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх үйл ажиллагааны гүйцэтгэл болон банкинд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас байршуулсан хөрөнгийн зарцуулалтад улирал тутам хяналт тавьж ажиллана. Хяналтын тайлан, дүгнэлтийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь нэгтгэн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр хүргүүлнэ. */Энэ заалтад ЗГ-ын 2017 оны 64-р тогтоолоор өөрчлөлт орсон/*

6.6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтэд хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөл болон аймаг, дүүргийн салбар зөвлөл хяналт тавьж ажиллана. Шаардлагатай тохиолдолд уг үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагаар хяналт, шалгалт хийлгэж болно. */Энэ заалтад ЗГ-ын 2017 оны 64-р тогтоолоор нэмэлт орсон/*

6.7. Энэ журмын 6.4-6.6-д заасан хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах үүргийг гэрээ байгуулсан талууд хариуцна.

6.8. Жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь хяналт, шалгалтаар тогтоогдсон бол хөрөнгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

6.9. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хууль бусаар ашигласан гэж буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---ooOoo---



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 12 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 375

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.7, 21.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ыг 1 дүгээр, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгох журам”-ыг 2 дугаар, хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2006 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 159, “Журам батлах тухай” Засгийн газрын 2006 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 166 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

С.БАТБОЛД

Нийгмийн хамгаалал,
хөдөлмөрийн сайд

Т.ГАНДИ

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 375 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ХӨРӨНГИЙГ БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан (цаашид “сан” гэх)-гийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих үйл ажиллагаанд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Сан нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлнэ.

1.3 Сангийн орлогыг төвлөрүүлэх, уг сангаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулан санхүүжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах үүргийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага хариуцна.

1.4. Сан нь мөнгөн хөрөнгийн сан байх бөгөөд аймаг, нийслэл, дүүрэгт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сан (цаашид “дэд сан” гэх)-тай байна.

1.5. Сангийн харилцах дансны 1 болон 2 дугаар гарын үсгийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга болон сан хариуцсан нягтлан бодогч, дэд сангийн харилцах дансны 1 болон 2 дугаар гарын үсгийг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын дарга болон нягтлан бодогч тус тус зурна.

Хоёр. Сангийн орлогын эх үүсвэр

2.1. Сангийн хөрөнгө нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22.1-д заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

2.2. Дэд санд аймаг, нийслэл, дүүргийн төсвөөс жил бүр олгох хөрөнгийн хэмжээ нь тухайн төсвийн орлогын 0,3 хувиас доошгүй байна.

2.3. Орон нутгийн төсвөөс хуваарилах хөрөнгийг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, дэд санд төвлөрүүлнэ.

2.4. Гадаад улс, олон улсын байгууллага, дотоодын болон гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдээ аливаа нөхцөл, болзол тавьсан хөрөнгийн эх үүсвэрийг санд оруулахыг хориглоно.

Гурав. Сангийн зарцуулалт

3.1. Сангийн хөрөнгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23.1-д заасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулна.

3.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22.1.6, 22.1.7-д заасан эх үүсвэрийг дараах зориулалтаар зарцуулна:

3.2.1. гадаад улс, олон улсын байгууллага, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд оруулсан хандив, тусламжийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зориулан олгосон чиглэл, гэрээний дагуу;

3.2.2. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулаагүй ажлын байрны төлбөрөөс төвлөрүүлсэн хөрөнгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасны дагуу.

3.3. Аймаг, нийслэл, дүүргийн төсвөөс дэд санд хуваарилсан хөрөнгийг тухайн орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зориулсан чиглэл, зорилтот арга хэмжээнд зарцуулна.

3.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нийтлэг үйлчилгээний зардлын төрөл, хамрагдах иргэнд тавигдах шалгуурыг хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний зардлын төрөл, хамрагдах иргэнд тавигдах шалгуурыг Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлөөс баталсан төсөл, хөтөлбөрт заасны дагуу тус тус тодорхойлно.

Дөрөв. Сангийн орлого, зарлагын төсөв

4.1. Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага тухайн жилд орон нутагтаа хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, тэдгээрт сан болон дэд сангаас зарцуулах хөрөнгийн хэмжээг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөр хэлэлцүүлэн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад өмнөх оны 7 дугаар сарын 1-ний дотор хүргүүлнэ.

4.2. Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь улсын төсвөөс санд олгох хөрөнгийн хэмжээ болон сангийн орлого, зарлагыг төлөвлөж, жил бүрийн 8 дугаар сарын 1-ний дотор хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.3. Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь санд жил бүр улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээ болон сангийн орлого, зарлагын жилийн төлөвлөгөөг хянан улсын хэмжээгээр нэгтгэж, Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн саналыг тусган жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.4. Санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага сангийн орлого, зарлагыг хянаж жил бүрийн төсвийн төсөлд тусгана.

4.5. Санд тухайн жилд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг ажилгүйдлийн түвшин, ажиллах хүчний оролцооны болон хөдөлмөр эрхлэлтийн түвшинг харгалзан Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал батална.

4.6. Сангийн тухайн жилийн төсвийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас боловсруулж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн саналыг харгалзан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

4.7. Сангийн батлагдсан төсвийг аймаг, нийслэл, дүүрэгт хуваарилахдаа хүн амын тоо, ажилгүйдэл, ядуурлын түвшин, хамрагдах хүний тоо зэргийг үндэслэн аймаг, нийслэл дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын саналыг харгалзан, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална. Энэхүү хуваарийг санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн I дүгээр сард багтаан хүргүүлж байна.

4.8. Сангийн хагас жилийн болон жилийн төсвийн тайланг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлнэ.

Тав. Сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт, тайлан

5.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийг хөтлөх, сангаас олгох хөрөнгийн хэмжээг тодорхойлох, тогтоосон хугацаанд олгох, хяналт тавих, зохион байгуулах үүргийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага гүйцэтгэнэ.

5.2. Сангийн бүртгэл, тайлангийн маягтыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дангаар болон холбогдох асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран баталж мөрдүүлнэ.

5.3. Сангийн зарцуулалтад Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналт, Үндэсний аудитын газар, тэдгээрийн харьяа байгууллагууд тус тус эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.

5.4. Сангийн үйл ажиллагаанд мэргэшсэн байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлд жил бүр танилцуулна.

5.5. Сангийн орлого, зарлагын тайланг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 25.1-д заасан хугацаанд гаргана.

5.6. Сан, дэд сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан гэм буруутай албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага тооцно.



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 05 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар А/123

Улаанбаатар хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

/Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж, санхүүжилт олгох/

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж, санхүүжилт олгох журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хөдөлмөрийн төв бирж /Ц.Энхтуяа/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Д.Ууганбаатар/-т, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С. Жамъянсүрэн/-т тус тус даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Хөдөлмөрийн сайдын 2013 оны 05-р сарын 07-ны өдрийн А/92 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Я.САНЖМЯТАВ

/Хөдөлмөрийн Сайдын 2016-05-06-ны А/116 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт орсныг тусгав./

Хөдөлмөрийн сайдын 2014 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/123 дугаар тушаалын хавсралт

ХӨДӨЛМӨРИЙН ХУВИЙН БИРЖИЙГ БҮРТГЭЖ, САНХҮҮЖИЛТ /ТАРИФААР ТООЦОЖ/ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Ажилд зуучлах үйлчилгээг иргэдэд чанартай, хүртээмжтэй хүргэх зорилгоор хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэх, санхүүжилт олгоход Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Хөдөлмөрийн төв бирж /цаашид төв бирж гэх/, хөдөлмөрийн хувийн бирж /цаашид хувийн бирж гэх/ нь ажилд зуучлах үйлчилгээнд Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/154 тоот тушаалаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний жишиг дүрэм”-ийг баримтална.

1.3. Төв бирж нь хувийн биржийг бүртгэх, санхүүжилт олгох асуудлыг зохион байгуулж, хэрэгжүүлнэ.

Хоёр. Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэх, бүртгэлээс хасах

2.1. Хувийн бирж нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.12 дахь заалтад заасан нийтлэг шаардлагыг хангаж, төв биржид бүртгүүлэхэд дараах бичиг, баримтыг бүрдүүлнэ:

2.1.1. албан хүсэлт;

2.1.2. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

2.1.3. удирдах ажилтан /захирал/-ны иргэний үнэмлэхний хуулбар;

2.1.4. үйл ажиллагааны танилцуулга;

2.1.5. хувийн биржийн хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх журам, бизнес төлөвлөгөө, үйлчилгээнд ашиглах тоног төхөөрөмж, тавилгын жагсаалт;

2.1.6. ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх мэргэшсэн зөвлөх, хөдөлмөр зуучлал хариуцсан ажилтны анкет, диплом, гэрчилгээний хуулбар;

2.2. Төв бирж нь энэхүү журмын 2.1-д заасан бичиг, баримтыг бүрдүүлсэн хувийн биржийг бүртгэж, гэрчилгээ олгоно.

2.3. Бүртгэлийн гэрчилгээний загварыг төв биржийн даргын тушаалаар батална.

2.4. Хувийн биржийг дараах тохиолдолд бүртгэлээс хасна:

2.4.1. хувийн бирж нь өөрөө хүсэлт гаргасан;

2.4.2. хуулийн этгээд татан буугдсан;

2.4.3.бүртгэл мэдээллийн санд хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр нийтэд зарласан ажлын байрны болон ажил хайгчийн зарыг дур мэдэн, зөвшөөрөлгүй бүртгэх, бүрэн бус, бодит бус, худал мэдээлэл оруулах, түүнд үндэслэн санхүүжилт хүссэн;

2.4.4.иргэнийг хуулиар хориглосон үйл ажиллагаатай ажилд зуучилсан болон зуучлахыг оролдсон нь нотлогдсон;

2.4.5.төв биржтэй гэрээ байгуулснаас хойш зургаан сарын хугацаанд хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд нэг ч ажил хайгчийг ажилд зуучлан оруулсан тухай бүртгэгдээгүй бол;

2.4.6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 9.4-т заасныг зөрчсөн буюу хувийн бирж нь ажилд зуучлуулсан иргэнээс шууд ба шууд бус байдлаар үйлчилгээний төлбөр авсан. /Энэ хэсгийг Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/116 дугаар тушаалаар нэмсэн/

2.5. Бүртгэлийн гэрчилгээг 2 жилийн хугацаатай олгоно./Энэ хэсгийг Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/116 дугаар тушаалаар нэмсэн/

2.6. Хувийн биржийн албан хүсэлт, төв биржтэй байгуулсан гэрээний биелэлтийн үнэлгээ, дүгнэлтийг тус тус үндэслэн гэрчилгээний хугацааг 2 жилээр сунгана./Энэ хэсгийг Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/116 дугаар тушаалаар нэмсэн/

Гурав. Хөдөлмөрийн хувийн биржийн үйл ажиллагаа

3.1.Хувийн бирж нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.11 дэх заалтад заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.2.Хувийн бирж нь энэхүү журмын 3.1 дэх хэсэгт заасан чиг үүргийн хүрээнд ажил хайгч иргэн, ажилгүй иргэн, 40- өөс дээш насны ажилгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэнийг ажил олгогчийн эрэлт хэрэгцээг үндэслэн ажилд зуучилна.

3.3.Хувийн бирж нь өөрийн байгууллагын эрхэлж буй хөдөлмөр зуучлалын үйл ажиллагаа болон шууд харьяалах, харьяалагдах аж ахуйн нэгж, байгууллагад ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх зорилгоор ажил хайгчийг ажилд авсан тохиолдолд ажилд зуучлах үйлчилгээнд хамаарахгүй.

3.4 Хувийн биржийн үйл ажиллагаа нь ажил мэргэжил болон эдийн засгийн үйл ажиллагааны салбарын хүрээнд эсхүл иргэн, ажил хайгч хүн амын тодорхой, онцлог бүлгүүдэд дагнасан байж болно.

3.5. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв болон их сургууль, дээд сургуулиудад суралцагсдыг суралцаж байх үеэс нь ажил олгогчтой холбох үйл ажиллагааг зохион байгуулна./Энэ хэсгийг Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/116 дугаар тушаалаар нэмсэн/

Дөрөв. Хөдөлмөрийн төв биржийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1. Энэхүү журмыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төв бирж нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.1.1. хувийн биржийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага, аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, санал, дүгнэлт гаргах;

4.1.2. хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй, татгалзсан тухай үндэслэлийг хууль тогтоомжийн дагуу гаргаж, хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, байгууллагад албан ёсоор хүргүүлэх;

4.1.3. хувийн биржийн үйл ажиллагааг үнэлэх, гэрээг дүгнэх шалгуур үзүүлэлт тогтоох;

4.1.4. хувийн биржтэй хамтран ажиллах гэрээ байгуулах, гэрээг хагас жил, бүтэн жилээр дүгнэх, санхүүжилт олгох;

4.1.5. хувийн биржийг бүртгэсэн болон бүртгэлээс хассан тухай олон нийтэд ил тод мэдээллэх;

4.1.6. эдгээр болон хууль тогтоомжид заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

4.1.7. Хувийн биржийн үйл ажиллагаанд жилд 1 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, шаардлагатай тохиолдолд гэнэтийн шалгалт хийнэ./Энэ хэсгийг Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/116 дугаар тушаалаар нэмсэн/

Тав. Мэдээ, тайлан, санхүүжилт

5.1. Хувийн бирж нь дараах тайлан, мэдээг гаргаж төв биржид тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

5.1.1. Хөдөлмөрийн сайдын 2014 оны А/04 дугаар тушаалаар батлагдсан хөдөлмөрийн зах зээлийн анхан шатны ХЗЗ-1, ХЗЗ-2, ХЗЗ-3, ХЗЗ-7а, ХЗЗ-7б маягтын дагуу сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон гаргаж, мэдээллийн сүлжээгээр болон албан бичгээр тухайн сарын 30-ны дотор;

5.1.2. Үйл ажиллагааны хагас жилийн тайланг 6 дугаар сарын 25-ны өдрөөр тасалбар болгон гаргаж, төв биржид 6 дугаар сарын 30-ны дотор, жилийн тайланг 12 дугаар сарын 15-ны өдрөөр тасалбар болгон гаргаж, 12 дугаар сарын 20-ны дотор;

5.2. Төв бирж нь хувийн биржтэй байгуулсан гэрээнд заасан ажил, үйлчилгээний биелэлтийг хянан баталгаажуулж, санхүүжилтийг тогтоосон тарифаар тооцон сар бүр олгоно.

5.3. Төв биржийг хувийн биржийн үйл ажиллагааг үндэслэлгүй дүгнэх, санхүүжилтыг нотлох баримтгүйгээр олгох, хасах, саатуулахыг хориглоно.

5.4. Энэхүү журмын 3.3-т заасан хувийн биржийн үйл ажиллагаанд санхүүжилт олгохгүй.

5.5. Ажил хайгчийг ажилд зуучлагдан орж тогтвортой ажиллах хугацааг

харгалзан санхүүжилтийг тарифаар тооцон давхардуулахгүйгээр олгоно./ Энэ хэсгийг Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/116 дугаар тушаалаар нэмсэн/

5.6. Төв бирж нь хувийн биржийн үйл ажиллагааны мэдээ, тайланг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад холбогдох байгууллагад тогтмол мэдээлж, тайлагнана./Энэ хэсгийг Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/116 дугаар тушаалаар нэмсэн/

Зургаа. Бусад

6.1. Журмын хэрэгжилт, хувийн биржийн үйлажиллагаанд Хөдөлмөрийн яам, Хөдөлмөрийн төв бирж, холбогдох бусад байгууллагаас хяналт тавих бөгөөд хөндлөнгийн байгууллагаар аудит хийлгэж болно. Энэхүү журмыг зөрчигчдөд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ. /Энэ хэсэгт Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/116 дугаар тушаалаар өөрчлөлт орсон./

6.2. Хувийн биржийг бүртгэх, санхүүжилт олгох, бүртгэлээс хасахтай холбоотой гомдол, маргааныг Төв биржид гаргах ба маргааныг шийдвэрлэх боломжгүй үед шүүхэд хандаж болно.

-----oOo-----

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2016 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн
А/117 дугаар тушаалын хавсралт

ХӨДӨЛМӨРИЙН ХУВИЙН БИРЖИД САНХҮҮЖИЛТ ОЛГОХ ЖИШИГ ТАРИФ

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ	Нэгжид ногдох зардал /ХХДХ-ээр дүйцүүлэн, төгрөгөөр/		
Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөө өгөх	5 цагийн хөдөлмөрийн хөлс		
Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн зөвлөгөө өгөх	Сарын хөдөлмөрийн хөлсний 30 хувиар		
Ажилд зуучлах	5 цагийн хөдөлмөрийн хөлс		
Хөдөлмөрийн хөлсний үнэлгээ, бүтээмж өндөр салбар ¹ -т ажилд оруулах	7 цагийн хөдөлмөрийн хөлс		
МСҮТ, ИДС төгсөгчдийг тухайн жилд нь багтаан ажилд оруулах	10 цагийн хөдөлмөрийн хөлс		
Ажил хайгчийг ажлын байранд зуучилж тогтвортой ажиллаж байгаа:	3 сараас дээш хугацаагаар:	6 сараас дээш хугацаагаар:	12 сараас дээш хугацаагаар:
Ажил хайгч ² Ажилгүй иргэн ³	Сарын хөдөлмөрийн хөлсний 15 хувиар	Сарын хөдөлмөрийн хөлсний 35 хувиар	Сарын хөдөлмөрийн хөлсний 65 хувиар
40-өөс дээш насны ажилгүй иргэн	Сарын хөдөлмөрийн хөлсний 30 хувиар	Сарын хөдөлмөрийн хөлсний 65 хувиар	Сарын хөдөлмөрийн хөлсний 125 хувиар
Ажил олоход хүндрэлтэй иргэн ⁴	Сарын хөдөлмөрийн хөлсний 35 хувиар	Сарын хөдөлмөрийн хөлсний 75 хувиар	Сарын хөдөлмөрийн хөлсний 150 хувиар

¹ Уул уурхай, олборлолт; цахилгаан, хий, агааржуулалт; санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа;

² Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.1.-т заасан;

³ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.2.-т заасан;

⁴ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.7.-т зааснаар тус тус ойлгоно.



**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ**

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2019 оны 7 дугаар
сарын 9-ний өдөр

Дугаар № 02

Улаанбаатар хот

**ОРОН НУТГИЙН ОНЦЛОГ, ХЭРЭГЦЭЭНД НИЙЦҮҮЛСЭН
ЗОРИЛТОТ ТӨСӨЛ БАТЛАХ ТУХАЙ**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6.3.7, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмын 4.6, 4.7, Засгийн газрын 2019 оны 06 дугаар сарын 28-ний өдрийн хуралдааны 28 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. 2019-2020 онд хэрэгжүүлэх “Орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл”-ийг нэгдүгээр, төслийн тэргүүлэх чиглэл, тавигдах ерөнхий шаардлага, шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан төслийн үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг танилцуулж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар / Б.Нямдаваа/-т тус тус үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Өнөрбаяр/-д даалгасугай.

**ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙД**

С.ЧИНЗОРИГ

Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн
дарга

Д.ХАДХҮҮ

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2019 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн 02
дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт.

ОРОН НУТГИЙН ОНЦЛОГ, ХЭРЭГЦЭЭНД НИЙЦҮҮЛСЭН ЗОРИЛТОТ ТӨСӨЛ

Нэг.Нийтлэг үндэслэл, шаардлага

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.15-д “Итгэлийн зээлийг олгож, жижиг, дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй, бичил бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлнэ”, 3.3.3-д “Хүн амын төвлөрлийг сааруулж, бүсчилсэн хөгжлийг дэмжихэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлого хэрэгжүүлж, орон нутгийн санаачилгыг дэмжинэ” зорилтуудыг хэрэгжүүлэх, өрхийн аж ахуй, бичил бизнес эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байрыг бий болгох, иргэдийг тогтвортой орлого олох боломжийг бүрдүүлэхэд орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хоёр. Төслийн зорилго

Төслийн зорилго нь Бичил бизнес эрхлэгчид орон нутгийнхаа онцлогт нийцүүлсэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд нь хөнгөлөлттэй зээл олгож ажлын байр бий болгох, тогтвортой орлоготой болгохыг дэмжих зорилготойгоор эргэн төлөгдөх, хүүгүй, барьцаагүй, 36 сарын хугацаатай итгэлийн зээлийн хэлбэрээр санхүүжилтийг олгоход оршино.

Гурав. Хамрах хүрээ, санхүүжилт

- 3.1. Ажил хайгч иргэн
- 3.2. Өрхийн аж ахуй эрхлэгч
- 3.3. Аж ахуйн нэгж, нөхөрлөл хоршооны хэлбэрээр бичил бизнес эрхлэгчид

Дөрөв. Төсөв

- 4.1. Төслийн санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:
 - 4.1.1. Улсын төсөв
 - 4.1.2. Орон нутгийн төсөв
 - 4.1.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
 - 4.1.3. Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж
 - 4.1.4. Бусад

Тав. Хэрэгжүүлэх арга хэмжээ

- 5.1. Төслийн хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулна. Үүнд
 - 5.1.1. Зорилтот төслийн эргэн төлөгдөх санхүүжилт
 - 5.1.2. Зээлийн дараах аж ахуй эрхлэлтийн сургалт болон бизнес инкубацийн үйлчилгээ
 - 5.1.3. Хяналт үнэлгээ

Зургаа. Эргэн төлөгдөх зорилтот төслийн санхүүжилт

6.1. Хувиараа болон аж ахуйн нэгж, нөхөрлөл, хоршооны хэлбэрээр бичил бизнес эрхлэгчид орон нутгийнхаа онцлогтой үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, ажлын байр бий болгоход нь зориулж ХХҮГ, хэлтсээр дамжуулан санхүүжилтийг олгоно.

6.2. 20.0 хүртэл сая төгрөгийн санхүүжилтийг хүүгүй, барьцаагүй, 36 сарын хугацаанд 100 хувь эргэн төлөх нөхцөлтэй олгоно.

6.3. Зээлийн санхүүжилт олгох үйл ажиллагааг 21 аймаг, 9 дүүрэгт сонгон шалгаруулалтын зарчмаар зохион байгуулна.

6.4. Зээлийн санхүүжилтийг дараах үе шаттайгаар зохион байгуулна.
Үүнд:

6.4.1. Тэргүүлэх чиглэл, төсөлд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох;

6.4.2. Олон нийтэд нээлттэй зарлан мэдээлэх

6.4.3. Төсөл хүлээн авах, бүртгэх,

6.4.4. Сонгон шалгаруулах,

6.4.5. Сонгон шалгаруулалтын үр дүнг олон нийтэд нээлттэй зарлан мэдээлэх

6.4.6. Гэрээ байгуулах, санхүүжүүлэх,

6.4.7. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээг хүргэх

6.4.8. Хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх,

6.4.9. Зээлийн батлан даалтын сангаас батлан даалт гаргах боломжтой эсвэл батлан даагчтай байх

6.5. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь төслийн ерөнхий шаардлага, шалгуурын дагуу орон нутгийнхаа онцлог, хэрэгцээ, хүн ам, хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүдэд тулгуурлан зээлийн санхүүжилтийн тэргүүлэх чиглэл, төсөлд тавигдах нэмэлт шаардлага, шалгуур үзүүлэлтийг тодорхойлно.

6.6. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь орон нутагтаа зээлийн талаарх мэдээллийг төсөл сонгон шалгаруулахаас 30-с доошгүй хоногийн өмнө нээлттэй зарлан мэдээлж, сурталчилна. Төслийн загвар маягт -ыг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар болон бусад мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэхээс гадна шаардлагатай бол олшруулж тараана.

6.7. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь зээлийн төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэг -ийг байгуулна.

6.8. Ажлын хэсэг төсөл сонгон шалгаруулалтыг 2 үе шаттай зохион байгуулах бөгөөд үе шат бүрийг ил тод, нээлттэй, иргэдийн оролцоог хангаж зохион байгуулна.

6.8.1. Эхний шатанд төслийн баримт бичгийн бүрдэл, тавигдах

шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхийг ажлын хэсэг үнэлнэ.

6.8.2. Шаардлага хангасан төслүүдийг төслийн санал ирүүлсэн иргэдийн үнэлгээг харгалзан нээлттэй, тэдний оролцоотойгоор ажлын хэсэг шалгаруулна. Шаардлагатай тохиолдолд иргэн өөрийн төслийг ажлын хэсэг болон ажлын хэсгийн үйл ажиллагааг хянаж байгаа иргэдийн төлөөлөлд танилцуулж болно.

6.9. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь өөрсдийн цахим хуудас, мэдээллийн самбарт ажлын хэсгийн сонгон шалгаруулсан болон шалгараагүй төслийн жагсаалтыг шалтгааны хамт нээлттэй, ил тод мэдээлнэ.

6.10. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь төсөл нь шалгарсан иргэн, бичил аж ахуйн нэгж, нөхөрлөл, хоршоотой зээлийн гэрээ -г төслийн батлан даагчийг оролцуулан байгуулна. Зээл нь 36 сарын хугацаанд 100 хувь эргэн төлөх нөхцөлтэй бөгөөд эргэн төлөлтийн хуваарийг бичил бизнес эрхлэгчдийн саналыг үндэслэн тогтоож, гэрээнд хавсаргана. Санхүүжилт авсан эхний 6 хүртэл сард эргэн төлөлтөөс чөлөөлж болно.

6.11. Аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь зээлийн авсан бичил бизнес эрхлэгчдийг зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ болох аж ахуй эрхлэлтийн сургалт, борлуулалт болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт арга хэмжээнд хамруулж болно.

6.12. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь зээлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, нөхөрлөл, хоршооны үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах, нийтэд мэдээлэх, үр дүнг сурталчлах өдөрлөг, яармаг зохион байгуулна.

6.13. Зээлийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээг аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь холбогдох төрийн болон Төрийн бус байгууллагуудтай хамтран жил бүр зохион байгуулна.

6.14. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь зээлийн хэрэгжилт, үр дүнгийн тайлан, мэдээг хагас жил тутамд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт ирүүлнэ. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь тайланг нэгтгэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлнэ.

6.15. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь зээлийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх тайлан, мэдээллийг Засгийн газарт тайлагнаж ажиллана.

Долоо. Төслийн хяналт

7.1 Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь Бичил бизнес эрхлэгчид орон нутгийнхаа онцлогт нийцүүлсэн үйлдвэрлэл,

үйлчилгээ эрхлэхэд нь зориулж олгосон итгэлийн зээлийн үр дүнг нэгтгэн олон нийгэд мэдээлж, мэдээллийн сан бүрдүүлнэ.

7.2 Зээлдэгчдийн мэдээллийг зээлийн мэдээллийн сантай холбоно.

7.3 Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь зээлийн үйл ажиллагааг дүгнэж цаашид авах арга хэмжээний санал боловсруулна.

Найм.Үр дүнгийн шалгуур үзүүлэлт

8.1. Зээл авсан хувираа хөдөлмөр эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, нөхөрлөл, хоршооны тоо;

8.2. Хадгалсан болон шинээр бий болсон ажлын байрны тоо;

8.3. Нийт олгосон зээлийн хэмжээ ба эргэн төлөлтийн хэмжээ;

---o0o---

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2019 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн 02
дугаар тогтоолын хоёрдугаар хавсаргалт

**Орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн
тэргүүлэх чиглэл, тавигдах ерөнхий шаардлага, шалгуур үзүүлэлт**

№	Хөтөлбөр, төслийн тэргүүлэх чиглэл	Ерөнхий шаардлага	Шалгуур үзүүлэлт
	<p>Орон нутаг, нийслэлийн үндсэн үзүүлэлт: Хүн ам /мян.хүн/; Хөдөлмөрийн насны хүн ам, Ажиллах хүчний оролцооны түвшин, Ажилгүйдлийн түвшин, Ажиллагчдын тоо, Албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчдийн эзлэх хувь, Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчдийн тоо, Мал аж ахуй эрхлэгчдийн тоо гэх мэт.</p>		
1.	Салбарын тэргүүлэх ач холбогдол бүхий төслүүд	Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээг судалгаанд үндэслэн тодорхойлсон байх; Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг тооцсон байх; Хөтөлбөр, төсөл хэрэгжиж эхлэх үеийн суурь үзүүлэлтүүдийг тооцсон байх; Төсөвт өртөгийг бодитойгоор тооцсон байх; Төслийн баримт бичгийн стандарт, шаардлагыг хангасан байх; Аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөс хэлэлцэн дэмжсэн байх;	Төслийн үндэслэл, тооцоолол, үр ашиг, нийгмийн үр нөлөө; Ажлын байр шинээр бий болгох, хадгалах, ажлын байрны бүтээмж, орлогыг дээшлүүлэх; Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн хэмжээ; Татвар, нийгмийн даатгал болон зээлийн өр, төлбөргүй байх; Төсөл хэрэгжүүлэгч нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн дэмжлэг, зээлд хамрагдаагүй байх;
2.	Өндөр технологид суурилсан гарааны бизнесийг дэмжиж, интерпрёнер мэргэжилтэн бэлтгэх, цахим ажлын байр бий болгох		

3.	Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээрх үйлдвэрлэл, үйлчилгээ болон ногоон ажлын байрыг дэмжих		
4.	Малын гаралтай түүхий эд, мах, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах, малын үүлдэр угсаа, ашиг шимийг дээшлүүлэх үйлдвэрлэлийг дэмжих, хөдөө аж ахуйн салбар дахь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх		
5.	Жимс, хүнсний ногоо боловсруулах чиглэлийн үйлдвэрлэлийг дэмжих		
6.	Нийтийн ахуйн үйлчилгээний жишиг үйлчилгээг сайжруулахыг дэмжих		
7.	Хөдөлмөрийн зах зээлд нэн шаардлагатай мэргэшсэн ажилтан дадлагажуулан, сургаж, ажлын байранд зуучлах		



**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ**

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2019 оны 1 дүгээр
сарын 14-ний өдөр

Дугаар № 01

Улаанбаатар хот

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ 2019-2020 ОНЫ
ХӨТӨЛБӨР”-ҮҮДИЙГ БАТЛАХ ТУХАЙ**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.7, 28 дугаар зүйлийн 28.8.2, Засгийн газрын 2016 оны 276 тоот “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 5.1-д заасныг үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”-ийг нэгдүгээр, “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийг хоёрдугаар, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийг гуравдугаар, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг дөрөвдүгээр, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийг тавдугаар, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг зургаадугаар хавсралтаар баталж, 2019-2020 онд хэрэгжүүлсүгэй.

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилтийг мэргэжлийн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ц.Амартөгс/-т, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Б.Нямдаваа/-т, хэрэгжилтийг хангаж, тайлагнаж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн дарга нарт даалгасугай.

3. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээ, хөтөлбөр төслийн мэдээллийг иргэдэд хүргэх арга хэмжээг өргөжүүлэх, ил тод, нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, “Иргэд төвтэй хөдөлмөр эрхлэлтийн жил”-ийг зарлаж, үйлчилгээг түргэн шуурхай болгон

хүртгэмжийг нэмэгдүүлэх, ажилтан, ажиллагчдын чадавхи бэхжүүлэх сургалтын арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Б.Нямдаваа/, аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн дарга нарт даалгасугай.

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙД С.ЧИНЗОРИГ

Үндэсний зөвлөлийн нарийн
бичгийн дарга Д.ХАДХҮҮ

/ ХЭҮЗ-ийн 2020 оны 01 сарын 30-ны өдрийн 01 дүгээр
тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсныг тусгав/

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2019 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн
01 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН УР ЧАДВАР ОЛГОХ ХӨТӨЛБӨР

Нэг. Зорилго

Иргэдийг хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ болон хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох сургалтад хамруулж, хөдөлмөрийн зах зээлд бэлтгэн, ажлын байранд дадлагажуулах замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд хөтөлбөрийн зорилго оршино.

Хоёр. Хамрах хүрээ

- 2.1. Ажилгүй иргэн;
- 2.2. Ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн;
- 2.3. Ажил олоход хүндрэлтэй иргэн;
- 2.4. Сургууль завсардсан хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхэд;
- 2.5.

Гурав. Хэрэгжүүлэх арга хэмжээ

- 3.1. Хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээ¹-г зохион байгуулна.

Үүнд:

- 3.1.1. Хөдөлмөрт бэлтгэх;
- 3.1.2. Мэргэжлийн болон давтан сургалт;
- 3.1.3. Үйлдвэрлэл дээрх сургалт;

Дөрөв. Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээг зохион байгуулах

4.1. Сургууль завсардсан, хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхэд, ажил олоход хүндрэлтэй иргэний онцлог, хэрэгцээ болон хөдөлмөр эрхлэх ур чадварыг тодорхойлж, дараах хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд хамруулна. Үүнд:

4.1.1. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох болон нийгэмшүүлэх зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн харилцааны мэдлэг олгох, хөдөлмөрийн дэг журам, үйлдвэрлэлийн горимд дасан зохицоход нь туслах, зөвлөгөө, мэдээллээр хангах;

4.1.2. Ажлын байран дахь харилцааны ур чадвар, сэтгэл зүй, хувь хүний төлөвшил, хөдөлмөрийн харилцаа аюулгүй ажиллагааны сургалтуудыг зохион байгуулах.

4.2. Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээний үйлчилгээ, дэмжлэг, туслалцааг хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагаар гэрээ²-ний үндсэн дээр гүйцэтгүүлж, зардлын жишгийн дагуу санхүүжилтийг олгоно.

¹ Арга хэмжээнүүдийн зардлын жишгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд батална.

² Гэрээний загварыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар батална.

Тав. Мэргэжлийн болон давтан сургалт зохион байгуулах

5.1. Мэргэжлийн болон давтан сургалтаар ажилгүй иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, сургууль завсардсан, хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхэд болон ажил олоход хүндрэлтэй иргэнд богино хугацаанд мэргэжлийн ур чадвар эзэмшүүлнэ.

5.2. Хөдөлмөрийн зах зээл, ажил олгогчдын эрэлт, ажлын байр, ур чадварын судалгаанд үндэслэн ажилгүй иргэдэд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлж, суралцах мэргэжлийн чиглэл, хэлбэр, боломжийн талаарх хүсэлтийг үндэслэн мэргэжлийн болон давтан сургалтад хамруулна.

5.3. Мэргэжлийн болон давтан сургалтыг нийслэлийн төвийн 6 дүүрэгт Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар “Эрхийн бичгийн сургалтын хөтөлбөр”³-ийн дагуу, 21 аймаг болон алслагдсан 3 дүүрэгт Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс орон нутгийн хөдөлмөрийн зах зээл дэх эрэлтийн дагуу зохион байгуулна.

5.4. Мэргэжлийн болон давтан сургалтыг эрх бүхий сургалтын байгууллагын жагсаалт⁴-д орсон сургалтын байгууллагуудаас сонгож, гэрээлэн зохион байгуулж, зардлын жишгийн дагуу санхүүжилтийг олгоно.

5.4.1. Нийслэлийн төвийн 6 дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс ажлын байрны захиалга, суралцагчдын эрэлтэд үндэслэн сургалтын хэрэгцээг тодорхойлж, Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газарт сургалтад хамрагдах хүний тоо, мэргэжлийн чиглэлийн саналыг хүргүүлнэ. Энэхүү саналд үндэслэн Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар сургалтын эрхийн бичгийг дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдэд хуваарилна.

5.4.2. Сургалтын чиглэл, сургалтын байгууллага сонгохдоо “Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр”-ийн хүрээнд зохион байгуулж буй цогц сургалтын чиглэлтэй давхцуулахгүй.

5.4.3. Дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээ-ний хэлтэс сургалтын эрхийн бичгийг иргэдэд олгох бөгөөд иргэн Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газраас мэргэжлийн сургалтын байгууллагын мэдээллийг авч суралцах байгууллагын сонголтоо хийнэ. Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар сургалтын гэрээг байгуулна.

5.4.4. Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар эрхийн бичгээр мэргэжлийн сургалтад хамрагдаж төгссөн иргэд, тэдний мэдээллийг

³«Эрхийн бичгийн сургалтын хөтөлбөр»-ийг Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын саналыг үндэслэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга батална.

⁴Эрх бүхий сургалтын байгууллагын жагсаалтыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар гаргана.

тухайн харъяалах дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст хүргүүлнэ.

5.4.5. Дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээ-ний хэлтэс эрхийн бичгээр мэргэжлийн сургалтад хамрагдсан иргэдийг зөвлөгөө, мэдээлэл өгөх, ажилд зуучлах болон бусад үйлчилгээ, арга хэмжээнд хамруулна.

5.4.6. Эрхийн бичгийн сургалтад орон нутгийн иргэн хамрагдаж болох бөгөөд энэ тохиолдолд өөрийн харьяа аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст хүсэлт тавьж, тодорхойлолт гаргуулна. Сургалтын үйл ажиллагаанаас бусад зардлыг иргэн өөрөө хариуцна.

5.5. Мэргэжлийн болон давтан сургалтын онол, дадлагын хичээлийн харьцаа 30/70, 5 хоногийн сургалт нь 36-гаас доошгүй цагийн хөтөлбөртэй байна.

5.6. Мэргэжлийн болон давтан сургалтыг чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрөөр зохион байгуулах бөгөөд үргэлжлэх хугацаа нь сонгосон хөтөлбөрөөс хамааран 1-6 долоо хоног байх бөгөөд хамрагдах иргэдийн 40 хүртэл хувь нь ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн байна.

5.7. Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж авч байгаа иргэний хэрэгцээнд үндэслэн мэргэжлийн сургалтад хамруулж, холбогдох зардлыг тухайн сангаас батлагдсан жишиг⁵-ээс хэтрүүлэхгүй санхүүжүүлж болно.

5.8. Мэргэжлийн болон давтан сургалтад хамрагдсан иргэнд “Мэргэжлийн сургалтаар чадамж, мэргэжил эзэмшсэн төгсөгч, иргэдийн мэргэшлийн түвшинг үнэлэх, баталгаажуулах журам”-ын дагуу ур чадварын шалгалтыг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв зохион байгуулж, Чадамжийн гэрчилгээ олгох ба иргэн өөрөө хүсвэл мэргэжлийн зэрэг олгох шалгалтад хамруулж болно.

Зургаа. Үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулах

6.1. Үйлдвэрлэл дээрх сургалтаар ажил олгогчийн үйлдвэрлэл, ажлын байранд тухайн иргэнд шинэ мэргэжил, ур чадвар эзэмшүүлэх, мэргэшүүлэх, ажиллуулах зорилгоор дагалдуулан сургана.

6.2. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс үйлдвэрлэл дээрх сургалтын талаарх мэдээллийг ажил олгогч, иргэдэд нээлттэй зарлан мэдээлэх ба сургалтад хамрагдах иргэдийг бүртгэнэ.

6.3. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь аж ахуйн нэгжийн хүсэлтийг хугацаа харгалзахгүйгээр хүлээн

⁵ Ажилгүйдлийн даатгалын сангаас сургалтад хамрагдах нэг даатгуулагчид олгох зардлын дээд хэмжээг баримтална.

авч, шаардлага хангаж байгаа эсэхэд ажлын 10-15 хоногийн дотор дүгнэлт хийж, гэрээ байгуулан сургалтыг зохион байгуулна.

6.4. Үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулах гэрээнд аж ахуйн нэгж тухайн дадлагажигчийг ажлын байраар хангах, түүнчлэн 5-аас дээш хүнийг дадлагажуулан ажиллуулж байгаа тохиолдолд 80-аас доошгүй хувийг ажлын байраар хангах асуудлыг заавал тусгана.

6.5. Үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулж байгаа аж ахуйн нэгжид 10.0 сая хүртэл төгрөгийн сургалтын зардлыг үр дүнгийн гүйцэтгэлд үндэслэн зардлын жишгийн дагуу нөхөн олгоно. Сургалтын үйл ажиллагаанд зарцуулагдах ажлын байр, цахилгаан, багаж, тоног төхөөрөмж зэрэг материаллаг болон материаллаг бус зардлыг аж ахуйн нэгж өөрөө хариуцна.

6.6. Үйлдвэрлэл дээрх сургалтын онолын хичээлийг аж ахуйн нэгж нь сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулах бөгөөд дадлагын хичээлийг онолын багшийн эсхүл үйлдвэрлэлийн дадлагажуулагч багшийн арга зүйн удирдлагын дор өөрийн үйлдвэрлэл дээр зохион байгуулна.

6.6.1. Үйлдвэрлэл дээрх сургалтын онол, дадлагын хичээлийн харьцаа 20/80, сургалтын хугацааг хувь хүний эрэлт, ажил олгогчийн хэрэгцээ, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох чадамжийн нэгжийн хөтөлбөрт үндэслэн уян хатан тогтоож болох бөгөөд 5 хоногийн сургалт нь 36-гаас доошгүй цагийн хөтөлбөртэй, сургалтын нийт үргэлжлэх хугацаа нь 3-6 долоо хоног байна.

6.6.2. Ажлын шинэ байр олноор бий болгох үйлдвэрлэл, бүтээн байгуулалтад шаардлагатай байгаа мэргэжилтэй ажилтны захиалга, эрэлтийг үндэслэн мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх, дадлагажуулан ажиллуулах арга хэмжээг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нэгтгэн зохион байгуулж, холбогдох зардлыг батлагдсан жишиг, хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр санхүүжүүлж болно.

6.7. Үйлдвэрлэл дээрх сургалтын зардлыг ажилгүй иргэний харьяалах аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс хариуцаж санхүүжүүлэх бөгөөд холбогдох гэрээг байгуулж ажиллана.

Долоо. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн

7.1. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

7.1.1. Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд хамрагдсан хүний тоо, зарцуулсан хөрөнгө;

7.1.2. Мэргэжлийн болон давтан сургалтад хамрагдсан хүний тоо, зарцуулсан хөрөнгө, үүнээс ажлын байртай болсон хүний тоо;

7.1.3. "Чадамжийн гэрчилгээ" авсан хөдөлмөр эрхлэлтийн ур чадвартай болсон хүний тоо.

7.1.4. Үйлдвэрлэл дээрх сургалтад хамрагдсан хүний тоо, зарцуулсан хөрөнгө, үүнээс ажлын байртай болсон хүний тоо;

7.1.5. Аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрагдсан хүний тоо, зарцуулсан хөрөнгө;

7.2. Хөтөлбөрийн хүрэх үр дүн

7.2.1. Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд хамрагдсан иргэдийн 50-с доошгүй хувь нь ажлын байртай болсон байна;

7.2.2. Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдсан иргэдийн 50-с доошгүй хувь нь чадамжийн гэрчилгээ авч, 40-с доошгүй хувь нь ажлын байртай болсон байна;

7.2.3. Үйлдвэрлэл дээрх сургалтад хамрагдсан иргэдийн 40-с доошгүй хувь нь ажлын байртай болсон байна;

7.2.4. Аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрагдсан иргэдийн 60-с доошгүй хувь нь аж ахуй эрхлэх үр чадвар нь дээшилсэн байна.

--ooOoo--

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2019 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн
I дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт

АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Нэг. Зорилго

Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийг санхүүгийн болон бусад дэмжлэг, арга хэмжээнд хамруулж, байнгын ажлын байр бий болгох, ажил олгогчид урамшуулал олгох, ажлын байрыг хадгалах, ажил хайгч, оюутан, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчийг түр ажлын байраар хангаж, орлого нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Аж ахуй, бичил бизнес болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч;

2.2. Ажил олоход хүндрэлтэй иргэнийг ажлын байраар хангаж буй ажил олгогч;

2.3. Ажилгүй иргэн, орон нутгийн иргэдийн бүлэг, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага;

2.4. Ажил хайгч иргэд, их, дээд сургуулийн оюутан, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагч;

2.5. Аж ахуй, бичил бизнес болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр хүнсний ногоо тариалах хүсэлт гаргасан иргэн, иргэдийн бүлэг.

Гурав. Хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1. Хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулна.
Үүнд:

3.1.1. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг;

3.1.2. Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэг;

3.1.3. Аж ахуй эрхлэлтийн сургалт;

3.1.4. Ажил олгогчийн дэмжлэг;

3.1.5. Нийтийг хамарсан ажил;

3.1.6. Зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээ;

3.1.7. Цагийн ажилд зуучлах;

3.1.8. Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах.

Дөрөв. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг зохион байгуулах

4.1. Аж ахуй, бичил бизнес, үйлдвэрлэл эрхлэх хүсэлтэй 35 ба түүнээс дээш насны хөдөлмөрийн насны иргэн болон гадаадад ажиллаж, амьдарч байгаа иргэн⁶-ий төсөл хэрэгжих үндэслэлийг харгалзан шалгаруулж,

⁶ Гадаадаас сүүлийн 2 жилийн дотор ирсэн хөдөлмөрийн насны иргэнийг хүсэлтэд үндэслэн хамруулна.

5,0 хүртэл сая төгрөгийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг нэг удаа олгоно.

4.2. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь жил бүрийн 4, 9 дүгээр сард төсөл шалгаруулалтыг зохион байгуулах ба шалгарсан төслийг хэрэгжүүлэх гэрээ байгуулж, санхүүгийн дэмжлэгийг олгон хэрэгжилтэд арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана.

4.3. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн тухай мэдээлэл, сурталчилгааг олон нийтэд 3 долоо хоногоос доошгүй хугацааны өмнөөс тухайн нутаг дэвсгэрийн иргэд, олон нийтэд зарлан мэдээлнэ.

4.4. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлт гаргасан иргэдийг бүртгэн аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулсны дараа төслүүдийг хүлээн авна.

4.5. Төсөл шалгаруулах үе шат бүрийг ил тод, нээлттэй иргэдийн оролцоог хангаж зохион байгуулна. Эхний шатанд төслийн баримт бичгийн бүрдэл, тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаж буйг ажлын хэсэг⁷ сонгон шалгаруулна.

4.6. Шаардлага хангасан төслүүдийг төслийн санал ирүүлсэн иргэдийн үнэлгээг харгалзан нээлттэй, тэдний оролцоотойгоор ажлын хэсэг шалгаруулна⁸. Шаардлагатай тохиолдолд төслийн санал ирүүлсэн иргэн өөрийн төслийг ажлын хэсэг болон ажлын хэсгийн үйл ажиллагааг хянаж байгаа иргэдийн төлөөлөлд танилцуулж болно.

4.7. Хүсэлт ирүүлсэн иргэн нь хийхээр төлөвлөсөн үйлдвэрлэлийн чиглэлээр мэргэжлийн ур чадвар эзэмшсэн байх нь төслийн шалгаруулалтад давуу тал болно.

4.8. Санхүүгийн дэмжлэг нь 36 сарын дотор 100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй байх бөгөөд эргэн төлөлтийн хуваарийг иргэний саналыг үндэслэн тогтоож, гэрээнд хавсаргана.

Тав. Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах

5.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон эргэн төлөгдөх санхүүгийн болон бусад дэмжлэг, жижиг зээл авсан иргэдэд бараа, бүтээгдэхүүн борлуулахад нь дэмжлэг үзүүлэх болон ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

5.2. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь иргэний үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг борлуулах

⁷ Ажлын хэсгийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөлтэйгээр аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн даргын тушаалаар байгуулна.

⁸ Төсөл шалгаруулах үед төсөлд оролцож буй иргэдийн өгч буй үнэлгээ нь ажлын хэсгийн үнэлгээний 20-30 хувьд нь нөлөөлөхөөр байна.

цэгийг ажиллуулна⁹.

5.3. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс үйлдвэрлэл, үйлчилгээ¹⁰ний зориулалтаар 6 болон түүнээс дээш сарын хугацаагаар ажлын байр түрээслэн үйл ажиллагаа явуулж байгаа, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг авсан хувиараа аж ахуй, бичил бизнес эрхлэгч, нөхөрлөл, хоршоодод түрээсийн гэрээ, холбогдох баримт бичиг, нөхцөл байдлыг газар дээр нь үнэлсэн үнэлгээнд үндэслэн ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг¹¹ төлбөр төлсөн баримтаар нөхөн олгоно.

5.4. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг зарж борлуулахад чиглэсэн үзэсгэлэн, яармагийг зохион байгуулна.

5.5. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь үндэсний бүтээгдэхүүнийг гадаад орнуудад гаргаж, борлуулалт хийдэг байгууллагуудаар дамжуулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдэд хамрагдсан иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг гадаад орнуудад борлуулахад зохион байгуулалтын дэмжлэг үзүүлнэ.

5.6. Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдсан иргэнийг энэхүү үйл ажиллагаанд 24 сарын дотор дахин хамруулахгүй.

Зургаа. Аж ахуй эрхлэлтийн сургалт

6.1. Аж ахуй, бичил бизнес эрхлэгч иргэн болон жижиг зээл, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдахаар төсөл өгсөн, төсөл нь шалгарсан иргэнийг хүсэлтэд нь үндэслэн аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулна.

6.2. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс аж ахуй эрхлэлтийн сургалтаар мэргэшсэн сургагч багшийн эрх бүхий ажилтантай бол тухайн ажилтнаар эсвэл сургалтын байгууллагатай гэрээний үндсэн дээр сургалтыг зохион байгуулна. Сургалтын байгууллагыг аж ахуй эрхлэлтийн эрх бүхий сургалтын байгууллагын жагсаалт¹² аас сонгоно.

6.3. Иргэн нь бизнес эхлэх, хөгжүүлэх, аж ахуй эрхлэх төлөвлөгөө, төсөл боловсруулах, бизнесийн санааг хөгжүүлж гарааны бизнесийг хөгжүүлэх, хоршоо, нөхөрлөл, бүлэг байгуулж үйл ажиллагаа эрхлэх,

⁹ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан «Борлуулалтын цэг ажиллуулахад зарцуулах нэг сарын зардлын дээд хэмжээ»-нээс хэтрүүлэхгүйгээр цэгийг ажиллуулна. Бусад хөтөлбөрүүдэд дурдсан нэгдсэн борлуулалтын цэг нь энэхүү цэг байж болно.

¹⁰ «Үйлчилгээ» гэдэгт худалдааны үйл ажиллагаа эрхэлж байгаа хамааруулахгүй.

¹¹ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан «Түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх нэг сарын зардлын дээд хэмжээ»-нээс хэтрүүлэхгүй байна.

¹² Аж ахуй эрхлэлтийн эрх бүхий сургалтын байгууллагын жагсаалтыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар гаргана.

борлуулалтын сүлжээ, маркетингийн болон санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээрх сургалтын хөтөлбөрөөс сонгон аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрагдана.

6.4. Аж ахуй эрхлэлтийн сургалтын үргэлжлэх хугацаа ажлын 3 болон 5 хоног байх бөгөөд 3 хоногийн сургалт нь 21-ээс, 5 хоногийн сургалт нь 36-гаас доошгүй цагийн хөтөлбөртэй байна.

6.5. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь хөтөлбөрт хамрагдсан иргэдийн үйл ажиллагааг дэмжих, хэрэгжилтийн явцад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах ба хяналт тавих, хэрэгжүүлж буй арга хэмжээг сайжруулах зорилгоор иргэд, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагууд, ажил олгогчдын оролцоотой туршлага солилцох уулзалт, хэлэлцүүлгийг жилд 2 удаа зохион байгуулна.

Долоо. Ажил олгогчийг дэмжих арга хэмжээг зохион байгуулах

7.1. “Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ” гэж ажил олгогчоос ажил олоход хүндрэлтэй иргэнийг авч ажиллуулахтай холбоотой гарсан зардлын тодорхой хэсгийг нөхөн төлөх, тухайн иргэнийг ажлын байранд нь тогтвортой ажиллуулахыг урамшуулах зорилго бүхий үйл ажиллагааг ойлгоно.

7.2. “Ажил олгогч” нь улсын бүртгэлийн болон татвар, нийгмийн даатгал, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй, нэг буюу түүнээс дээш ажилтныг хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр авч байнгын ажлын байранд ажиллуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын эзэн, нөхөрлөл, хоршооны удирдлага¹³ байна.

7.3. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлэн, ажил идэвхтэй хайж байгаа боловч 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа иргэнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар байнгын ажлын байраар хангасан ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг бий болгосон байнгын ажлын байраар тооцож, ажил олгогчид нэг удаа олгоно.

7.4. Хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан иргэнийг үйлдвэрлэл дээрээ дадлагажуулан үндсэн ажилтнаар нэг жилээс доошгүй хугацаагаар үргэлжлүүлэн байнгын ажлын байраар хангаж байгаа ажил олгогчид дадлагын хугацааны сургалтын зардлыг нөхөн олгож, нэг жилийн цалин хөлстэй тэнцэх хэмжээний¹⁴ санхүүгийн дэмжлэгийг бий болгосон байнгын ажлын байраар тооцож, ажил олгогчид нэг удаа олгоно.

¹³ Энэхүү арга хэмжээнд Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалтын үйлдвэр болон төсвөөс санхүүжилт авдаггүй төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад төсвийн байгууллага, төрийн бус байгууллага, нөхөрлөл, хоршооны гишүүд хамаарахгүй.

¹⁴ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан “Дээд хэмжээгээр тооцох нэг сарын цалингийн хэмжээ”-нээс хэтрүүлэхгүй байна.

7.5. Ажил олгогч энэхүү хөтөлбөрийн 7.3, 7.4-т заасан иргэнийг ажлын байраар хангах тухайгаа тухайн иргэний харьяалах аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст мэдэгдэн гэрээг байгуулж, холбогдох урамшууллыг авна.

7.6. Ажил олгогч нь ажлын байраар хангасан иргэнийг нийгмийн даатгалд хамруулж, цалин, хөлсийг олгон, баримт бүрдүүлнэ.

Найм. Нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээ

8.1. Нийтийг хамарсан ажлыг зохион байгуулах хүрээнд байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй бусад нөхцөл байдлын улмаас үүссэн хор уршгийг арилгах, нөхөн сэргээх, нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд бүтээн байгуулалт хийх, сайжруулах, тохижилт хийх, хог хаягдалгүй байлгах, байгаль орчныг хамгаалах, ой цэвэрлэх, мод тарих, голын ай сав, үер усны даланг цэвэрлэх, усны нөөц сан байгуулах, засварлах зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэж болно.

8.2. Тухайн арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийн 10-15 хүртэл хувийг хог, хаягдал цэвэрлэх зардалд зарцуулна.

8.3. Орон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь орон нутгийн ажилгүй иргэдийг түр ажлын байраар хангах төсөл, төлөвлөгөөг боловсруулж Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст ирүүлнэ.

8.4. Ирүүлсэн төслийг хүлээн авч, бий болгох түр ажлын байрны тоо, гүйцэтгэх ажлын зардал, санхүүгийн тооцоо зэргийг хянан үзээд дэмжигдсэн төсөл, төлөвлөгөөг хэрэгжүүлэх нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах шийдвэр гаргаж, гэрээ байгуулна.

8.5. Нийтийг хамарсан ажилд хамрагдах иргэдийг сард ажлын 10 хүртэл хоногоор, өдөрт 8 хүртэл цагаар ажиллуулах ба ажилласан иргэдийн цалин хөлс, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлыг¹⁵ ажилласан цагаар тооцож өдрөөр болон ажил хийгдэж дууссаны дараа олгоно.

8.6. Нийтийг хамарсан ажилд хамрагдсан иргэдийн ажлын хөлс, зардлыг аймаг, нийслэл, дүүргийн газар, хэлтэс тухайн иргэний банкин дахь нэрийн дансанд шилжүүлнэ.

8.7. Нийтийг хамарсан ажлыг гэрээлэн гүйцэтгэх нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж нь хууль тогтоомжийн хүрээнд хүлээсэн үүрэгт ажил¹⁶-ыг нийтийг хамарсан ажлаар гүйцэтгүүлэхийг

¹⁵ Хөдөлмөр, нийгмийн хамгаалын сайдын баталсан «Нийтийг хамарсан ажлын хөлс, зардлын хэмжээ»-ний дагуу олгоно.

¹⁶ Нийслэлийн Засаг даргын Санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан орлогчийн 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/1125 дугаар захирамжийн 2 дугаар зүйл, заалт болон түүнтэй адилтгах хууль тогтоомж, орон нутгийн шийдвэрийн дагуу хүлээсэн үүрэгт ажлыг болон бусад хууль тогтоомжоор хүлээлгэсэн үүрэгт ажлыг ойлгоно.

хориглоно.

8.8. Орон нутгийн төрийн захиргааны байгууллагын эрэлт, хэрэгцээг судалж нийтийн ашгийн төлөө ажил зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх талаарх мэдээллийг ажил олгогч, олон нийтэд болон иргэнд өгч оролцох боломжийн талаар танилцуулна.

8.9. Арга хэмжээний хүрээнд талуудын хамтран ажиллах гэрээний загвар, тайлангийн маягтыг Хөдөлмөр, халамжийн ерөнхий газрын дарга баталж мөрдүүлнэ.

8.10. Нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээнд хамрагдсан иргэдэд олгосон цалин хөлснөөс Нийгмийн даатгалын шимтгэлийг тооцож авахгүй¹⁷ бөгөөд иргэн сайн дурын даатгалд хамрагдаж болно.

Ес. Зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээ

9.1. Сумын ажилгүй иргэдийг бүлгийн зохион байгуулалтайгаар хөдөлмөр эрхлүүлж, ажлын байртай болгох¹⁸ арга хэмжээ

9.1.1. Сумын бүртгэлтэй ажилгүй иргэдээс 1 суманд 8-аас илүүгүй хүнтэй 1 бүлэг зохион байгуулж, ахлагчийг бүлгийн гишүүдийн саналаар томилно. Бүлэгт нийгмийн дэмжлэг тусламж зайлшгүй шаардлагатай орхийн 1-2 гишүүнийг оруулна.

9.1.2. Бүлэг нь сум, багийн Засаг дарга, хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан ажилтантай хамтран аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлтэд үндэслэн тухайн жилд хамтран хийх ажлын жоргоо, байршил, хамрах хүрээ /хэмжээ/¹⁹-г гаргана.

9.1.3. Бүлэг нь гүйцэтгэх ажлаас гишүүдийн санал, ур чадвар, чадавхид үндэслэн сонгож, бүлгийн тухайн жилийн ажлын төлөвлөгөө, зардал, хөрөнгийн тооцоог боловсруулж, сумын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан ажилтанд танилцуулна.

9.1.4. Сумын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан ажилтан нь энэхүү хөтөлбөрийн 9.1.3-т заасан төлөвлөгөө, тооцоог хянан бүлгийн ахлагч, сумын Засаг дарга болон бусад хамтран ажиллах талууд хоорондын гэрээг байгуулж, уг гэрээний нэг хувийг бүлгийн ажлын төлөвлөгөө, зардал, хөрөнгийн тооцооны хамт аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хүргүүлнэ.

9.1.5. Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээ-ний газар нь бүлгийн ажлын төлөвлөгөө, зардал, хөрөнгийн тооцоо, гэрээг үндэслэн бүлэг тус бүрт 5,0 хүртэл сая төгрөгийн багаж, тоног төхөөрөмжийн нэг удаагийн буцалтгүй дэмжлэгийг олгоно.

¹⁷ Засгийн газрын 2015 оны 380 дугаар тогтоол, Монгол Улсын Дээд шүүхийн 2008 оны 47 дугаар тогтоолын 1.8 дахь заалтыг баримтлан ажиллана.

¹⁸ Нэг аймаг нь 10 хүртэл бүлгийг ажиллуулна.

¹⁹ Бүлгийн гүйцэтгэх ажлын төрлийг нэгдсэн удирдамжид тусгана.

9.1.6. Тухайн бүлэг нь жагсаалтад гэрээнүүдэд заасан ажил, үйлчилгээг хийж гүйцэтгэх ба үүний үр дүнд орлого олон дундын сан /хуримтлал/ үүсгэж, тогтвортой үйл ажиллагаа явуулан цаашид нөхөрлөл, хоршоо байгуулах чиглэлээр ажиллана.

9.2. Хорооны ажилгүй иргэдийг бүлгийн зохион байгуулалтаар хөдөлмөр эрхлүүлж, орлоготой болгох²⁰ арга хэмжээ

9.2.1. Хорооны бүртгэлтэй ажилгүй иргэдээс нэг хороонд 3-5 хүнтэй 1 бүлэг зохион байгуулж, ахлагчийг бүлгийн гишүүдийн саналаар томилно. Багт нийгмийн дэмжлэг, тусламж зайлшгүй шаардлагатай өрхийн 1 гишүүнийг оруулна.

9.2.2. Багийн зохион байгуулалтаар хөдөлмөр эрхлүүлж, орлоготой болгох арга хэмжээний үе үат, хэрэгжилт нь энэхүү хөтөлбөрийн 9.1-т заасан арга хэмжээтэй ижил зохион байгуулагдана.

9.2.3. Дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээ-ний хэлтэс нь холбогдох гэрээг үндэслэн хөтөлбөрт заасан дэмжлэгийн зардал, түүний дотор баг тус бүрт 3,0 хүртэл сая төгрөгийн багаж, тоног төхөөрөмжийн нэг удаагийн бүцэлтгүй дэмжлэгийг олгоно.

Арав. Ажил хайгч иргэн, оюутан, суралцагчдыг цагийн ажилд зуучилж орлого нэмэгдүүлэх арга хэмжээ

10.1. Ажил хайгч иргэд, их, дээд сургуулийн оюутан, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын өдрийн ангид суралцагчийг орлого олоход дэмжлэг үзүүлэх зорилгоор цагийн ажилд зуучилна.

10.1. Ажил хайгч иргэд, оюутан, суралцагчдыг цагийн ажилд зуучлах арга хэмжээг Улаанбаатар хотод Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дэргэдэх “Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”-үүдээр дамжуулан, ~~Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар туршилтаар Ажил, мэргэжлийн мэдээллийн төвд төрийн бус байгууллагаар дамжуулан хэрэгжүүлнэ.~~

/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор хассан/

10.3. Цагийн ажлын цалин хөлс, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зардлыг ажил олгогч хариуцах бөгөөд хөдөлмөрийн хэвийн нөхцөлийг хангаж аюулгүй ажиллагааны заавар зөвлөмж өгч ажиллана.

10.4. ~~Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар нь цагийн ажлын зуучлалд зориулсан бүртгэл, зуучлалын мэдээллийн сан бий болгон хөгжүүлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны анхан шатны зааварчилгаа өгөх, цагийн ажилд зуучлах хөдөлмөрийн яармаг, өдөрлөг, явуулын, хөдөлмөрийн бирж ажиллуулж, батлагдсан зардлын жишгийн дагуу санхүүжүүлнэ.~~

/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 дүгээр

¹⁶ Нэг дүүрэг нь 7 хүртэл багийг ажиллуулна.

тогтоолоор хассан/

10.5. Оюутнуудад цагийн ажлын үргэлжлэх хугацаа нь өдөрт 4 цагаас, долоо хоногт 20 цагаас илүүгүй байна. Хичээлийн жилийн завсарлага буюу зуны амралтын хугацаанд энэхүү хязгаарлалт хамаарахгүй.

Арван нэг. Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээг зохион байгуулж орлогын дэмжлэг үзүүлэх

11.1. Иргэдийг бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд хамруулан сургаж, орлогоор дэмжинэ.

11.2. Хүнсний ногоо тариалах арга хэмжээг Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн хэмжээнд Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар, аймгууд болон алслагдсан 3 дүүргийн хэмжээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс зохион байгуулах ба хүнсний ногоо тариалах арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах газрын асуудлыг шийдвэрлэсэн байна.

11.3. Арга хэмжээнд хамрагдах хүсэлтэй иргэдэд зохих мэдээллийг нийтэд мэдээлэн, шалгаруулж, тодорхой төлөвлөгөөний дагуу хүнсний ногоо тариалах арга барилд сурган иргэдийг бүлгийн зохион байгуулалттайгаар ажиллуулна.

11.4. Арга хэмжээний хүрээнд иргэдийн хураасан ургацыг хамрагдсан иргэдэд олгох бөгөөд зарж, борлуулахад чиглэсэн нэгдсэн арга зохион байгуулж болно.

Арван хоёр. Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн

12.1. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

12.1.1. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг авсан хүний тоо, зарцуулсан болон эргэн төлөгдсөн хөрөнгийн хэмжээ;

12.1.2. Бий болсон байнгын ажлын байрны тоо;

12.1.3. Бараа, бүтээгдэхүүн борлуулах цэг болон хамрагдсан иргэн, нөхөрлөл, хоршооны тоо;

12.1.4. Дотоод, гадаадын үзэсгэлэн яармагт оролцсон иргэн, нөхөрлөл, хоршооны тоо;

12.1.5. Ажлын байрны түрээсийн хөнгөлөлтөд хамрагдсан иргэн, нөхөрлөл, хоршооны тоо;

12.1.6. Нийтийг хамарсан ажлын төрөл, чиглэл тус бүрт хамрагдсан хүний тоо;

12.1.7. Цагийн ажилд зуучлагдсан хүний тоо, хүйсээр, мэргэжлийн төрлөөр, бүртгэлд хамрагдсан оюутан, ажил хайгчийн тоо;

12.1.8. Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд хамрагдсан иргэний тоо.

12.2. Хөтөлбөрийн хүрэх үр дүн

12.2.1. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдаж ажлын байр бий болсон байна;

12.2.2. Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэгт хамрагдан үйл ажиллагаа тогтворжсон байна;

12.2.3. Ажил олоход хүндрэлтэй иргэд байнгын ажлын байраар хангагдаж, орлого нь нэмэгдсэн байна;

12.2.4. Иргэд түр ажлын байраар хангагдаж, орлого нэмэгдсэн байна.

--ooOoo--

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2019 оны 1 дүгээр сарын 14 -ний өдрийн
1 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт

ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Нэг. Зорилго

Залуучуудыг хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамруулах, аж ахуй, бизнес эрхлэх ур чадвар, шинэлэг санаанд тулгуурлан гарааны дэмжлэг олгох, бизнесээ тогтвортой эрхлэхэд туслах замаар тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд хөтөлбөрийн зорилго оршино.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан Монгол Улсын иргэн, 15-34 насны залуучууд, ялангуяа, ажилгүй, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа залуучууд түүнчлэн, их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид болон төгсөгчид энэхүү хөтөлбөрт хамрагдана.

Гурав. Хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1. Хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулна.
Үүнд:

3.1.1. Залуучуудад зориулсан хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх;

3.1.2. Аж ахуй эрхлэлтийн сургалт;

3.1.3. Гарааны бизнесийг дэмжих;

3.1.4. Борлуулалтын болон үйлдвэрлэлийн ажлын байрны түрээсийн хөнгөлөлт олгох.

Дөрөв. Залуучуудад зориулсан хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх

4.1. Ажил хайгчийн хөдөлмөр эрхлэх ур чадварт үнэлгээ хийх;

4.1.1. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс болон Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв нь ажил хайгч залуучуудын хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээг зохих аргачлалын дагуу хийнэ.

4.1.2. Ажил хайгч залуучуудыг хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх чадварынх нь хувьд боломжтой, дунд зэрэг, боломж багатай гэж гурав ангилна.

4.2. Ажил хайгч хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөөгөө боловсруулахад туслах;

4.2.1. Хөдөлмөрийн зах зээлд нэвтрэн орох чадварын хувьд боломжтой гэсэн үнэлгээ авсан залуучуудыг тохирох ажилд зуучилна.

Тохирох ажил олдохгүй байгаа бол ажил хайгч хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөөгөө боловсруулж хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлнэ.

4.2.2. Хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх чадварын хувьд дунд зэрэг, боломж багатай гэсэн үнэлгээ бүхий ажил хайгч залуучуудтай хамтран ажил хайгч хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөөгөө боловсруулахад тусалж, хэрэгжилтэд нь тухайн хүний ур чадвар, эрэлт хэрэгцээнд тулгуурлан хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээнд хамруулан дэмжлэг үзүүлж ажиллана.

4.3. Ажил хайгч залуучуудын хамтын ажиллагааг дэмжих үйлчилгээг бүлгээр зохион байгуулах бөгөөд бүлгийг ажил хайгч 15-20 залуугаас бүрдүүлэн дараах багц арга хэмжээг зохион байгуулна. Үүнд:

4.3.1. Өөрийгөө танин мэдэх, үнэлэх, хөдөлмөрийн зах зээлд нэвтрэн орох, ажил хайх чадвар эзэмших, ажил хайх гэсэн үе шат бүхий сургалтад хамруулах;

4.3.2. Аж ахуйн нэгж, байгууллагад танилцах аялал зохион байгуулах;

4.3.3. Дундын зориулалттай байраар үйлчлэх;

4.3.4. Тохирох ажилд ганцаарчилсан болон бүлгийн зохион байгуулалттайгаар зуучлах.

4.4. Ажил олгогчид тохирох ажилтныг, ажил хайгчид тохирох ажил зуучлах арга хэмжээг ганцаарчилсан ба бүлгийн зохион байгуулалттай хэлбэрээр хэрэгжүүлнэ.

4.4.1. Дараах ажил олгогч, ажил хайгч эсвэл ажилтанд ганцаарчилсан хэлбэрээр зуучилна. Үүнд:

- Ажлын байрны захиалгыг маягтын дагуу ирүүлсэн ажил олгогч;

- Өндөр ур чадвартай, мэргэшсэн ажилтан хайж буй ажил олгогч;

- Тохирох өөр ажил буюу амьдарч буй газарт ойр ажил хайж буй ажилтан;

- Ганцаарчилсан хэлбэрээр үйлчилгээ авахаар хүсэлт гаргасан ажил олгогч, ажил хайгч.

4.4.2. Бүлгийн зохион байгуулалтыг нэг буюу хэд хэдэн ажил олгогчид тодорхой бүлэг ажил хайгчдыг зуучлах төрөл бүрийн (хөдөлмөрийн яармаг цагийн ажлын өдөрлөг зохион байгуулах, ажил товлох шуурхай ярилцлага хийх, урьдчилан тохирсон аж ахуйн нэгж, байгууллагаар тойрон явж ярилцлага хийх, эрэлт ихтэй мэргэжлээр сургууль төгсөгчдийг ажилд зуучлах гэх мэт) аргаар хийнэ.

4.4.3. Дараах ажил олгогч, ажил хайгч нарт бүлгийн зохион байгуулалттай хэлбэрээр зуучилна. Үүнд:

- Бүлэг ажил хайгчдаас сонголт хийх хүсэлтэй ажил олгогч буюу хэд хэдэн ажил олгогч;

- Тухайн үед эрэлт хэрэгцээтэй болсон мэргэжлүүдээр ажиллах хүч нэмж авах шаардлагатай байгаа ажил олгогч;

- Улирлын болон цагийн ажилд ажилтан авах хүсэлтэй ажил олгогчид;

- Их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын байгууллага төгсөгчид;

- Бүлгийн зохион байгуулалттай хэлбэрээр үйлчилгээ авч буй ажил хайгчид.

4.5. Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, үр дүнгийн тухай мэдээллээр хангах хүрээнд дараах арга хэмжээ хэрэгжүүлнэ. Үүнд:

4.5.1. Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг 2 жилд нэг удаа аргачлалын дагуу хийнэ.

4.5.2. Газар хэлтсүүд орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн үр дүнгийн судалгааг сэдэвчилсэн байдлаар зах зээлийн нөхцөл байдал, ажил олгогч болон сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг үндэслэн хийнэ.

4.5.3. Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, үр дүнгийн судалгааг аймаг, нийслэл, дүүргийн судалгааны баг дангаараа эсвэл хөдөлмөрийн зах зээлийн судалгаа эрхэлдэг төрөлжсөн байгууллагуудтай төслийн дэмжлэгтэйгээр хамтран гүйцэтгэж болно. Судалгааг хамтран гүйцэтгэх тохиолдолд судалгаа хийх бэлтгэл хангах, өгөгдөл цуглуулах, өгөгдлийн тоо, чанарт хяналт тавих, өгөгдөл оруулах зэрэг ажлыг аймаг, нийслэл, дүүргийн судалгааны баг өөрөө гүйцэтгэнэ.

4.5.4. Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, үр дүнгийн судалгааны зардлыг орон нутгийн төсвөөс болон олон улсын хөтөлбөр, төслөөс санхүүжүүлэн гүйцэтгэнэ.

Тав. Аж ахуй эрхлэлтийн сургалт

5.1. Аж ахуй, бичил бизнес эрхлэгч иргэн болон жижиг зээл, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдахаар төсөл өгсөн, төсөл нь шалгарсан иргэнийг хүсэлтэд нь үндэслэн аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулна.

5.2. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь аж ахуй эрхлэлтийн сургалтаар мэргэшсэн сургагч багшийн эрх бүхий ажилтантай бол тухайн ажилтнаар эсвэл зохих сургалтын байгууллагатай гэрээний үндсэн дээр зохион байгуулна.

5.3. Иргэн нь бизнес эхлэх, хөгжүүлэх, аж ахуй эрхлэх төлөвлөгөө, төсөл боловсруулах, бизнесийн санааг хөгжүүлж гарааны бизнесийг хөгжүүлэх, хоршоо, нөхөрлөл, бүлэг байгуулж үйл ажиллагаа эрхлэх, борлуулалтын сүлжээ, маркетингийн болон санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээрх сургалтын хөтөлбөрөөс сонгон аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрагдана.

5.4. Аж ахуй эрхлэлтийн сургалтын үргэлжлэх хугацаа ажлын 3 болон 5 хоног байх бөгөөд 3 хоногийн сургалт нь 21-ээс, 5 хоногийн сургалт нь 36-гаас доошгүй цагийн хөтөлбөртэй байна.

5.5. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь хөтөлбөрт хамрагдсан иргэдийн үйл ажиллагааг дэмжих, хэрэгжилтийн явцад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах ба хяналт тавих, хэрэгжүүлж буй арга хэмжээг сайжруулах зорилгоор иргэд, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагууд, ажил олгогчдын оролцоотой туршлага солилцох уулзалт, хэлэлцүүлгийг жилд 2 удаа зохион байгуулна.

Зургаа. Залуучуудын гарааны бизнесийг дэмжих арга хэмжээг зохион байгуулах

6.1. Тэргүүн туршлага, шинэ технологид суурилсан шинэлэг бизнес санааг дэмжих, гарааны компани эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх арга хэмжээг аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүд дараах байдлаар 1-2 удаа зохион байгуулж, хэрэгжүүлнэ. Үүнд:

/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор өөрчилсөн/

Залуучуудын гарааны бизнесийг дэмжих ажлын хэсгийг²¹ аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс тус бүрт холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулна.

6.1.1. Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар нь дүүргүүдээс шалгарсан багийн гарааны бизнесийг хөрөнгө оруулагч нарт суртчилах, танилцуулах нэгдсэн уулзалт, өдөрлөг зохион байгуулна.

6.1.2. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс болон сум, хорооны хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь гарааны бизнес эхлүүлэх хүсэлтэй залуучуудад зарлан мэдээлж, залуучуудыг²² бүртгэж, бүлэг байгуулна.

6.1.3. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/хэлтэс гарааны бизнес эхлүүлэх хүсэлтэй залуучууд (их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагч, төгсөгчид, 15-34 насны залуучууд)-дад мэдээлэл хүргэх, бүртгэх, бүлэг байгуулах арга хэмжээг хариуцах ба мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, политехник коллежийн суралцагчдын бүлгийг сургалтын байгууллагатай нь хамтран зохион байгуулна.

/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор өөрчилсөн/

²¹ Ажлын хэсгийн ажиллах нийтлэг удирдамжийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар батална.

²² 15-34 насны залуучууд, мэргэжлийн боловсрол, сургалтын байгуул-лагын төгсөгчид байна.

6.1.4. Гарааны бизнес санааг баяжуулах, өрсөлдүүлэх, багаар ажиллаж ирээдүйтэй санааг бизнесийн зөвлөх (ментор)-ийн туслалцаатайгаар хөгжүүлэх, шилдэг гарааны бизнесийг сонгон шалгаруулах 72 цагийн арга хэмжээг 3 өдөр (Сүүлийн 2 өдөр нь хагас, бүтэн сайн) зохион байгууллахаар сонгогдсон мэргэжлийн эрх бүхий байгууллагатай байгуулсан гэрээний үндсэнд хэрэгжүүлнэ.

6.1.5. Шалгарсан багуудын үйл ажиллагаа тогтворжиж, бизнесийн ашгаа хүртэж эхэлтэл /3 сар орчим/ бизнесийн зөвлөх /ментор/-үүдтэй хамтарч, гэрээний үндсэн дээр зохион байгуулна.

6.1.6. Залуучуудад аж ахуй эрхлэлт, загвар бүтээх сэтгэлгээний сургалт, гарааны бизнес санааг баяжуулах, өрсөлдүүлэх зөвлөгөөг бүлгүүдийн хэрэгцээ, хүсэлтэд үндэслэн эрх бүхий байгууллага²³ын туслалцаатайгаар зохион байгуулж, холбогдох зардлыг санхүүжүүлж²⁴ болно. Шалгарсан эхний төслүүдэд 10,0 сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр гарааны дэмжлэгийг 36 сарын хугацаатайгаар олгоно.

6.1.7. Шалгарсан багуудтай аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс гарааны дэмжлэг олгох тухай гэрээ байгуулж, хамтран ажиллана. Эхний жилд гарааны дэмжлэгийн эргэн төлөлт хийхгүй байж болох ба эргэн төлөлт²⁵ийн хуваарийг бүлгийн саналд үндэслэн боловсруулж, гэрээнд хавсаргана.

6.1.8. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг гарааны бизнес эрхлэх хүний цалин хөлсөнд болон шаардагдах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эргэлтийн хөрөнгө гэх мэт гэрээнд заасан зориулалтаар зарцуулна.

6.1.9. Сонгон шалгаруулалтад эхний байранд орсон багуудыг багцлан бүлэг болгож, 5 долоо хоногийн бизнес хурдасгуурын үйлчилгээнд хамруулж шинэлэг бизнес санаагаа хэрэгжүүлэх боломжтой нь нотлогдсон багуудад эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг, жижиг зээлийн үйлчилгээнд хамруулах арга хэмжээ үзүүлж болно.

6.1.10. Залуучуудын гарааны бизнесийг дэмжих арга хэмжээг зохион байгуулах үйл ажиллагааны зардлыг шалгаруулалтын үе болон бизнесийн зөвлөх /ментор/ ажиллуулах зардалд зарцуулах ба зөвлөх нь ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг, бизнесийн үйл ажиллагаа нь тогтворжсон орон нутгийн ажил олгогч байж болно.

²³ Гарааны бизнесийг дэмжих мэргэшсэн байгууллага, бизнес инкубатор болон бизнесийг дэмжих төвүүдийн жагсаалтыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар гаргана.

²⁴ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан «Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний зардлын жишиг хэмжээнээс хэтрүүлэхгүй.

²⁵ Гарааны дэмжлэгийн эргэн төлөлтийг аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлж зохих журмын дагуу хяналт тавьж ажиллана.

Долоо. Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах

7.1. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд эргэн төлөгдөх гарааны дэмжлэг авсан залуучууд болон залуучуудын бүлгийн бараа, бүтээгдэхүүнийг борлуулахад дэмжлэг үзүүлэх, ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлж болох ба энэхүү үйл ажиллагааг Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн 5 дугаар зүйлд заасны дагуу зохион байгуулна.

7.2. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь хөтөлбөрт хамрагдсан залуучуудын үйл ажиллагааг дэмжих, хэрэгжилтийн явцад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах ба хяналт тавих, хэрэгжүүлж буй арга хэмжээг сайжруулах зорилгоор залуучууд, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагууд, ажил олгогчдын оролцоотой туршлага солилцох уулзалт, хэлэлцүүлгийг жилд 2 удаа зохион байгуулж болно.

Найм. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн

8.1. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

8.1.1. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хөдөлмөр эрхлэх чадварыг нь үнэлсэн залуучуудын тоо, нас, хүйсээр;

8.1.2. Төвийн дэмжлэгтэйгээр хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө боловсруулсан ажил хайгч залуучуудын тоо, нас, хүйсээр;

8.1.3. Төвийн дэмжлэгтэйгээр хамтын ажиллагаа, сургалтад хамрагдсан ажил хайгч залуучуудын тоо, нас, хүйсээр;

8.1.4. Загвар төвийн дэмжлэгтэйгээр ажилд орсон ажил хайгч залуучуудын тоо, нас, хүйсээр;

8.1.5. Гарааны бизнесийг дэмжих бүлгийн гишүүдийн тоо, үйл ажиллагааны салбараар, нас, хүйсээр;

8.1.6. Гарааны бизнесийг дэмжих бэлтгэгдсэн сургагч багшийн тоо, нас, хүйсээр;

8.1.7. Санхүүгийн дэмжлэг авсан баг, төгсөгчдийн тоо, үйл ажиллагааны салбараар, нас, хүйсээр;

8.1.8. Борлуулалтын болон түрээсийн төлбөрийн хөнгөлөлт, сургалтад хамрагдсан баг, хүмүүсийн тоо, үйлчилгээний чиглэл тус бүрээр, нас, хүйсээр;

8.1.9. Шинээр байгуулагдсан аж ахуйн нэгж, бизнесийн бүлгийн тоо, шинээр бий болсон ажлын байрны тоо.

8.2. Хөтөлбөрийн хүрэх үр дүн

8.2.1. Залуучуудад зориулсан хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдсэн байна;

8.2.2. Залуучуудын гарааны бизнес, санхүүгийн дэмжлэгийн үр ашиг дээшилсэн байна;

8.2.3. Залуучуудын аж ахуй, бизнес, хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2019 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн
1 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралт

МАЛЧДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Нэг. Зорилго

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар цөөн малтай болон малгүй иргэдийг ажлын байртай болгоход хөтөлбөрийн зорилго оршино.

Хоёр. Хэрэгжүүлэх арга хэмжээ

2.1. Хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулна.
Үүнд:

2.1.1. Өрхийг малжуулах;

2.1.2. Мал маллагааны арга ажиллагаа, аж ахуй эрхлэлтийн сургалт туршлага солилцох уулзалт, арга хэмжээг зохион байгуулах;

2.1.3. Гэрээт малчин өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих.

Гурав. Өрхийг малжуулах арга хэмжээг зохион байгуулах

3.1. Өрхийг малжуулах арга хэмжээнд хөдөлмөрийн чадвартай, 18-45 насны 2-оос доошгүй гишүүнтэй, малгүй болон бог малд шилжүүлснээр 200 хүртэл толгой мал²⁶-тай “малчин”²⁷ өрхийг хамруулна.

3.2. Арга хэмжээнд хамрагдах өрх нь малгүй болон 150 хүртэл толгой малтай бол 5.0 сая төгрөг, 150-200 толгой малтай бол 4.0 сая төгрөгийн мал худалдан авах арга хэмжээг аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс²⁸ зохион байгуулна.

3.3. Санхүүгийн дэмжлэгийг мал худалдан авч өгснөөс хойш 36 сарын дотор хуваарийн дагуу 100 хувь эргүүлэн төлнө.

3.4. Арга хэмжээнд хамрагдах малчин өрхийг сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлийн саналыг үндэслэн аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс сонгож, гэрээ байгуулж ажиллах бөгөөд гэрээнд эргэн төлөлтийн хуваарийг иргэний хүсэлтийг үндэслэн тогтоож, гэрээнд хавсаргана. Хамрагдах малчин өрх нь төлөвлөгөө, төсөлтэй байна.

3.5. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь мал худалдан авч өгөх үйл ажиллагааг хуулийн дагуу нээлттэй, ил тод зохион байгуулна. Худалдан авч байгаа малын үнэ нь зах зээлийн дундаж үнээс илүүгүй байна.

²⁶ Мал тооллогын «А» дансанд бог малд шилжүүлснээр бүртгэгдсэнийг үндэслэнэ.

²⁷ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д заасны дагуу «мал аж ахуй эрхэлж үндсэн орлогоо олдог иргэн»-ийг хэлнэ.

²⁸ Алслагдсан 3 дүүргийг хамруулна.

3.6. Хэрэв малгүй болон 50 хүртэл толгой малтай малчин өрх малжуулах арга хэмжээнд хамрагдах бол мал аж ахуй эрхлэх дадлага, туршлагатай дадлагажуулагч малчинтай байна.

3.7. Өрх нь малжуулах арга хэмжээнд зөвхөн нэг удаа хамрагдана.

3.8. Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор тухайн иргэн, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс болон сумын Засаг дарга нар гурвалсан гэрээ байгуулж, хэрэгжилтийг дүгнэж ажиллана.

Дөрөв. Мал аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт, арга хэмжээг зохион байгуулах

4.1. Малжуулах арга хэмжээнд хамрагдсан өрхөд аж ахуй эрхлэлтийн²⁹ болон малын эрүүл мэнд, мал маллах арга ажиллагааны болон малын ашиг шимийг боловсруулах сургалт /мах, сүү цагаан идээ, ноос, арьс шир боловсруулах г.м/, туршлага солилцох уулзалт зохион байгуулах, малын хашаа, хороо барих, хадлан тэжээл, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зэрэг дэмжлэг, туслалцаа үзүүлэх бөгөөд энэхүү арга хэмжээний нийт зардал нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас энэхүү хөтөлбөрт хуваарилсан нийт хөрөнгийн 5 хувиас ихгүй байна.

4.2. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь сургалт зохион байгуулах эрх бүхий мэргэшсэн сургалтын байгууллагыг³⁰ сонгож, гэрээ байгуулан ажиллана. Мөн мал маллагаа, аж ахуй эрхлэлтийн сургалтаар мэргэшсэн эрх бүхий сургагч багшаар сургалтыг зохион байгуулж болно.

4.3. Туршлагатай сайн малчдаас суралцах, туршлага солилцох, дэлгэрүүлэх зорилготой уулзалт, хэлэлцүүлгийн төлөвлөгөөг хуваарилагдсан төсөвт багтаан тухайн аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөр батлуулан зохион байгуулж болно.

Тав. Гэрээт малчин өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг зохион байгуулах

5.1. Хот, суурингаас хөдөөд шилжин суурьшиж, мал маллах хүсэлтэй өрхийг цалин хөлстэй ажилд зуучилж, 2 жилийн хугацаанд тогтвортой ажлын байраар хангаж, орлоготой болгох арга хэмжээг зохион байгуулна.

5.2. Гэрээт малчин өрхийг ажиллуулах малчин болон гэрээт малчнаар ажиллах хүсэлтэй өрх дараах ерөнхий шаардлагыг хангасан байна.

5.2.1. Гэрээт малчин өрхийг ажиллуулах малчин нь бог малд шилжүүлснээр 600 болон түүнээс дээш тооны малтай³¹, гэрээгээр мал маллах өрхийг авч ажиллуулах хүсэлт гаргасан байна.

²⁹ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан «Аж ахуй эрхлэлтийн сургалтын зардлын дээд хэмжээ»-нээс хэтрүүлэхгүй байна.

³⁰ Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах эрх бүхий сургалтын байгууллагуудыг шалгаруулж, жагсаалт гаргана.

³¹ Мал тооллогын «А» дансанд бүртгэгдсэнийг үндэслэнэ.

5.2.2. Гэрээт малчин өрх нь 18-59 насны хөдөлмөрийн чадвартай 2-оос доошгүй гишүүнтэй, гэр бүлээрээ хөдөөд шилжин суурьшиж, 2-оос доошгүй жил гэрээт малчнаар ажиллах нөхцөлийг зөвшөөрч хүсэлт гаргасан байна.

5.3. Ажил олгогч малчин нь гэрээт малчин өрхийн 2 гишүүнийг сард хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доошгүй үндсэн цалинтай байхаар харилцан тохиролцож, цалин хөлсийг сар бүр мөнгөн хэлбэрээр олгоно.

5.4. Ажил олгогч малчин нь гэрээт малчин өрхийн 2 гишүүнтэй хөлсөөр ажиллах болон хөдөлмөрийн гэрээний аль нэгийг байгуулна. Гэрээнд мал маллахаас гадна төл хүлээн авах, бойжуулах, мах, сүү, ноос, ноолуур зэрэг малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн бэлтгэх, боловсруулах, хадлан тэжээл, худаг ус, отор нүүдэл зэрэг бусад дагалдах ажилд гэрээт малчин өрхийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг нарийвчлан тусгана.

5.5. Ажил олгогч малчин нь хүлээн авсан төл, бэлтгэж боловсруулсан малын гаралтай түүхий эд, мах, сүү, цагаан идээ зэргийг борлуулснаас олсон орлогоос гэрээт малчин өрхөд мөнгөн болон биет хэлбэрээр урамшуулал олгоно. Үүнийг хөлсөөр ажиллах болон хөдөлмөрийн гэрээнд тусгасан байна.

5.6. Ажил олгогч болон гэрээт малчин өрхийн нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн зардлыг тухайн аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нөхөн олгоно. Гэрээт малчин хувь хүний орлогын албан татварыг өөрөө төлнө.

/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/

5.7. Нөхөн олговрыг малчин ажил олгогч болон гэрээт малчны нийгмийн даатгалын шимтгэл төлсөн баримт, энэхүү хөтөлбөрийн 5.4-т заасан гэрээг үндэслэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан зардлын жишгээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд хуваарилсан хөрөнгөөс олгоно.

/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/

5.8. Гэрээт малчин өрхийн гишүүд нь тухайн оршин суух газартаа түр шилжүүлэг хийлгэх болон нийгмийн даатгалын дэвтэр авах зэрэг бусад зардлыг өөрөө хариуцна.

5.9. Байгалийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас мал зүй бусаар хорогдох болон бусад эрсдэлээс учирсан хохирлыг гэрээт малчин хариуцахгүй, бусад шалтгаанаар мал хорогдсон, алдагдсан зэрэг тохиолдолд хүлээх хариуцлагыг 2 тал харилцан тохирч гэрээнд тусгана.

5.10. Ажил олгогч малчин нь гэрээт малчин өрхийн сургуулийн насны хүүхдийг сургууль завсардуулахгүй байх, бага насны хүүхдээ харж хандах нөхцлийг бүрдүүлэх ба тухайн сумын Засаг дарга, холбогдох байгууллага нь хүүхдийг сургуулийн дотуур байраар хангана.

5.11. Арга хэмжээнд зарцуулагдах хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, гэрээний талууд хүлээсэн үүргээ биелүүлээгүй, бичиг баримт хуурамчаар үйлдсэн болон бусад зөрчил, дутагдал гаргасан нь холбогдох байгууллагуудаас хийсэн хяналт шалгалтаар тогтоогдвол олгосон санхүүжилтийг буцаан төлүүлж, буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5.12. Арга хэмжээнд хамрагдах малчин өрхөд дараах дэмжлэг, сургалтийг зохион байгуулна. Үүнд:

5.12.1. Шилжин суурьшиж байгаа аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар гэрээт малчин өрхийн тухайн орон нутагт нүүж очих зардлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан зардлын жишгийг үндэслэн олгоно.

/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/

5.12.2. Гэрээт малчин өрхийн хэрэгцээний уналга, эдэлгээний малыг малчин ажил олгогч хариуцна.

5.12.3. Хөтөлбөрийн 4.1-т заасан мал маллагааны болон сүү, цагаан идээ боловсруулах сургалтад өөрийнх нь хүсэлтээр хамруулна.

5.12.4. Гэрээний зүйл, заалтыг амжилттай хэрэгжүүлсэн ажил олгогч малчин болон гэрээт малчин гэр бүлийн туршлагыг дараагийн төсөл хэрэгжүүлэх газруудад загвар болгон судлуулах, тэднийг ижил төстэй төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчдийн уулзалт, сургалт, зөвлөгөөнд оролцуулах, арга туршлагыг хэвлэн нийтлэх, түгээх ажлыг зохион байгуулна.

Тав. Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн

5.1. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

5.1.1. Малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрх, өрхийн гишүүд, олгосон малын тоо, төрлөөр, арга хэмжээнд хамрагдсанаас хойш 24 сарын дараах малын тоо, орлогын дүнгээр;

5.1.2. Шавь сургалтад хамрагдсан малчин өрх, өрхийн гишүүдийн тоо, хүйсээр, шавь сургалт хийсэн дадлагажуулагч малчны тоо;

5.1.3. Мал аж ахуй эрхлэлтийн болон мал маллах арга ажиллагааны сургалтад хамрагдсан малчин өрх, өрхийн гишүүдийн тоо, хүйсээр;

5.1.4. Туршлага солилцох уулзалт, хэлэлцүүлэгт хамрагдсан малчин өрхийн тоо, гишүүдийн тоо;

5.1.5. Гэрээт малчин өрх болон малчин ажил олгогчийн тоо, маллуулсан малын төрөл, зарцуулсан хөрөнгө.

5.2. Хөтөлбөрийн хүрэх үр дүн

5.2.1. Малжуулах арга хэмжээнд залуу малчид хамрагдаж, амьжиргаа нь дээшилсэн байна.

5.2.2. Туршлага солилцох уулзалт болон сургалтуудыг зохион байгуулснаар ахмад, туршлагатай малчдаас суралцаж, мал маллах арга ажиллагааны чадвар, мэдлэг, дээшилсэн байна.

5.2.3. Гэрээт малчин өрх нь хот, аймаг, сумаас хөдөөд шилжин суурьшиж, тогтвортой ажлын байраар хангагдаж, тогтмол орлоготой болсон байна.

5.2.4. Төсөлд хамрагдсан өрхийн гишүүд малчдын туршлагаас суралцаж, мал маллах арга ажиллагааны чадвар, мэдлэг нь дээшилсэн байна.

--ooOoo--

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2019 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн
1 дүгээр тогтоолын тавдугаар хавсралт

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Нэг. Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэх, дэмжлэгтэйгээр ажилд зуучлах, тэдний аж ахуй эрхлэлт болон хөдөлмөр эрхлэх үр чадвар олгох сургалтад хамруулах, урамшуулал, санхүүгийн дэмжлэг, хөдөлмөр эрхлэлтийн тусгай үйлчилгээ, арга хэмжээнд хамруулж дэмжлэг үзүүлэх замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан байнгын ажлын байрыг нэмэгдүүлэх, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд хөтөлбөрийн зорилго оршино.

Хоёр. Хамрах хүрээ, хэрэгжүүлэх арга хэмжээ

2.1. Хөтөлбөрт доорх иргэдийг хамруулна. Үүнд:

2.1.1. “Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан³²”, эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хүчин төгөлдөр шийдвэртэй, бичгээр хандсан хөгжлийн бэрхшээлтэй хүн;

2.1.2. Байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг эх;

2.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангаж буй ажил олгогч.

2.2. Хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулна. Үүнд:

2.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний аж ахуй, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;

2.2.2. Ажил олгогчийг дэмжих.

Гурав. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих арга хэмжээг зохион байгуулах

3.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих дараах арга хэмжээг зохион байгуулна. Үүнд:

3.1.1. Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ зохион байгуулах;

3.1.2. Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээ үзүүлэх;

3.1.3. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох;

3.1.4. Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг үзүүлэх;

3.1.5. Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах;

³² Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн

3.1.6. Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах.

3.2. Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээг зохион байгуулах

3.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, сургууль завсардсан, хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхдэд сэтгэл зүй, хувь хүний төлөвшил, нийгэм, хамт олны дунд биеэ авч явах тухай сургалт, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хүнтэй харилцах, өөрийгөө ойлгуулах чадвар эзэмшүүлэх, хөдөлмөрийн харилцааны анхан шатны зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн дэг журам, аюулгүй ажиллагааны мэдлэг олгоно.

3.2.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ганцаарчилсан болон бүлгийн зохион байгуулалттайгаар хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд хамруулна. Үргэлжлэх хугацаа нь хөгжлийн бэрхшээлийн төрлөөс шалтгаалан ажлын 5-10 хоног хүртэл байна.

3.2.3. Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн жилд нэг удаа хамрагдана.

3.2.4. Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээг эрх бүхий³³ хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно.

3.2.5. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд хамруулсны дараа ажилд зуучлах үйлчилгээ үзүүлнэ.

/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан/

3.3. Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээ үзүүлэх

3.3.1. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт нийцүүлэн, ажил олгогчийн эрэлт хэрэгцээнд үндэслэн ажилд зуучлах үйлчилгээг ганцаарчилсан болон хэсэг, бүлгээр зохион байгуулна.

3.3.2. Шаардлагатай тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүсэлтийг харгалзан хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд хамруулах, ажлын ярилцлагад ороход туслах, ажлын байр, ажил олгогчтой танилцуулах зорилгоор хөтөч³⁴, дохионы хэлмэрч³⁵ ажиллуулж болох бөгөөд хөтөч, дохионы хэлмэрч нь сургалтад хамрагдсан байна.

3.3.3. Хөтөч, дохионы хэлмэрч, чиглүүлэгч болон орон зайн чиг баримжааны сургагч багшийг бэлтгэх сургалтыг нийслэлд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, орон нутагт Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар мэргэжлийн байгууллагатай гэрээ

³³ Тухайн салбар, мэргэжлээр сургалт явуулахаар бүртгэгдсэн эрх бүхий мэргэшсэн байгууллага

³⁴ «Хөтөч» гэж хараагүй хүн тухайн орчинд зөв чиг баримжаатай, саадгүй, аюулгүй зорчиход нь туслах хүнийг,

³⁵ «Дохионы хэлний хэлмэрч, орчуулагч» гэж сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний дохионы хэлийг хэлмэрчилдэг хүнийг хэлнэ.

байгуулж, зардлын жишиг хэмжээ³⁶нд нийцүүлэн зохион байгуулна.

/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор өөрчилсөн/

3.3.4. Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах, хөтөч, дохионы хэлмэрч, чиглүүлэгчийн үйлчилгээг тухайн орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

3.4. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг зохион байгуулах

3.4.1. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг олон нийтэд 3 долоо хоногоос доошгүй хугацааны өмнөөс тухайн нутаг дэвсгэрийн иргэд, олон нийтэд зар мэдээлэл, сурталчилгаа хийнэ.

3.4.2. Энэхүү арга хэмжээг жил бүрийн эхний болон гуравдугаар улиралд тус тус багтаан аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс зохион байгуулна.

3.4.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, байнгын асаргаанд байдаг хүүхдээ асарч буй эцэг, эх нь хувиараа болон бүлэг, нөхөрлөл, хоршооны хэлбэрээр өрхийн үйлдвэрлэл, аж ахуй, бичил бизнес, газар тариалан, фермерийн аж ахуй эрхлэх төслөө Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст хүргүүлнэ.

3.4.4. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлт гаргасан иргэдийг бүртгэн аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулсны дараа төслүүдийг хүлээн авна.

3.4.5. Төсөл шалгаруулах үе шат бүрийг ил тод, нээлттэй оролцоог хангаж зохион байгуулна. Эхний шатанд төслийн баримт бичгийн бүрдэл, тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхэд ажлын хэсэг үнэлгээ өгнө. Шаардлага хангасан төслүүдийг төслийн санал ирүүлсэн иргэдийн үнэлгээг харгалзан сонгон шалгаруулна.

3.4.6. Санхүүгийн дэмжлэгт хамрагдах төслийн урьдчилсан үнэлгээ хийх, сонгон шалгаруулах ажлын хэсгийг 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байгуулах бөгөөд тэдгээрийн 30-аас доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, хөгжлийг дэмжих чиглэлээр тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөлөл байна.

3.4.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих төслийн санхүүгийн дэмжлэгийн хэмжээ 1.0-5.0 хүртэл сая тогрөг байх ба дэмжлэгийг 4 хүртэл жилийн хугацаанд 50³⁷ хувь эргэн төлнө. Иргэний саналыг үндэслэн эргэн төлөлтийн хуваарийг гэрээнд хавсарган баталгаалжуулна.

³⁶ Сургалтын зардлын жишиг хэмжээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд батална.

³⁷ Засгийн газрын 2016 оны 276 дугаар тогтоолоор баталсан «Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам»-ын 5.3 дахь хэсэг

/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/

3.4.8. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь төслийн сонгон шалгаруулалтын дүн, шийдвэрийг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэх бөгөөд сонгон шалгаруулалттай холбоотой гарсан маргааныг хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

3.5. Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах

3.5.1. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар нь бичил бизнес эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүсэлтэд үндэслэн боловсруулсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулахад дэмжлэг үзүүлэх болон ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтөд хамруулах арга хэмжээг зохион байгуулна.

/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан/

3.5.2. Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтөд үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ажлын байр түрээслэн 6 сараас дээш хугацаагаар тасралтгүй үйл ажиллагаа эрхэлсэн хувиараа хөдөлмөр эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг, мөн нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байдаг нөхөрлөл, хоршоо, бизнес инкубатор төвийн бойжигчийг хамруулна.

3.5.3. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь холбогдох баримт бичиг, түрээсийн гэрээг үндэслэн нөхцөл байдлыг газар дээр нь тодорхойлсны үндсэн дээр ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг³⁸ нөхөн олгоно. Түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг нөхөн олгоходоо тухайн төлбөрийг төлсөн баримтыг үндэслэнэ.

3.5.4. Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдсан иргэн, нөхөрлөл, хоршоо, бизнес инкубаторын бойжигч нь 24 сарын хугацаанд энэхүү хөнгөлөлтөд дахин хамрагдахгүй.

3.5.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулахад дэмжлэг үзүүлэх үзэсгэлэн, яармагийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар зохион байгуулах бөгөөд шаардлагатай бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, хөгжлийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж болно.

/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан/

³⁸ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан «Түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх нэг сарын зардлын дээд хэмжээ»-нээс хэтрүүлэхгүй байна.

3.6. Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах

3.6.1. Аж ахуй эрхлэлтийн сургалтад энэхүү хөтөлбөрийн 3.4-т заасан санхүүгийн дэмжлэгт хамрагдсан болон бичил бизнес эрхэлдэг, цаашид эрхлэх хүсэл сонирхолтой хөгжлийн бэрхшээлтэй иргэн, байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчийг хүсэлтийн дагуу хамруулна.

3.6.2. Эрх бүхий мэргэшсэн, боломжит тохируулгатай сургалтын орчин бүрдсэн мэргэжлийн эрх бүхий байгууллага³⁹, иргэнтэй гэрээ байгуулан 3-5 хоногийн хугацаанд зохион байгуулна.

3.7. Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах

3.7.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг мэргэжлийн ур чадвар, чадамжийг 1-10 сарын хугацаанд багтаан эрх бүхий мэргэшсэн, боломжит тохируулгатай сургалтын орчин бүрдсэн мэргэжлийн байгууллага, иргэнтэй гэрээлэн гүйцэтгүүлэх бөгөөд уг сургалт нь модуль хэлбэртэй тусгайлсан сургалтын хөтөлбөрт суурилсан байна.

3.7.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг мэргэжлийн чадамж эзэмшүүлэх, үйлдвэрлэл дээрх ажлын байрны зэрэг тухайн хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирсон төрөл хэлбэрийг сонгон зохион байгуулна. Энэхүү арга хэмжээний хүрээнд хөтөч, дохионы хэлмэрчийг бэлтгэх, хараагүй хүмүүсийн орон зайн чиг баримжаа олгох сургалт болон хөгжлийн бэрхшээлийн бусад төрөл хэлбэрийн онцлогт тохирсон нэмэлт сургалтыг хийж болно.

3.7.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт нийцүүлэн мэргэжлийн ур чадварын тусгайлсан сургалтыг Улаанбаатар хотод Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, аймаг болон алслагдсан 3 дүүрэгт Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэргэжлийн сургалт зохион байгуулах дадлага, туршлага бүхий сургалтын байгууллагаар гэрээний үндсэн дээр зохион байгуулна.

/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/

3.7.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийн сургалтад ногдох зардлын жишгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд тогтооно.

³⁹ Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь аж ахуй эрхлэлтийн сургалтыг зохион байгуулах мэргэшсэн байгууллагуудын нэгдсэн жагсаалт гаргана.

⁴⁰ Ажил олгогч гэж эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг бие даан гаргаж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнээсээ олсон ашиг буюу ашиг олох боломжоос шууд хамаарах бизнестээ урт хугацаагаар нэг буюу түүнээс дээш ажилтныг хөдөлмөрийн болон бусад гэрээ, тохиролцооны үндсэн дээр авч ажиллуулж буй эзэн, байгууллагын удирдлагыг хамруулна.

Энэхүү арга хэмжээнд Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалтын үйлдвэр болон төсвөөс санхүүждэггүй төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад төсвийн байгууллага, ажил олгогч

3.7.5. Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд “Мэргэжлийн сургалтын чадамж, мэргэжил эзэмшсэн төгсөгч, иргэдийн мэргэшлийн түвшинг үнэлэх, баталгаажуулах журам”-ын дагуу ур чадварын шалгалтыг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв зохих журмын дагуу зохион байгуулж, “Чадамжийн гэрчилгээ” олгоно.

3.7.6. Мэргэжлийн сургалт зохион байгуулах байгууллагын сургалтын хөтөлбөр, сургалт зохион байгуулах танхим, хэрэглэгдэхүүнийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар хянаж, хөдөлмөр эрхлэлтийн сургалтын мэргэшсэн байгууллагуудын жагсаалтыг гаргана.

/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан/

Дөрөв. Ажил олгогчийг дэмжих арга хэмжээг зохион байгуулах

4.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан ажил олгогчийг дэмжих дараах арга хэмжээг зохион байгуулна. Үүнд:

4.1.1. Урамшуулал олгох;

4.1.2. Санхүүгийн дэмжлэг олгох.

4.2. Урамшуулал олгох арга хэмжээг зохион байгуулах

4.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тусгайлсан байнгын ажлын байраар хангасан дор дурдсан нөхцөл, шаардлагыг хангасан ажил олгогчид⁴⁰ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг нэг удаа олгоно. Үүнд:

А. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 1 дэх заалтад зааснаас цөөн буюу 25 хүртэл ажилтантай ажил олгогч хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан бол байнгын ажлын байраар хангасан хүний тоогоор;

Б. 25 болон түүнээс дээш тооны ажилтантай ажил олгогч Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 1 дэх заалтаар тогтоосон хувиас давсан хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан бол хуулиар тогтоосон хувиас давсан байнгын ажлын байраар хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүний тоогоор тус тус урамшууллыг олгоно.

⁴⁰ Ажил олгогч гэж эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг бие даан гаргаж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнээсээ олсон ашиг буюу ашиг олох боломжоос шууд хамаарах бизнестээ урт хугацаагаар нэг буюу түүнээс дээш ажилтныг хөдөлмөрийн болон бусад гэрээ, тохиролцооны үндсэн дээр авч ажиллуулж буй эзэн, байгууллагын удирдлагыг хамруулна.

Энэхүү арга хэмжээнд Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалтын үйлдвэр болон төсвөөс санхүүждэггүй төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад төсвийн байгууллага, ажил олгогч малчин, төрийн бус байгууллага хамаарахгүй.

4.2.2. Ажил олгогч хөгжлийн бэрхшээлтэй, ажилгүй иргэнийг ажлын байраар хангах тухайгаа тухайн иргэний харьяалах аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст мэдэгдэн гэрээг байгуулж, холбогдох урамшууллыг авна.

4.3. Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг зохион байгуулах

4.3.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт нийцүүлсэн байнгын ажлын байр бий болгох зорилгоор боловсруулсан аж ахуйн нэгжийн төслийг зохих журмын дагуу шалгаруулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэний нэг ажлын байранд 5.0 сая хүртэл төгрөгөөр тооцон, 10.0-20.0 хүртэл сая төгрөгийг 100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй олгоно.

/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/

4.2.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах, ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилго бүхий үйл ажиллагаа эрхэлдэг, ашгийн бус төрийн бус байгууллагын ажлын байр бий болгох төслийг зохих журмын дагуу шалгаруулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэний нэг ажлын байранд 5.0 хүртэлх сая төгрөгөөр тооцон 5.0-20.0 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгоно.

/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/

4.3.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөл нь аж ахуйн нэгж болон төрийн бус байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх төслүүдийг шалгаруулах ажлын хэсэг, тэргүүлэх чиглэл, төсөлд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлно. Мөн энэхүү арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг хөгжлийн бэрхшээлийн төрөлд ногдох хувийг тогтооно.

4.3.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар нь санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулалтыг жилд 1-2 удаа зохион байгуулна.

4.3.5. Төсөл сонгон шалгаруулах үнэлгээний хороонд төрийн бус байгууллагуудын төлөөллийг “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөл”-ийн санал болгосноор оролцуулна.

4.4. Урамшуулал болон санхүүгийн дэмжлэгт хамрагдаж буй ажил олгогч, иргэнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад дэмжлэг, урамшууллыг давхардуулж олгохгүй⁴¹.

Тав. Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн

5.1. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

5.1.1. Хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо хүйсээр, байгууллагын тоо, сургалтын төрлөөр;

⁴¹ Санхүүгийн дэмжлэгт хамрагдсанаас хойш 2 жилийн дотор хамрагдахгүй.

5.1.2. Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, ажилд зуучлагдсан хүний тоо хүйсээр, ажил олгогчийн өмчийн хэлбэрээр, хөтөч ашигласан хүний тоо, хүйсээр, хөтөч, дохионы хэлмэрчээр ажилласан хүний тоо, хүйсээр, давтамж цагаар;

5.1.3. Аж ахуй эрхлэлтийн сургалт, Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдсан хүний тоо, хүйсээр, сургалтын төрлөөр, мэргэжлээр;

5.1.4. Иргэн болон бүлэг нөхөрлөл, хоршооны хэлбэрээр өрхийн үйлдвэрлэл, аж ахуй эрхлэх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан төсөл, хамрагдсан хүний тоо, үүнээс хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, хүйсээр, салбараар;

5.1.5. Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт, үзэсгэлэн, яармагт хамрагдсан бүлэг, нөхөрлөл, хоршоо, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо;

5.1.6. Санхүүгийн дэмжлэг, урамшуулалд хамрагдсан аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, шинээр бий болгосон тохируулгатай ажлын байрны тоо, байнгын ажлын байраар хангагдсан хүний тоо мэргэжлээр, салбараар.

5.2. Хөтөлбөрийн үр дүн

5.2.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байр нэмэгдсэн байна;

5.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аж ахуй, хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна;

5.2.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эхийн аж ахуй эрхлэлт, өрхийн орлого өссөн байна.

--ooOoo--

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2019 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн
1 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралт

АХМАД МЭРГЭЖИЛТНИЙ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Нэг. Зорилго

Ахмад мэргэжилтнүүдийн хүсэлтэд үндэслэн ажил, хөдөлмөрт оролцох оролцоог нэмэгдүүлж, мэдээллийн сан үүсгэн, тэдний мэдлэг, ажлын туршлагыг өвлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, өсвөр хойч, залуу үеийнхэнд хөдөлмөрийн дадал олгох чиглэлээр ажиллуулж, орлогын дэмжлэг үзүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Хоёр. Хөтөлбөрийн хамрах хүрээ

2.1. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст хүсэлт гарган мэдээллийн санд бүртгүүлсэн тэтгэвэрийн насны ахмад мэргэжилтнүүд;

2.2. Ахмад настны эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, холбоод.

Гурав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг зохион байгуулах⁴²;

3.2. Ахмадын төрийн бус байгууллагуудаар зөвлөх үйлчилгээг зохион байгуулах,

3.3. Аж ахуй болон өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд нь зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгох.

Дөрөв. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг зохион байгуулах

4.1. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төслийн тавигдах шаардлагыг холбогдох мэдээллийн хамт нийтэд ил тод зарлан мэдээлж, зохион байгуулах ба аймаг, нийслэл, дүүргүүд тус бүрт 15 хүртэлх төслийг сонгон шалгаруулна.

4.2. Ахмад мэргэжилтний зөвлөн туслах үйл ажиллагаа шаардлагатай байгаа боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй болон төрийн захиргааны салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд /эрэлт хэрэгцээгээ ирүүлэхийг хүссэн урилга, мэдээлэл хүргүүлсэн байх/ зөвлөх үйлчилгээ авах хэрэгцээ, шаардлага, ажлын цар хүрээг тодорхойлсон төслийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст ирүүлнэ.

⁴² Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь «Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд хамрагдах зөвлөхүүдийн мэдээллийн нэгдсэн сан»-г үүсгэж, хяналт тавьж ажиллана.

4.3. Төсөлд хамрагдан ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ үзүүлж буй ахмадад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан зардлын жишиг хэмжээгээр⁴³ ажилласан цагийн урамшууллыг тооцож, төсөлд хамрагдсан байгууллагын ирүүлсэн тайлан, ажлын цагийн бүртгэлд үндэслэн урамшууллыг ахмад мэргэжилтэнд шууд олгох ба нийтийг хамарсан ажил зохион байгуулах журмын дагуу нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй.

4.4. Зөвлөх мэргэжилтний төслийн хүрээнд олгох урамшууллыг тооцохдоо нэг жил хүртэлх хугацаанд ажлын 30 өдөр буюу нийт 240 цагаас хэтрэхгүй байхыг төсөл, холбогдох гэрээнд тусган ажиллана.

4.5. Тухайн төсөлд хамрагдаж буй ахмад мэргэжилтэн өөрийн эзэмшсэн ур чадвар, туршлагад үндэслэн хөтөлбөрийн 4.2-г заасан салбаруудаас давхардуулахгүй сонгож зөвлөх үйлчилгээ үзүүлнэ.

4.6. Төсөл хэрэгжүүлэгч ахмад мэргэжилтэнд аймаг, сум орон нутгийн захиргаа, бусад байгууллагаас үйл ажиллагаа явуулах байр, техник хэрэгсэл, ажиллах нөхцөл, шаардагдах материал түүхий эд, санхүүгийн болон дэмжлэг үзүүлэх ба гүйцэтгэж буй ажил, үүрэгтэй нь уялдуулан нэмэлт цалин хөлсийг зохих хууль тогтоомжийн дагуу олгож болно.

Тав. Ахмадын төрийн бус байгууллагаар зөвлөх үйлчилгээг зохион байгуулах

5.1. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь бүтээн байгуулалт болон бусад салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудад ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ үзүүлэх ахмадын багийг улсын хэмжээнд үйл ажиллагаа эрхэлдэг ахмадын эрх ашгийг хамгаалсан холбоодтой хамтран ажиллах гэрээний үндсэн дээр зохион байгуулна.

5.2. Зөвлөх үйлчилгээний төслийг хэрэгжүүлэх ахмад настны эрх ашгийг хамгаалах холбоо нь тухайн зөвлөх үйлчилгээний чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмж үзүүлэх мэргэжлийн өндөр ур чадвартай баг, бүрэлдэхүүнтэй байна.

5.3. Ахмад мэргэжилтний багийн зөвлөх үйлчилгээний төсөл хэрэгжүүлэх ахмадын төрийн бус байгууллага нь төсөлд хамрагдах хүний тоо, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллах төр хувийн хэвшлийн байгууллагын хүсэлт, ажиллах байршил, гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төслийн холбогдох баримт бичгийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт ирүүлнэ.

5.4. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь зөвлөх үйлчилгээний захиалгад үндэслэн ирүүлсэн төслийг сонгон шалгаруулж, төсөлд хамрагдах ахмад мэргэшсэн зөвлөх мэргэжилтнүүдийг “Ахмад мэргэшсэн зөвлөхүүдийн нэгдсэн мэдээллийн сан”-д бүртгэнэ. Төслийн зориулалтаар хуваарилагдсан хөрөнгө, түүний зарцуулалт олон нийтэд ил тод, нээлттэй байна.

⁴³ Нийтийг хамарсан ажлын цагийн хөлс болон журмын дагуу тооцож олгоно.

5.5. Төслийн үйл ажиллагаа эхлэхэд санхүүжилтийн 70 хувийг, төслийн явц, үр дүнг үндэслэн үлдэгдэл 30 хувийг санхүүжүүлнэ.

5.6. Төслийн үйл ажиллагаанд ахмадын баг, бүлгийг ажиллуулах ажил олгогч, төрийн захиргаа үйлчилгээний байгууллага нь ажиллах нөхцөл, байр, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах болон ажлын нэмэгдэл хөлс, цалинг олгож болно.

5.7. Энэхүү арга хэмжээнд хамрагдаж буй ахмад мэргэжилтнүүд нь аймаг, орон нутагт хэрэгжүүлэх ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төсөлд давхардан хамрагдахгүй.

Зургаа. Аж ахуй, өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд нь зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгох

6.1. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь ахмадуудын төслийн тавигдах шаардлагыг холбогдох мэдээллийн хамт нийтэд ил тод зарлан мэдээлж, 2 дугаар улиралд багтаан зохион байгуулах ба аймаг, нийслэл, дүүргүүд тус бүрт 10 хүртэлх төслийг сонгон шалгаруулна.

6.2. Ахмад нь аж ахуй болон өрхийн үйлдвэрлэл эрхлэх зорилгоор боловсруулсан төслөө харьяа аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст ирүүлэх ба төсөлд олгох эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг⁴⁴ нь 3.0 сая хүртэл төгрөг байна.

6.3. Санхүүгийн дэмжлэг нь 24 сарын дотор 100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй байх бөгөөд эргэн төлөлтийн хуваарийг иргэний саналыг үндэслэн тогтоож, холбогдох гэрээнд тусгана.

Долоо. Төслийн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн

7.1. Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр тооцно. Үүнд:

7.1.1. Төсөл, зөвлөх үйлчилгээнд хамрагдсан ахмад мэргэжилтнүүдийн тоо, нас, хүйс, салбар, мэргэжлээр;

7.1.2. Бүтээн байгуулалтад ажилласан ахмад мэргэжилтний зөвлөх багийн тоо, салбар, мэргэжлээр;

7.1.3. Зөвлөх үйлчилгээнд хамрагдсан ахмад настны төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын тоо, салбар, мэргэжлээр;

7.1.4. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан хүний тоо.

7.2. Хөтөлбөрийн хүрэх үр дүн

7.2.1. Ахмад мэргэжилтэн нь ажлын байраар хангагдаж, орлого нэмэгдсэн байна.

7.2.2. Ахмад мэргэжилтний мэдээллийн сан бий болсон байна.

7.2.3. Ахмад настны хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна.

⁴⁴ Ахмад нь эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт нэг удаа



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 1 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар № 01

Улаанбаатар хот

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРТ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ТӨСӨВ БАТЛАХ ТУХАЙ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28.8, Засгийн газрын 2016 оны 276 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 2.11, 5.3 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 4.6 дахь заалтыг тус тус үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны төсвийн гүйцэтгэл, 2020 оны төсвийн хуваарийн төслийг хэлэлцээд 2019 оны төсвийн гүйцэтгэлийг нэгдүгээр, 2020 оны төсвийн хуваарийг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус батлахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн даргад зөвлөмж болгосугай.

2. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-т тусгах нэмэлт, өөрчлөлтийг гуравдугаар хавсралт ёсоор баталсугай.

3. Залуучуудыг тогтвортой ажлын байраар хангаж байгаа ажил олгогчийг дэмжих, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр тусгайлсан хөтөлбөр, арга хэмжээний санал боловсруулж, танилцуулахыг Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ц.Амартөгс/-т, сум, хороонд хөдөлмөр эрхлэлтийн

үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, хүний нөөцийг оновчтой зохион байгуулах талаар санал танилцуулахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Т.Бадрахбаяр/-т тус тус даалгасугай.

4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны батлагдсан төсвийн хүрээнд санхүүжилтийг хуваарилан, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Т.Бадрахбаяр/-т, хэрэгжилтийг хангаж, тайлагнаж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн дарга нарт тус тус даалгасугай.

5. Гэрээт малчин өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих болон зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, зөвлөн туслах, мэдээлэл сурталчилгааг өргөжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг улирал бүр тайлагнаж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Т.Бадрахбаяр/, аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,
САЙД

С.ЧИНЗОРИГ

Үндэсний зөвлөлийн нарийн
бичгийн дарга

Д.ХАДХҮҮ

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 01
дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТҮҮД

Нэг. “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”

1.1. Хөтөлбөрийн 10.2-т “... Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар туршилтаар Ажил, мэргэжлийн мэдээллийн төвд төрийн бус байгууллагаар дамжуулан...” гэснийг хасах;

1.2. Хөтөлбөрийн 10.4-г “Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, ...” гэснийг хасах.

Хоёр. “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”

2.1. Хөтөлбөрийн 6.1-д “... дараах байдлаар 1-2 удаа зохион байгуулж, хэрэгжүүлнэ.” гэснийг “... дараах байдлаар жилд 2-с доошгүй удаа зохион байгуулж, хэрэгжүүлнэ.” гэж өөрчлөх;

2.2. Хөтөлбөрийн 6.1.3-г “Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/хэлтэс гарааны бизнес эхлүүлэх хүсэлтэй залуучууд (их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагч, төгсөгчид, 15-34 насны залуучууд)-дад мэдээлэл хүргэх, бүртгэх, бүлэг байгуулах арга хэмжээг хариуцах ба мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, политехник коллежийн суралцагчдын бүлгийг сургалтын байгууллагатай нь хамтран зохион байгуулна.” гэж өөрчлөх.

Гурав. “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”

3.1. Хөтөлбөрийн 5.6-г “Ажил олгогч болон гэрээт малчин өрхийн нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн зардлыг тухайн аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нөхөн олгоно. Гэрээт малчин хувь хүний орлогын албан татварыг өөрөө төлнө.” гэж өөрчлөн найруулах;

3.2. Хөтөлбөрийн 5.7-г “Нөхөн олговрыг малчин ажил олгогч болон гэрээт малчны нийгмийн даатгалын шимтгэл төлсөн баримт, энэхүү хөтөлбөрийн 5.4-т заасан гэрээг үндэслэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан зардлын жишгээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд хуваарилсан хөрөнгөөс олгоно.” гэж өөрчлөн найруулах;

3.3. Хөтөлбөрийн 5.12.1-г “Шилжин суурьшиж байгаа аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар гэрээт малчин өрхийн тухайн орон нутагт нүүж очих зардлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан зардлын жишгийг үндэслэн олгоно.” гэж өөрчлөн найруулах.

Дөрөв. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”

4.1. Хөтөлбөрийн 3.2.5-д “Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс...” гэсний дараа “..., Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар...” гэж нэмэх;

4.2. Хөтөлбөрийн 3.3.3-т “... нийслэлд Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, ...” гэснийг “... нийслэлд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, ...” гэж өөрчлөх;

4.3. Хөтөлбөрийн 3.4.7-д “... 5.0 хүртэл сая төгрөг...” гэснийг “... 1.0-5.0 хүртэл сая төгрөг...” гэж, “... 100 хувь эргэн төлнө.” гэснийг “... 50 хувийг эргэн төлнө.” гэж тус тус өөрчлөх;

4.4. Хөтөлбөрийн 3.5.1-д “Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс ...” гэсний дараа “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар ...” гэж нэмэх;

4.5. Хөтөлбөрийн 3.5.5-д “... Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс ...” гэсний дараа “... Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар...” гэж нэмэх;

4.6. Хөтөлбөрийн 3.7.3-т “... сургалтыг Улаанбаатар хотод Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, ...” гэснийг “... сургалтыг Улаанбаатар хотод Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, ...” гэж өөрчлөх;

4.7. Хөтөлбөрийн 3.7.6-д “Мэргэжлийн сургалт зохион байгуулах байгууллагын сургалтын хөтөлбөр, сургалт зохион байгуулах танхим, хэрэглэгдэхүүнийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар хянаж, хөдөлмөр эрхлэлтийн сургалтын мэргэшсэн байгууллагуудын жагсаалтыг гаргана.” гэсэн заалтыг нэмэх;

4.8. Хөтөлбөрийн 4.3.1-т “... 50.0 хүртэл сая төгрөгийг...” гэснийг “... 10.0-20.0 хүртэл сая төгрөгийг...” гэж өөрчлөх;

4.9. Хөтөлбөрийн 4.3.2-т “... 30.0 хүртэл сая төгрөгийн” гэснийг “... 5.0-20.0 хүртэл сая төгрөгийн...” гэж өөрчлөх.



**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ**

2019 оны 03 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар № А/83

Улаанбаатар хот

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙГ 2019-2020
ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ НЭГДСЭН УДИРДАМЖ
БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.5, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 1 дүгээр тогтоолоор батлагдсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамжийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх нэгдсэн удирдамжийн дагуу хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд оролцогч талуудын хооронд байгуулах гэрээний загвар, тайлангийн маягтуудыг боловсруулан баталж, мөрдүүлэхийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Б.Нямдаваа/-т даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Өнөрбаяр/-д үүрэг болгосугай.

САЙД

С.ЧИНЗОРИГ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2019 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн
А/83 дугаар тушаалын хавсралт

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ НЭГДСЭН УДИРДАМЖ

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс 2019-2020 онд хэрэгжүүлэхээр баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулан ажиллах Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүд, сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан ажилтан, албан хаагчдыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж, хөтөлбөрийг нэгдсэн зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэхэд удирдамжийн зорилго оршино.

Нэгдүгээр бүлэг. Удирдлага зохион байгуулалт, тайлагналт, хяналт-шинжилгээ, үнэлгээ

1.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам мэргэжлийн удирдлагаар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар зохицуулалт, арга зүйгээр хангаж, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс зохион байгуулж, дэмжлэг үзүүлж ажиллана.

1.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үрдүнд Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл болон сум, дүүрэг/хорооны Засаг дарга, иргэдийн төлөөллийн байгууллага байнгын хяналт тавина.

1.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулахад төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог хангаж, хамтран ажиллана.

1.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн хяналт-үнэлгээг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар жилд 2 удаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам жилд 1 удаа хийнэ.

1.5. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь хөтөлбөрийн хэрэгжилтийн тухайн сарын тайлан, мэдээг 25-ны өдрөөр тасалбар болгож, дараа сарын 3-ны дотор, улирлын тайлан, мэдээг дараа улирлын эхний сарын 3-ны дотор Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт, тус газар нь тайлан, мэдээг ажлын 3 хоногт багтаан нэгтгэн дүгнэж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тус тус хүргүүлнэ.

1.6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний болон хамрагдаж буй иргэдийн мэдээллийг Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан

(LMIS)-д маягтын дагуу тогтмол бүртгэж, шинэчилнэ.

1.7. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн тус бүрээр тайлагнана.

1.8. Хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлсэн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, бичиг баримт хуурамчаар үйлдсэн болон бусад зөрчил, дутагдал гаргасан нь холбогдох байгууллагуудаас хийсэн хяналт, шалгалтаар тогтоогдвол олгосон санхүүжилтийг буцаан төлүүлэх арга хэмжээ авч, буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

1.9. Иргэнийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд олгогдох эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт давхардуулан хамруулахгүй.

Хоёрдугаар бүлэг. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хэрэгжилт, зохицуулалт

2.1. Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд:

2.1.1. Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ:

2.1.1.1. Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээний хүрээнд зохион байгуулах сургалтыг эрх бүхий байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх ба сургалт зохион байгуулах байгууллагын жагсаалтыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас гаргана.

2.1.2. Мэргэжлийн болон давтан сургалт зохион байгуулах

2.1.2.1. "Мэргэжлийн сургалт"-нд ажилгүй болон ажлын байранд зуучлагдах болох хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй иргэнийг, "Давтан сургалт"-нд ажил олгогчийн хүсэлтийг үндэслэн ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэнийг тус тус сургана.

2.1.2.2. Мэргэжлийн болон давтан сургалт зохион байгуулах сургалтын байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

А. Холбогдох журмын дагуу бүртгүүлсэн, сургалт зохион байгуулах гэрчилгээтэй, мэргэжлийн сургалт зохион байгуулах эрх бүхий байгууллага байх;

Б. Сургалтын хөтөлбөр нь мэргэжлийн боловсрол, сургалтын стандартад нийцсэн, ажил олгогчийн эрэлт, хэрэгцээг хангахуйц байх;

В. Насанд хүрэгчдийн сургалт заах арга зүй, ур чадвар бүхий үндсэн багштай байх;

Г. Сургалтын стандарт нөхцлийг хангасан онолын болон дадлагын байр, танхимтай байх;

Д. Сургалт нь онол, дадлага буюу лабораторийн ажил, үйлдвэрлэлийн дадлагын хэсгүүдээс бүрдэх бөгөөд онолын сургалт нь нийт сургалтын 30 хувиас ихгүй байх;

Е. Бусад

2.1.2.3. Нийслэлийн төвийн 6 дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс 4 дүгээр сарын 3 дахь долоо хоногт багтаан

эрхийн бичгээр сургах иргэдийн тоо, мэргэжлийн чиглэлийн саналаа Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газарт хүргүүлэх ба тус газар нь 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 7 дугаар сарын эхний долоо хоногт сургалт дуусахаар төлөвлөн зохион байгуулна. Мөн мэргэжлийн сургалтад суралцаж төгссөн иргэдийн мэдээллийг 8 сарын эхний хагаст багтаан харьяалах дүүргүүд рүү хүргүүлнэ.

2.1.2.4. Хөдөлмөрийн захзээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийн цогц сургалтыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын баталсан төлөвлөгөөнд заасан цагалбарын дагуу зохион байгуулна.

2.1.2.5. Мэргэжлийн болон давтан сургалтын сургалтыг эрх бүхий мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, мэргэжлийн сургалтын байгууллагууд зохион байгуулна.

2.1.3. Үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулах

2.1.3.1. Үйлдвэрлэл дээрх сургалтыг 3 долоо хоног буюу ажлын 15 хоногоос 6 долоо хоног буюу ажлын 30 хоногт ажил олгогчийн хүссэн, боломжтой хугацаагаар зохион байгуулна. Ажил олгогчийн хэрэгцээ, суралцагчийн хүсэлтийг харгалзан сургалтын хугацаа уян хатан байх бөгөөд сургалтын хугацаанд ногдох санхүүжилтийг олгоно.

2.1.3.2. Үйлдвэрлэл дээрх сургалтыг зохион байгуулж, ажиллах хүчин авах хүсэлтэй аж ахуйн нэгж нь дараах шаардлагыг хангасан тухай холбогдох баримт бичиг, материалыг бүрдүүлж, холбогдох байгууллагад хандана. Үүнд:

А. Тухайн салбарт үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нотолсон аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээтэй, Монгол Улсын хуулийн этгээд байх;

Б. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа нийгмийн даатгалын шимтгэл төлдөг ажилтнуудтай, улмаар үйл ажиллагаа нь өргөжиж, шинээр ажилтан авах эрэлт хэрэгцээ бий болсон байх;

В. Суралцагч үйлдвэрлэл дээр дадлага эзэмших боломжоор хангагдсан байх /дадлагын тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн цех, талбайтай, дагалдуулан сургах ур чадвар бүхий дадлагажуулагч багштай, мастер, мэргэшсэн мэргэжилтэн, инженер, сургагчийн нөөцтэй г.м/;

Г. Дадлагын сургалтын хөтөлбөр, агуулга нь чадамжийн нэгж бүрээр тодорхойлогдсон байх бөгөөд сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөтэй байх;

Д. Сургалтын хугацаанд үйлдвэрлэлийн горим, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, дүрэм журмыг мөрдүүлэх;

Е. Суралцагчдад сургалтын дадлагын хугацаанд нь ажил үүрэгт нь тохирсон цалин хөлс, урамшууллыг зохих журмын дагуу олгох;

Ё. Үйлдвэрлэл дээрх сургалтын суралцагчдын 80-аас доошгүй хувийг ажлын байраар хангаж, хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллуулах;

Ж. Бусад.

2.1.3.3. Үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулах аж ахуйн нэгж нь өөрийн үндсэн ажилтн⁴⁵ы тоо 2-5 хүртэл байвал 3 хүртэл хүнийг, 6 буюу түүнээс их байвал шинээр бий болох ажлын байрны тоогоор буюу 4-өөс дээш хүнийг үйлдвэрлэл дээр сургах тухай хүсэлтээ ирүүлнэ.

2.1.3.4. Үйлдвэрлэл дээрх сургалтын онол, дадлагын хичээлийн зардлыг ажил олгогчид шилжүүлэн олгох бөгөөд онолын хичээлийн 20 хувьд зориулсан сургалтын зардлыг онолын хичээлийг явуулахаар тухайн аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан эрх бүхий сургалтын байгууллагын дансанд шилжүүлж, баримт бүрдүүлнэ.

2.1.3.5. Үйлдвэрлэл дээрх сургалтын үйл ажиллагаанд зарцуулах нийт зардлыг сургалт эхлэхэд 70 хувь, сургалтын үйл ажиллагаа дуусч, суралцагч мэргэжлийн ур чадварын түвшин тогтоох шалгалт өгсний дараа шалгалтанд тэнцсэн болон ажлын байраар хангагдсан суралцагчийн тоог үндэслэн үлдсэн 30 хувийг тус тус олгоно.

2.1.3.6. Үйлдвэрлэл дээрх сургалтад хамрагдах иргэдийн 40 хүртэл хувьд ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн байж болно.

2.1.3.7. Үйлдвэрлэл дээрх сургалтад хамрагдсан иргэнд “Мэргэжлийн сургалтаар чадамж, мэргэжил эзэмшсэн төгсөгч, иргэдийн мэргэшлийн түвшинг үнэлэх, баталгаажуулах журам”-ын дагуу ур чадварын шалгалтыг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв зохион байгуулж, Чадамжийн гэрчилгээ олгох ба иргэн өөрөө хүсвэл мэргэжлийн зэрэг олгох шалгалтад хамрагдаж болно.

2.1.3.8. Үйлдвэрлэл дээрх сургалтыг зохион байгуулах тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь монгол иргэдийг гадаад ажилтан, ажилчдыг дагалдуулан ажиллуулж байгаа бол төслийн шалгаруулалтад давуу тал болно.

2.2. Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд:

2.2.1. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох:

2.2.1.1. Төсөл шалгаруулах 2 дахь үе шатанд иргэн өөрийн хэрэгжүүлэх төсөлд үнэлгээ өгөхгүй. Харин бусад шаардлага хангасан төслүүдэд үнэлгээ өгч оролцоно.

2.2.1.2. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг авахыг хүссэн иргэн бусадтай хамтран аж ахуй эрхлэх нь нээлттэй бөгөөд энэ тохиолдолд үйл ажиллагаа эрхлэх төсөл, төлөвлөгөөндөө хамтран ажиллах иргэдийн оролцоог тусгана.

2.2.1.3. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг хүссэн иргэн өөрийн харьяалах аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст дор дурдсан бичиг баримтыг бүрдүүлж хандана. Үүнд:

А. Санхүүгийн дэмжлэг хүссэн тухай өргөдөл;

Б. Иргэний өөрийн болон хамтран ажиллах бусад иргэдийн

⁴⁵ Нийгмийн даатгалын шимтгэл төлдөг ажилтан

иргэний үнэмлэхний хуулбар;

В.Аж ахуй, бичил бизнес эрхлэх үйл ажиллагааны төсөл, төлөвлөгөө;

Г. Гадаадад ажиллаж, амьдарч байгаад ирсэн бол гадаад паспорт, шаардлагатай бол эзэмшсэн мэргэжил, ур чадварыг тодорхойлох баримт бичиг.

2.2.1.4. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг үйлдвэрлэл, үйлчилгээний тодорхой чиглэл харгалзахгүйгээр зохион байгуулна. Шаардлагатай бол ижил төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээг бүлэглэн шалгаруулалтыг зохион байгуулна.

2.2.1.5. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд зарцуулах нийт хөрөнгийн 70 хүртэл хувийг 4 дүгээр сард, үлдсэн 30 хувийг 9 дүгээр сард тус тус зарцуулахаар төлөвлөж, холбогдох арга хэмжээг зохион байгуулна.

2.2.1.6. 4 дүгээр сард зохион байгуулахдаа иргэдийг бүртгэх тухай зарлал, мэдээллийг жил бүрийн 2 дугаар сарын сүүлийн 7 хоногт нийтэд мэдээлэх бөгөөд 3 дугаар сарын 3 дахь 7 хоногт иргэдийн бүртгэлийн ажлыг зогсооно. Иргэдийн ирүүлсэн материал болон нөхцөл, байдалтай газар дээр нь танилцаж, санхүүгийн дэмжлэг авах шаардлага хангасан иргэдийг 4 дүгээр сарын 2 дахь 7 хоногт багтаан шалгаруулж дууссан байна.

2.2.1.7. 9 дүгээр сард зохион байгуулах санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээг 7 дугаар сараас эхлэн энэхүү удирдамжийн 2.2.1.6-д заасан үйл ажиллагааг тухайн заагдсан хугацаанд багтаан зохион байгуулна.

2.2.1.8. Ажлын хэсэг иргэний хэрэгжүүлэх төслийн бодит төсөвт өртгийг санхүүжүүлэх зарчим баримтлана.

2.2.1.9. Иргэдээс ирүүлсэн төслийг шалга-руулахдаа хэрэв өөрийн эзэмшсэн мэргэжлийн дагуу буюу хөдөлмөр эрхлэлтийн сургалтын хүрээнд эзэмшсэн мэргэжлийн дагуу үйл ажиллагаа эрхлэхээр хүсэлт ирүүлсэн бол давуу тал болно. Энэ тохиолдолд хөдөлмөр эрхлэлтийн сургалтын чадамжийн гэрчилгээг үндэслэл болгоно.

2.2.1.10. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн төлөлтийг гэрээний дагуу иргэнээр төлүүлж, хяналт тавих ба эргэн төлөлтийг аймаг, дүүрэг тус бүр өөрийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төвлөрүүлнэ.

2.2.1.11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр, хөтөлбөрүүдийн хүрээнд олгогдсон санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийг улирал бүрийн сүүлийн сарын 4 дэх долоо хоногт багтаан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлнэ.

2.2.1.12. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг иргэнд олгохдоо хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад хөтөлбөр, төслийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамрагдсан хүнд давхардуулан⁴⁶ олгохгүй.

⁴⁶ Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн нэгдүгээр тогтоолоор баталсан хөтөлбөрүүдийн хүрээнд санхүүгийн дэмжлэгийг нэг иргэнд давхардуулан олгохгүй.

2.2.2. Аж ахуй эрхлэлтийн сургалт явуулах арга хэмжээг зохион байгуулах

2.2.2.1. Жижиг зээл болон энэхүү хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг авах төсөл ирүүлсэн болон шийдвэрлэгдсэн иргэд түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдэд хамрагдаагүй аж ахуй, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэнийг өөрсдийн хүсэлтэд нь үндэслэн аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулна.

2.2.2.2. Аж ахуй эрхлэлтийн сургалтаар мэргэшсэн сургагч багшийн эрх бүхий ажилтантай аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь аж ахуй эрхлэлтийн сургалтыг зохион байгуулж болох бөгөөд энэ тохиолдолд сургалтын үйл ажиллагаанд хуваарилсан төсвийг тухайн багшийн замын зардал болон томилолтын зардалд зарцуулж болно. Төсвийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн ажилтан багшийн урамшуулал болон цалинд зарцуулахгүй.

2.2.2.3. Жижиг зээл, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн төслийг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжих, хяналт тавих зорилгоор иргэд, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагууд, ажил олгогчдын оролцоотой туршлага солилцох уулзалт, хэлэлцүүлгийг аж ахуй эрхлэлтийн сургалтын зардалд хуваарилсан төсвийн 5 хүртэл хувиар зохион байгуулж болно.

2.2.2.4. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах эрх бүхий сургалтын байгууллагын жагсаалтыг гаргахдаа бизнес инкубатор төвүүдийн нэгдсэн холбооны саналыг харгалзан тогтооно.

2.2.3. Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах

2.2.3.1. Борлуулалтын цэгийг ажиллуулах зардлыг зөвхөн түрээсийн төлбөр болон урсгал зардал /цахилгаан, дулаан, интернет гэх мэт/-д зарцуулна. Борлуулалтын цэг дээр ажиллах борлуулагчид цалин, урамшуулал олгохгүй буюу борлуулалтын цэгт хамрагдаж байгаа зорилтот бүлгийн иргэдийг тодорхой хуваарийн дагуу ажиллуулах, эсхүл зорилтот бүлгийн иргэдтэй харилцан тохиролцож, борлуулалтын орлогын тодорхой хувиар цалин, урамшууллыг олгох байдлаар зохион байгуулна.

2.2.3.2. Борлуулалтын цэгийг бизнес инкубатор төвөөр гэрээлэн ажиллуулж болох бөгөөд энэ тохиолдолд санхүүжилтийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан “Борлуулалтын цэг ажиллуулахад зарцуулах нэг сарын зардлын дээд хэмжээ”-нээс хэтрүүлэхгүйгээр олгоно.

2.2.3.3. Борлуулалтын цэг нь бараа, бүтээгдэхүүн борлуулахад

дэмжлэг үзүүлж, борлуулалтын захиалга хүлээн авах, сурталчлах, худалдан авагчидтай холбох зэрэг арга хэмжээг зохион байгуулна.

2.2.3.4. Хөтөлбөрүүдэд заасан иргэний үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг борлуулах “Борлуулалтын цэг”-ийг аймаг, дүүргүүд тус бүрдээ нэгдсэн нэг цэгээр зохион байгуулж болно.

2.2.3.5. Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр ажлын байр түрээсэлж байгаа Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгодог зээл, санхүүгийн дэмжлэгт хамрагдах шийдвэр гарсан иргэдэд үзүүлнэ.

2.2.3.6. Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг тухайн ондоо багтааж дээд тал нь 6 сарын хугацаатай үзүүлэх ба хөнгөлөлтийг сар сараар нөхөн олгоно.

2.2.3.7. Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт эдлэх хүсэлтэй зорилтот бүлгийн дараах шаардлагыг хангасан иргэдийг шалгаруулж, хамруулна. Үүнд:

А. Энэхүү хөтөлбөрийн зээл, санхүүгийн дэмжлэгт хамрагдсан үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй, бичил бизнес эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байх;

Б. Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ажлын байр түрээслэн үйл ажиллагаагаа тасралтгүй 6 сар болон түүнээс дээш хугацаагаар явуулсан байх;

В. Хүчин төгөлдөр хугацаа бүхий түрээсийн гэрээтэй байх;

Г. Бусад.

2.2.3.8. Түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх иргэдийг сонгон шалгаруулахад тухайн ажлын байранд ажиллаж байгаа ажилтнуудын тоо нь давуу тал болно.

2.2.3.9. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг зарж борлуулахад чиглэсэн нэгдсэн үзэсгэлэн, яармагийг жилд 5 сая хүртэл төгрөгт багтаан зохион байгуулах ба холбогдох зардлыг батлагдсан төсвийн “Борлуулалтын дэмжлэг”-т хуваарилсан хөрөнгөөс санхүүжүүлнэ.

2.2.3.10. Иргэн нь түрээсийн төлбөрийн хөнгөлөлтөд үйлдвэрлэлийн, эсхүл үйлчилгээний аль нэг чиглэлээр хамрагдана. Үйлчилгээний төрөлд хүнсний болон бэлэн бараа бүтээгдэхүүн худалдан борлуулах үйл ажиллагаа хамрахгүй болно.

2.2.3.11. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь өөрийн харьяанд үйл ажиллагаа явуулж байгаа Бизнес инкубатор төвд аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах, ажлын байрны түрээсийн хөнгөлөлт, борлуулалтын цэг ажиллуулах зэрэг үйлчилгээг гэрээний үндсэн дээр зохион байгуулна⁴⁷.

⁴⁷ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батлагдсан зардлын жишгийг баримтлан санхүүжүүлнэ.

2.2.4. Ажил олгогчийг дэмжих арга хэмжээг зохион байгуулах

2.2.4.1. Ажил олгогчийн урамшуулал, санхүүгийн дэмжлэг олгох тухай гэрээг ажлын байраар хангагдаж байгаа иргэний байнгын оршин суугаа аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс ажил олгогчтой байгуулж, санхүүжилтийг олгоно.

2.2.4.2. Ажил олгогчийн урамшуулал, санхүүгийн дэмжлэгийг авахаар гэрээ байгуулсан ажил олгогч урамшууллаа авахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлж холбогдох байгууллагад хандана. Үүнд:

А. Аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

Б. Ажил олгогч, ажилтны хүсэлт;

В. Ажилтны иргэний үнэмлэхний хуулбар;

Г. Ажилтан зорилтот бүлгийн иргэн мөн болохыг нотолсон баримт бичиг, тодорхойлолт;

Д. Хөдөлмөрийн болон бусад гэрээний хуулбар;

Е. Ажилтны нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар;

Ё. Ажил олгогчийн хүн амын орлогын болон нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тухай болон татвар шимтгэлийн өргүй талаарх Татварын болон Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт;

Ж. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэстэй байгуулсан гэрээ;

З. Ажилтны цалингийн картны хуулга;

И. Бусад.

2.2.4.3. Ажил олгогчийн дэмжлэгийг зорилтот бүлгийн иргэнийг ажлын байраар хангаж, тасралтгүй 12 сар буюу түүнээс дээш хугацаагаар ажиллуулсан, цаашид үргэлжүүлэн ажиллуулах ажил олгогчид олгоно. (тасралтгүй 12 сар ажилласан боловч ажлаасаа гарсан иргэний тухайд ажил олгогчид дэмжлэг олгохгүй)

2.2.5. Зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээ

2.2.5.1. Сумын бүлгийн гишүүд нь дараах чиглэлээр хөдөлмөр эрхлэнэ. Үүнд:

- Сум, багийн хэмжээнд нөөцийн болон шинээр эзэмших бэлчээр нутагт өвөлжөө, хаваржаа, намаржааны хашаа, хороо барих, худаг ус гаргах, нийтийн хэрэглээнд зориулж хадлан тэжээлийн нөөц бэлтгэх, эзгүйрч орхигдсон бууц, хашаа хороог сэргээн засварлах,

- Сум, багийн иргэдийн арьс шир, хөөвөр хялгас, ноос ноолуур зэрэг малын гаралтай түүхий эд, мах, сүү, цагаан идээ зэрэг бүтээгдэхүүнийг зохион байгуулалттайгаар боловсруулах, хадгалах, худалдан борлуулах,

- Өвөлжилт хүндэрсэн үед цас зудад нэрвэгдсэн малчдад хүнс, өвс, тэжээл хүргэх, малын бэлчээрийн цас арилгах, мал тэжээхэд туслах, боогдсон даваа гүвээ, замын цас, мөс цэвэрлэх,

• Сум, багийн төвд үер усны суваг, шуудуу татах, нийтээр ашиглах ариун цэврийн байгууламж /жорлон, хогийн сав зэрэг/ барих, сэргээх, засварлах,

2.2.5.2. Хорооны ажилгүй иргэдийг бүлэг нь дараах чиглэлээр хөдөлмөр эрхлэнэ. Үүнд:

• Хорооны эзэмшлийн хүүхдийн болон спортын талбай, явган зам, ойр орчмын газрын сандал, сүүдрэвч, төхөөрөмж зэргийн бохирдлыг арилгах, эвдрэлийг засах, зүлэг модыг услах, хиймэл зүлэг, дэвсгэрийг угаах, тоглоомын ойр орчмыг цэвэрлэх,

• Хорооны нутаг дэвсгэрт хүүхдийн болон спортын талбай, явган зам, ойр орчмын талбай, хашаа, хашлагын эвдрэлийг засах, гэрэлтүүлэг, тохижилтын бүрэн бүтэн байдлыг хянах,

• Хорооны нутаг дэвсгэрт нэгдсэн журмаар тохижилтын ажил хийх /айлуудын хашааны нүүрийг жигдэлж будах, гудамжны тахир муруйг засах, хүн хүчний боломжгүй айл, өрхүүдийн ариун цэврийн байгууламж, гэрийн буурь малтах, шинэчлэх, хашаа барих, засах зэрэг/,

• Газар чөлөөлөлт болон албан журмаар нүүлгэн шилжүүлэх арга хэмжээнд хамрагдсан айл, өрхийг нүүлгэх,

• Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, нялх хүүхэдтэй эх /эцэг/ зэрэг хүн хүчний боломжгүй, нийгмийн халамж анхаарал шаардах гэр бүлд түлш, ус түлш хүргэх, гэр байшин дулаалах зэрэг ажилд туслах,

2.2.5.3. Сум, хороонд ажиллах бүлгийн ажиллах хугацаа, хөдөлмөрийн харилцааны зохицуулалт

2.2.5.3.1. Бүлгийн ахлагч нь гишүүн бүрийнхээ хөдөлмөр эрхэлсэн цагийн бүртгэлийг сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэнд сар бүр гаргаж өгнө. Бүлгийн гишүүн сард 10, жилд 100-аас доошгүй ажлын бүтэн өдөр ажиллана.

2.2.5.3.2. Сум, хорооны хөдөлмөр, халамжийн асуудал хариуцсан ажилтан нь бүлгийн гишүүдийн ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн зардал болон ажлын хөлсийг өдөрт гишүүн тус бүрт 10,0 мянган төгрөгөөр тооцон, удирдамжийн 2.2.5.3.1-т заасан өдрөөс хэтрүүлэхгүйгээр олгоно.

2.2.5.3.3. Тухайн аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь бүлгийн гишүүдийн тухайн жилд төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төсөлд хуваарилагдсан хөрөнгөөс 100 хувь төлнө.

2.2.5.3.4. Бүлгийн гишүүдийн ажлын хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэл тооцож авахгүй.

2.2.5.3.5. Бүлэг нь удирдамжийн 2.2.5.1-2-т заасан болон ажлын чиглэлээр хязгаарлахгүйгээр аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн

захиалгаар ажлыг гүйцэтгэхдээ хөлсөөр ажиллах гэрээ байгуулан 2.2.5.3.2-т зааснаас өөр нэмэлт цалин хөлстэй ажиллана⁴⁸.

2.2.5.4. Удирдлага, зохион байгуулалт

2.2.5.4.1. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс, сум, хорооны Засаг даргын Тамгын газар, Ажлын албатай хамтран бүлгийн үйл ажиллагаа, энэхүү төслийн хэрэгжилтийн явц, үр дүнд тогтмол хяналт тавьж ажиллана.

2.2.5.4.2. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь сум, хорооны Засаг дарга, бүлэг, багийн ахлагчийн хооронд байгуулах хөлсөөр ажиллах гэрээ, мөн 2.2.5.3.5-д заасан гэрээний ерөнхий загвар, төслийн хэрэгжилтийн тайлангийн маягтыг тус тус батална.

2.2.6. Ажил хайгч иргэн, оюутан, суралцагчийг цагийн ажилд зуучилж, орлого нэмэгдүүлэх арга хэмжээ

2.2.6.1. Арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь “Ажил хайгч иргэн, оюутан, суралцагчдийг цагийн ажилд зуучлах зөвлөмж”-ийг хөтөлбөрийн зүйл, заалтад нийцүүлэн баталж, зохицуулалтаар хангаж ажиллана.

2.2.6.2. Хөтөлбөрийн 10.4-т заасан арга хэмжээний хүрээнд Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар нь явуулын болон хөдөлмөрийн биржийн үйл ажиллагааг хөдөлмөрийн зуучлалын байгууллага, салбарын ажил олгогчдыг оролцуулж тухай бүр зохион байгуулна.

2.2.7. Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээг зохион байгуулах

2.2.7.1. Арга хэмжээг орон нутгийн захиргааны эрх бүхий байгууллагаас нэгдсэн зохион байгуулалттай, зөвшөөрөгдсөн газар дээр иргэдийг бүлгийн зохион байгуулалттайгаар хамруулж, хэрэгжүүлнэ.

2.2.7.2. Иргэдийг сонгохдоо Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээс зарлал мэдээлэл, сурталчилгааг явуулж, бүртгэнэ. Бүртгэгдсэн иргэдэд арга хэмжээний талаар танилцуулга хийж, өөрийнх нь хүсэлтэд тулгуурлан арга хэмжээнд хамруулна. Хэрэв арга хэмжээнд хамрагдахаар бүртгүүлсэн иргэдийн тоо Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн төлөвлөсөн тооноос давбал бүлгээр ажиллах иргэдийн саналыг харгалзан шалгаруулна.

2.2.7.3. Арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийг иргэдийн цалин, урамшуулал, хоолны зардалд бус хүнсний ногоо тариалахтай холбоотой үр бордоо, бага оврын багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах, хашаа, хайс, хүлэмж барих, худаг гаргах, амралтын гэр, байр барих зэрэг болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, бусад холбогдох үйл ажиллагааны зардалд зарцуулна.

⁴⁸ Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн захиалгаар ажил гүйцэтгэх хоногт удирдамжийн 2.2.5.3.1-т заасан хоног хамаарахгүй.

2.2.7.4. Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэнийг нэн тэргүүнд хамруулах чиглэл баримтлана.

2.3. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд:

2.3.1. Залуучуудад зориулсан хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх

2.3.1.1. Хөтөлбөрийн 3.1-д заасан үйлчилгээг туршин нэвтрүүлсэн Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төв бүхий аймаг, дүүргүүд бусад аймаг, дүүрэгт түгээн дэлгэрүүлэх, нэвтрүүлэхэд арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.

2.3.1.2. Залуучуудын хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээг аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн ажил мэргэжлийн чиг баримжаа болон ажилд зуучлах үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн хийнэ.

2.3.1.3. Залуучуудын хөдөлмөр эрхлэх ур чадварыг үнэлэх үнэлгээний аймаг, үнэлэх аргачлал /заавар/, хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөөний загварыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар батална.

2.3.1.4. Хөтөлбөрийн 4.3.1-д заасан үе шат бүхий сургалтыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас баталсан хөтөлбөрийн дагуу аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүд зохион байгуулна.

2.3.1.5. Залуучуудыг ажилд зуучилсны дараа ажил олгогч болон тухайн зуучлагдсан иргэдтэй холбогдож, тогтвортой ажиллаж байгаа эсэхэд хяналт тавьж, шаардлагатай бол зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллана.

2.3.1.6. Хөтөлбөрийн 4.5-д заасан судалгаа хийх аргачлал /арга зүй/-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтээс боловсруулсан аргачлалын дагуу зохион байгуулах ба арга зүйн зөвлөмж, чиглэл авч хамтран ажиллана.

2.3.2. Гарааны бизнесийг дэмжих арга хэмжээг орон нутгийн эрэлт хэрэгцээ, салбар, чиглэл зэргийг харгалзан зохион байгуулна. Ингэхдээ хөтөлбөрт хуваарилсан гарааны бизнесийг дэмжих арга хэмжээг зохион байгуулах зардлаар болон орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрээс санхүүжүүлэн хэрэгжүүлнэ.

2.3.3. Гарааны бизнесийн санааг хөгжүүлэх, сонгон шалгаруулах арга хэмжээг зохион байгуулах, шалгарсан төслүүдийг хурдасгуурт хамруулах, ментор ажиллуулах үйл ажиллагааг батлагдсан төсөвт багтаан⁴⁹ зохион байгуулна.

⁴⁹ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан зардлын жишгийн дагуу зохион байгуулна.

2.3.4. Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээ

2.3.4.1. Гарааны бизнесийн дэмжлэгт хамрагдсан залуучуудын үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг борлуулах үйл ажиллагааг энэхүү хөтөлбөрийн хүрээнд болон гадаад борлуулалт, аймаг, дүүрэг бүрт байгуулсан борлуулалтын цэгүүд болон нэгдсэн үзэсгэлэн, яармаг, арга хэмжээний хүрээнд холбогдох байгууллагууд хариуцан зохион байгуулна.

2.3.4.2. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь түрээсийн хөнгөлөлтийг үзүүлэхдээ “Түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх нэг сарын зардлын дээд хэмжээ”-гээр тооцож олгоно.

2.4. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд:

2.4.1. Малчин өрхийг малжуулах арга хэмжээ

2.4.1.1. Сумын амьжиргааг дэмжих зөвлөл нь арга хэмжээнд хамрагдах малчин өрхийн нэрсийн жагсаалт, холбогдох мэдээлэл бүхий саналыг орон нутгийн иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэн аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст ирүүлэх бөгөөд газар нь малчин өрхийг арга хэмжээнд хамруулах тухай эцсийн шийдвэрийг гаргана.

2.4.1.2. Арга хэмжээнд дараах шаардлагыг хангасан малчин өрхийг хамруулна. Үүнд:

А. Арга хэмжээнд хамруулах хүсэлт гаргасан байх;

Б. 18-45 насны 2-доошгүй гишүүнтэй /бусад насны гишүүдийн тоо хамаарахгүй бөгөөд тайлангийн маягтад бусад гишүүдийн тоог тусгана./ малчин өрх байх;

В. Хөтөлбөрийн 3.1-д заасан толгой малтай байх;

Г. Хөтөлбөрт хамрагдах малчин өрх нь малжуулах арга хэмжээнд хамрагдахдаа боловсруулсан төлөвлөгөө, төсөлтэй байх;

Д. Эргэн төлөлтийг хийх хуваарийг тусгасан төлөвлөгөө гаргасан байх.

2.4.1.3. Малжуулах дэмжлэгийн эргэн төлөлтийг мал худалдан авч өгсөн өдрөөс хойш 36 сарын дотор мөнгөн хэлбэрээр хийх ба малчин өрхийн өөрийн боломжид тулгуурлан боловсруулсан “Эргэн төлөлт хийх төлөвлөгөө”-г малчин өрх, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс болон сум, хорооны Засаг дарга нарын гурвалсан гэрээнд хавсаргана.

2.4.1.4. Эргэн төлөлтийг аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төвлөрүүлнэ.

2.4.1.5. Бог малд шилжүүлснээр 50 хүртэл толгой малтай малчин өрхийг дадлагажуулагчийг сонгохдоо арга хэмжээнд хамрагдах малчин өрхийн ойр дотны хамаатан садан, айл саахалтын хүмүүс болон найз

нөхдийг нь сонгохыг удирдамжийн хүрээнд зөвлөж байна.

2.4.1.6. Малчин өрхийг малжуулах арга хэмжээг Улаанбаатар хотын алслагдсан Багануур, Багахангай, Налайх дүүргүүдэд хэрэгжүүлж, хөрөнгийг хуваарилах бөгөөд тухайн дүүргүүд хөтөлбөр болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамжийн дагуу арга хэмжээг зохион байгуулна.

2.4.2. Гэрээт малчин хөдөлмөр эрхлэлтийг арга хэмжээг зохион байгуулах удирдлага, зохион байгуулалт

2.4.2.1. Гэрээгээр мал маллах сонирхолтой өрхийн бүртгэл, судалгааг сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан ажилтан оны эхний улиралд багтаан гаргаж нэгтгэн, аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст хүргүүлнэ.

2.4.2.2. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь сум, хорооноос ирсэн бүртгэл, мэдээллийг нэгтгэж, ажлын 3 хоногийн дотор Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлнэ.

2.4.2.3. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь аймаг, дүүргээс ирсэн бүртгэл мэдээллийг нэгтгэн, мэдээллийн сан үүсгэх ба батлагдсан төсвийн хүрээнд хуваарилж санхүүжүүлнэ.

2.4.2.4. Аймгуудын гэрээт малчин авч ажиллуулах малчны /600⁵⁰ болон түүнээс дээш малтай/ бүртгэл, судалгааг тухайн аймгийн сумдын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан ажилтан, Засаг даргын тамгын газар, багийн Засаг даргатай хамтран оны эхний улиралд багтаан гаргаж, аймгийнхаа Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хүргүүлнэ.

2.4.2.5. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, сумын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан ажилтан нь хамтран малчин ажил олгогчид гэрээт малчнаар ажиллах өрхийн бүртгэл, судалгааг танилцуулах, сонголт хийлгэх, сонгосон гэр бүлтэй холбогдох, харилцан тохиролцож гэрээ байгуулах, сургалтад хамруулах зэрэг зуучлалын үйл ажиллагааг 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор зохион байгуулна.

2.4.2.6. Удирдамжийн 2.4.2.5-д заасан үйл ажиллагааг тухайн арга хэмжээнд хуваарилсан хөрөнгөнөөс батлагдсан төсвийн хэмжээнд санхүүжүүлнэ.

2.4.2.7. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь хөдөлмөрийн болон хөлсөөр ажиллах гэрээний ерөнхий загвар, дөрвөлсөн гэрээний ерөнхий загвар⁵² /ажил олгогч малчин, гэрээт

⁵¹ 501-999 тооны малтай 26,632 өрх, 1000-аас дээш малтай 9954 өрх байна. ҮСХ-ны 2017 оны тайлан.

⁵² Дөрвөлсөн гэрээ нь арга хэмжээнд хамруулах, хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор байгуулах ерөнхий гэрээ байна.

малчин өрх, аймгийн ХХҮГазар, сумын ЗДТГ/, малчин ажил олгогч, гэрээт малчин гэр бүлийг бүртгэх судалгааны маягтыг тус тус батална.

2.4.2.8. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь төслийн хэрэгжилтийн тайлангийн маягт, гэрээт малчин өрхийн гишүүдийг сургах сургалтын хөтөлбөрийг батална. Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалтыг зохион байгуулна. Гэрээт малчин өрхийн гишүүдэд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа, сургалтыг холбогдох хөтөлбөр, гарын авлагын дагуу зохион байгуулна.

2.4.2.9. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, сум, багийн Засаг дарга, хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан ажилтан арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнд эрх үүргийнхээ хүрээнд хяналт тавьж ажиллана.

2.4.3. Аж ахуй эрхлэлтийн, мал маллагааны болон малын ашиг шим боловсруулах сургалт, туршлага солилцох уулзалт, бусад арга хэмжээг зохион байгуулах

2.4.3.1. Аж ахуй эрхлэлтийн сургалт, мал маллагааны болон малын ашиг шим боловсруулах сургалт, туршлага солилцох уулзалтыг зөвхөн малжуулах арга хэмжээнд хамрагдаж байгаа малчин өрхөд зориулан зохион байгуулна.

2.4.3.2. Хөтөлбөрт хамрагдсан малчин өрхийн аж ахуйг аймаг, дүүрэгт байгуулсан Борлуулалтын цэгээр дамжуулан дэмжинэ.

2.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд:

2.5.1. Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ

2.5.1.1. Хөтөлбөрийн 3.2-т заасан арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэйн улмаас нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцож чадахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй залуучуудыг түлхүү хамруулна.

2.5.1.2. Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээний хүрээнд зохион байгуулах сургалтыг эрх бүхий байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх ба сургалт зохион байгуулах байгууллагын жагсаалтыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас гаргана.

2.5.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжлэгтэйгээр ажилд зуучлах

2.5.2.1. Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах арга хэмжээнд хамрагдахаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст ажил хөдөлмөр эрхлэх хүсэлт гаргасан хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг Хөдөлмөрийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 08 ны А/04 тушаалаар батлагдсан “Ажил хайгч иргэний бүртгэл”-д, ажил олгогчоос ирүүлсэн захиалгыг “Ажлын байрны захиалгын мэдээлэл”-д хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллах боломжтой эсэх лавлагааг тодорхой асууж, бүртгэнэ.

2.5.2.2. Дээрх бүртгэлд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажил, мэргэжлийн чиг баримжаа, сэтгэл зүй, хувь хүний төлөвшил, хөдөлмөрийн харилцааны суурь мэдлэг олгох, зөвлөгөө мэдээлэл өгөх болон ажлын байранд зуучилна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батлагдсан “Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ”-ний зардлын жишгийн дагуу санхүүжүүлнэ.

2.5.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллах боломжит ажлын байрны нөхцөл, тоноглол, тохируулгын талаар ажил олгогчид зөвлөгөө өгөх, хамт олонд түшиглэн нийгэмшүүлэх, харьцааны ур чадвар, хөдөлмөрийн дэг журам, аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн горимд дасан зохицох ярилцлагад ороход нь туслах үйлчилгээг ажлын 5 өдөр хүртэлх хугацаанд хөтөч, дохионы хэлмэрчийн оролцоотой зохион байгуулна. Дээрх үйлчилгээг үзүүлэхэд ажилласан хөтөч, дохионы хэлмэрчийн урамшууллын ажилласан цаг, давтамж, ажил олгогчийн тодорхойлолтыг үндэслэн хөтөлбөрийн 3.3.3-т заасны дагуу олгоно.

2.5.3. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ

2.5.3.1. Уг арга хэмжээнд хамрагдах хөгжлийн бэрхшээлтэй иргэн дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна. Үүнд:

А. Эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрийн хугацаа нь хүчинтэй, тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний биеийн байдал нь төслөө хэрэгжүүлэх боломжтой байх;

Б. Албан ёсоор оршин суугаа харьяаллын дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст бүртгүүлж, санхүүгийн дэмжлэгт хамрагдах өөрийн хүсэлтээ бичгээр илэрхийлсэн байх;

В. Хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр өрхийн үйлдвэрлэл, аж ахуй, бичил бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд хэрэгжих үндэслэлтэй бизнесийн санаа, сонирхол, үр ашиг, орлого нэмэгдүүлэх тооцоо судалгаатай төсөл, үйл ажиллагааны төлөвлөгөө болон төсвийн саналыг боловруулсан байх;

Г. Төслийг нөхөрлөл, хоршоо, бүлгийн зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэх бол гишүүд, оролцогчдын үүрэг, хариуцлага, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг бичгээр тодорхойлсон байх.

2.5.3.2. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг зохион байгуулах талаар зар мэдээлэл, сурталчилгааны арга хэмжээг тодорхой төлөвлөгөө хуваарийн дагуу орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан зохион байгуулж, байнгын ажлын байр бий болгох төсөл сонгон шалгаруулалтыг нийтэд зарлана.

2.5.3.3. Хөтөлбөрийн 3.4-т заасан арга хэмжээг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн даргын тушаалаар батлагдсан

ажлын хэсэг сонгон шалгаруулалтын удирдамжийн дагуу зохион байгуулна. Ажлын хэсгийн гуравны нэгээс доошгүй бүрэлдэхүүнд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалсан тухайн орон нутгийн төрийн бус байгууллага, холбоодын хоорондоо зөвшилцсөн төлөөллийг оролцуулна.

2.5.3.4. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамруулах төслүүдийг аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс тухайн оны эхний болон 3 дугаар улиралд багтаан сонгон шалгаруулна. Сонгон шалгаруулалт дууссанаас хойш ажлын 10 хоногийн дотор сонгон шалгаруулалтын дүн шийдвэрийн талаар төсөл хэрэгжүүлэх саналаа ирүүлсэн иргэд болон нийтэд ил тод мэдээлнэ.

2.5.3.5. Сонгон шалгаруулалтанд тэнцсэн төсөл хэрэгжүүлэгчтэй “Аж ахуй, бичил бизнес эрхлэх хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн гэрээ”-ний загварын дагуу гэрээ байгуулж, талууд баталгаажуулна.

2.5.3.6. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь төсөл хэрэгжүүлж буй иргэний мэдээллийг “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн иргэний бүртгэл”-д буюу батлагдсан маягтын дагуу бүртгэнэ.

2.5.4. Борлуулалтын болон ажлын байрны дэмжлэг үзүүлэх арга хэмжээ

2.5.4.1. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулахад дэмжлэг үзүүлэх үзэсгэлэн худалдааг зохион байгуулах ба “Борлуулалтын цэг”-т байршуулан борлуулах дэмжлэг үзүүлнэ.

2.5.4.2. Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр ажлын байр түрээсэлж байгаа хөтөлбөрийн 3.5.2.-т заасан иргэнийг хамруулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар шинэчлэн батлагдсан зардлын хэмжээгээр тооцон, тухайн жилдээ багтаан дээд тал нь 6 сарын хугацаатай үзүүлэх ба хөнгөлөлтийг сар бүр нөхөн олгоно.

2.5.5. Аж ахуй эрхлэлтийн болон хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах

2.5.5.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүсэлтийг харгалзан хөтөлбөрийн 3.7.2-т заасан сургалтын аль нэг төрлийг сонгон хамруулна.

2.5.5.2. Аж ахуй эрхлэлт болон хөдөлмөр эрхлэлтийн сургалтын хүрээнд хөтөч, дохионы хэлмэрчийг бэлтгэх, хараагүй хүмүүсийн орон зайн чиг баримжааны сургалт болон хөгжлийн бэрхшээлийн бусад төрөл хэлбэрт хамаарах нэмэлт сургалтыг хөдөлмөр эрхлэлтийн болон аж ахуй эрхлэлтийн сургалтын зардлаас зохион байгуулж болно.

2.5.5.3. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь сургалтыг “Мэргэжлийн болон давтан сургалтын нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээ”-нд дурдсан мэргэжлийн дагуу сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлага хангасан гэрчилгээтэй, гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусаагүй, эрх бүхий сургалтын байгууллага, иргэнтэй гэрээлэн гүйцэтгүүлнэ.

2.5.5.4. “Мэргэжлийн болон давтан сургалтад нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээ”-ний дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэний мэргэжлийн сургалтын зардлын хэмжээг 30 хувиар нэмэгдүүлэн тооцох нь зөвхөн мэргэжлийн ур чадварын сургалтанд хамаарна.

2.5.5.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний үйлдвэрлэл дээрх сургалтыг “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”-ийн холбогдох заалтуудад нийцүүлэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс зохион байгуулна.

2.5.5.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний шавь сургалтыг зөвхөн мэргэжлийн ур чадвар олгох чиглэлээр өндөр ур чадвар бүхий иргэнтэй хамтран зохион байгуулах бөгөөд шавь сургалтын үргэлжлэх хугацаа нь 1-6 долоо хоног байна. Шавь сургалтын нэг хүнд ногдох зардлын хэмжээг “Мэргэжлийн болон давтан сургалтын нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээ”-ний “Мэргэжлийн сургалтын зардлын хэмжээ”-тэй дүйцүүлж, санхүүжүүлнэ. Шавь сургалтын зардалд хөгжлийн бэрхшээлтэй иргэний мэргэжлийн сургалтын 30 хувийн нэмэгдлийг тооцохгүй болно.

2.5.5.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний орон зайн чиг баримжааны сургалт болон хөтөч, дохионы хэлмэрчийг бэлтгэх анхан шатны нэг удаагийн сургалтын үргэлжлэх хугацаа нь ажлын 5-аас доошгүй хоног байх бөгөөд сургалтыг эрх бүхий мэргэжлийн сургалтын байгууллага болон иргэнтэй хамтран зохион байгуулна. Сургалтын зардлыг “Мэргэжлийн болон давтан сургалтын нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээ”-гээр санхүүжүүлнэ.

2.5.5.8. Удирдамжийн 2.5.5.7-д заасан арга хэмжээний зардлыг хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээний зардалд хуваарилсан хөрөнгөнөөс санхүүжүүлнэ.

2.5.5.9. Хөтөч, дохионы хэлмэрч, чиглүүлэгч болон орон зайн чиг баримжааны сургагч багшийн цагийн ажлын хэлбэрээр ажиллах хугацаа нь жилд 800 цагаас хэтрэхгүй байна.

2.5.6. Ажил олгогчийг дэмжих арга хэмжээг зохион байгуулах

2.5.6.1. Хөтөлбөрийн 4.2.1-д заасан урамшуулалд хамрагдах хүсэлтэй ажил олгогч нь хөтөлбөрийн 2.1-д тодорхойлсон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд авах тухай шийдвэр, хүсэлтийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст гаргаж, “Хөгжлийн

бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан ажил олгогчид урамшуулал олгох гэрээ”-ний загварын дагуу гэрээ байгуулж, талууд баталгаажуулна.

2.5.6.2. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь дээрх гэрээний хэрэгжилт, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажиллаж байгаа байнгын ажлын байрны тогтвортой байдалд тогтмол хяналт тавина.

2.5.6.3. Хөтөлбөрийн 4.2.1-д заасан урамшууллыг дараах баримт бичгийг үндэслэн аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс олгоно. Үүнд:

А. Аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

Б. Ажил олгогч, ажилтны хүсэлт;

В. Ажилтны иргэний үнэмлэхний хуулбар;

Г.Эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссийн хүчинтэй шийдвэр;

Д. Хөдөлмөрийн гэрээний хуулбар;

Е. Ажилтны нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар;

Ё. Ажил олгогчийн хүн амын орлогын болон нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тухай болон татвар шимтгэлийн өргүй талаарх Татварын болон Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт;

Ж. Аймаг, дүүргийн Хөдөлмөрийн хэлтэстэй байгуулсан гэрээ;

З. Ажилтны цалингийн картны хуулга;

И. Бусад.

2.5.6.4. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь байнгын ажлын байртай болж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон урамшуулалд хамрагдсан ажил олгогчийн талаарх мэдээллийг “Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан”-д бүртгэнэ.

2.5.7. Ажлын байрны санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ Үүнд:

2.5.7.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан байнгын ажлын байрыг бий болгоход олгох санхүүгийн дэмжлэгийн сонгон шалгаруулалтыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу тухайн оны 3-4 сард багтаан зохион байгуулна.

2.5.7.2. Санхүүгийн дэмжлэгийн 70 хувийг төсөл эхлүүлэхээр гэрээ байгуулсны дараа, үлдсэн хувийг төслийн хэрэгжилтийн явцын болон үр дүнгийн тайлан мэдээг үндэслэн үлдэгдэл санхүүжилтийг олгоно.

2.5.7.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгож буй аж

ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж, санхүүжилтийг олгох ба хэрэгжилтийн явц, үр дүнд тогтмол хяналт тавьж, үр дүнгээ тайлагнаж ажиллана.

2.5.7.4. Угаргахэмжээндхамрагдахбайгуул-лагуудыгөргөжүүлэх, үр дүнг сайжруулах, тохируулгатай ажлын байр нэмэгдүүлсэн байдлыг нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөөр тооцно.

2.5.7.5. Хөтөлбөрөөр олгож буй санхүүгийн дэмжлэгт хамрагдсан аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын хэрэгжүүлсэн төслийн гүйцэтгэлийн үр дүнд суурилан 24 сарын дараа дахин хамруулж болно.

2.6. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд:

Хөтөлбөрийн хамрах хүрээг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

- “ахмад мэргэжилтэн” гэж зөвлөх үйлчилгээ, төсөл хэрэгжүүлэхээр аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст бүртгүүлсэн, Хөдөлмөрийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай болон Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд тус тус заасан тэтгэвэр авагч /хүчин төгөлдөр тэтгэврийн дэвтэртэй/ ахмад настанг;

- “Ахмад настны эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг холбоо, төрийн бус байгууллага” гэж Төрийн бус байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан хуулийн этгээдийг;

- “Ахмад мэргэжилтний зөвлөх баг” гэж нийгэм, эдийн засгийн тодорхой салбар, мэргэжлийн чиглэлээр ахмад настны эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын 3 ба түүнээс дээш гишүүнтэй тэтгэвэр авагч ахмад мэргэжилтнүүдийн баг, бүлгийг;

- “Мэргэжлийн өндөр ур чадвартай” гэж хувь хүний гоц буюу ховор авьяас, мэргэжил, өндөр ур чадвар, нарийн мэргэшил, мэдлэгийн эрх /диплом, сертификат, гэрчилгээ гэх мэт/ эзэмшсэн хүнийг тус тус ойлгоно.

2.6.1. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг зохион байгуулах

2.6.1.1. “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ” -нд хамрагдах боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй болон төрийн захиргааны салбарт зөвлөгөө үзүүлэх ахмад мэргэжилтэнг тухайн сум, дүүрэг, хорооны онцлогийг харгалзан аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс тодорхойлж, хэрэгжүүлнэ.

2.6.1.2. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь тухайн салбарт мэдлэг туршлагатай, тэтгэврийн насны ахмад иргэдэд сурталчилгааны ажлыг зохион байгуулна.

2.6.1.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй бусад хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд зөвлөгөө өгөх, хяналт тавих ажлыг хамтран гүйцэтгэж болно.

2.6.1.4. Мэдээлэл сурталчилгааны үр дүнд төсөлд хамрагдах хүсэлтэй ахмад мэргэжилтэн оршин суух харъяаллын дагуу Хөдөлмөр,

халамжийн үйлчилгээний газар, хэлтэст бүртгүүлэхэд дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

А. Төслийг хэрэгжүүлэх тухайн сум, хорооны Засаг даргын тодорхойлолт;

Б. Төсөл хэрэгжүүлэгчийн хүсэлт;

В. Иргэний үнэмлэхний хуулбар, түүний танилцуулга;

Г. Зөвлөгөө өгөх ажил үйлчилгээний төрөл, арга хэлбэр, хугацаа, гарах үр дүн, санхүүжилтийн тооцоо болон бусад шаардлагатай зүйлийг тусгасан төсөл, төлөвлөгөө;

Д. бусад шаардлагатай лавлагаа.

2.6.1.5. Төслийн сонгон шалгаруулалтыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг зохион байгуулна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ахмадын төрийн бус байгууллагын төлөөллийг зөвшилцөн оролцуулна.

2.6.1.6. Сонгон шалгаруулалтанд тэнцсэн төсөл хэрэгжүүлэгчтэй Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын тушаалаар баталсан гэрээний загварын дагуу “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний гэрээ”-г байгуулж, баталгаажуулна.

2.6.1.7. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст нь шаардлагатай тохиолодолд ахмад мэргэжилтний зөвлөгөө өгөх зохион байгуулалттай үйл ажиллагаа явуулах байр, техник хэрэгсэл, хамрагдах иргэдийн оролцоог хангах талаар сум, хороо, нутгийн захиргааны байгууллагатай хамтран дэмжлэг үзүүлнэ.

2.6.2. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх

2.6.2.1. Хөтөлбөрийн 5.1.-д заасан ахмад мэргэжилтний багийн зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэхэд Засгийн газрын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан “олон нийтийн байгууллагаас улс орныг хөгжүүлэх, төр, нийгмийн байгууллыг бэхжүүлэх, төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг хангахад тус дөхөм үзүүлэх талаар гаргасан санал, санаачилгыг дэмжих шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар тэдгээр байгууллагатай харилцан ажиллана.”, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан “Төрийн байгууллага төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн болон бусад хэлбэрийн дэмжлэг үзүүлж болно”, 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан “төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс олгосон хөрөнгө” зэрэг холбогдох заалтуудыг үндэслэл болгоно.

2.6.2.2. Төсөлд хамрагдах ахмад мэргэжилтний зөвлөх баг нь төсөл хэрэгжүүлэх тухайн салбарт мэргэшсэн, 3-аас доошгүй гишүүнтэй байна. Төсөл хэрэгжүүлэх баг нь өөрийн үйл ажиллагааны талаарх асуудлаар удирдах дээд, төв байгууллагаараа уламжлан Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газартай гэрээ байгуулан ажиллана.

2.6.2.3. Төсөл хэрэгжүүлэхээр шалгарсан байгууллага, зөвлөх баг нь тухайн салбарт хэрэгцээтэй байгаа ахмад мэргэжилтний туршлага, мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх, нарийн мэргэжлийн гарын авлага, арга зүйн зөвлөмж, ном товхимлыг төслийн өртөгтөө багтаан боловсруулж, хэвлэх зардалд зарцуулж болно. Төслийн нийт өртөгийн 10 хувиас хэтрэхгүй байна.

2.6.2.4. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь тухайн аймаг, сум, дүүрэг, хороонд төсөл хэрэгжүүлэгч ахмад мэргэжилтнүүдийн зөвлөх багтай байнгын харилцаатай байж, төслийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт, үнэлгээ хийнэ.

2.6.3. Аж ахуй болон өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд нь зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг үзүүлэх

2.6.3.1. Аж ахуй болон өрхийн үйлдвэрлэл эрхлэх ахмад настан нь өөрийн амьдралын явцад олж авсан, мэдлэг, туршлагадаа тулгуурлан өрхийн орлого нэмэгдүүлэх зорилгоор төсөл хэрэгжүүлнэ.

2.6.3.2. Мэдээлэл сурталчилгааны үр дүнд төсөлд хамрагдах хүсэлтэй ахмад настан оршин суух харьяаллын дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст бүртгүүлэхэд дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

А. Төслийг хэрэгжүүлэх тухайн сум, хорооны Засаг даргын тодорхойлолт;

Б. Төсөл хэрэгжүүлэгчийн хүсэлт;

В. Иргэний үнэмлэхний хуулбар;

Г. Аж ахуй болон өрхийн үйлдвэрлэл эрхлэх хугацаа, гарах үр дүн, санхүүжилтийн тооцоо болон бусад шаардлагатай зүйлийг тусгасан төсөл, төлөвлөгөөтэй байх;

Д. Бусад шаардлагатай лавлагаа.

Гуравдугаар бүлэг. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах

3.1. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ.

3.1.1. Хөдөлмөрийн зах зээлд оролцогчдыг нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээнд хамруулах;

3.1.2. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;

3.1.3. Ажилд зуучлах.

3.2. Хөдөлмөрийн зах зээлд оролцогчдыг нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээнд хамруулах

3.2.1. Нэгдсэн бүртгэл мэдээллийн үйлчилгээ нь ажил хайгч иргэнийг ажлын байр, түүнд тавигдах шаардлага, ажил мэргэжлийн мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн бүртгэлийн санд иргэний мэдээллийг ХЗЗ-2 маягтын дагуу

оруулж бүртгэх цогц арга хэмжээ, үйлчилгээнээс бүрдэнэ.

3.2.2. Мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх үйлчилгээний бүрэлдэхүүн хэсэг нь хөдөлмөр зах зээлд оролцогч ажил олгогч байгууллага, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагын мэдээллийг ХЗЗ-1 маягтын дагуу хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн санд бүртгэх, мэдээллийн үнэн зөв, бодитой байдлыг хангахад чиглэнэ.

3.2.3. Мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх үйлчилгээнд ажил хайх, ажил олоход туслалцаа үзүүлэхэд чиглэсэн тодорхой ажил мэргэжил, ажлын байрны талаарх мэдээ, мэдээлэл цуглуулах, боловсруулах, ажил мэргэжлийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, баяжуулах, нэгдсэн мэдээллийн сангийн боловсруулсан мэдээллийг ажил хайгч иргэдэд хүргэх, олон нийтэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдах нөхцлийн талаар зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах суурь үйлчилгээ хамаарна.

3.3. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах

3.3.1. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд Ерөнхий боловсролын сургуулийн /ЕБС/ сурагчдад ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилгүй иргэдэд тодорхой ажил, мэргэжил, ажлын байрны талаарх мэдээ, мэдээллийг иргэдэд хүргэх, ажил мэргэжлээ сонгох болон хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах нөхцлийн талаар зөвлөгөө өгөх хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах үйлчилгээ хамаарна.

3.3.2. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлийн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг ганцаарчилсан болон бүлгээр зохион байгуулж, батлагдсан зардлын жишгийн дагуу санхүүжүүлнэ.

3.3.3. Мэргэжлийн мэдээллийн жишиг үйлчилгээ үзүүлэх журам, уг үйлчилгээг хэрэгжүүлэх хөтөлбөр, агуулгыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар батлах бөгөөд жишиг үйлчилгээ нь онлайн хэлбэрээр хэрэгжих ба үйлчилгээнд ажил хайгч иргэд, хүүхэд, залуучуудыг хамруулна.

3.3.4. Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, зөвлөгөө өгөх үйлчилгээг зохион байгуулах бөгөөд үргэлжлэх хугацаа нь ажлын 3 өдрөөс хэтрэхгүй байна.

3.3.5. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн болон сум, хороо, тосгоны хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн, мөн эрх бүхий сургалтын байгууллагаар гэрээний үндсэн дээр зохион байгуулна.

3.4. Ажилд зуучлах үйлчилгээ

3.4.1. Ажилд зуучлах үйлчилгээ нь ажлын байрыг судлах, ажил олгогчийн эрэлт хэрэгцээг тодорхойлох, ажил хайгчдад зөвлөгөө, мэдээлэл өгч ажлын байранд тохирох эсэх, хувь хүний болон ур чадварын үзүүлэлтийг шинжлэх, хоёр талын хэрэгцээнд нийцсэн туслалцаа үзүүлэх үйлчилгээ хамаарна.

3.4.2. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний байгууллагад тавих шаардлага стандартыг хангасан хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх байгууллага нь харьяалах орон нутгийн болон салбарын онцлог, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогод нийцүүлэн ажилд зуучлах үйлчилгээний байгууллагын стандарт, журмуудыг боловсруулан мөрдөж, үйлчилгээний гүйцэтгэлийг хэмжих шинэ арга хэрэгсэл боловсруулж хэрэгжүүлнэ.

3.4.3. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний стандартын дагуухөдөлмөрэрхлэлтийнүйлчилгээүзүүлжбуйорчныгүйлчлүүлэгчдэд ээлтэй, илүү үр дүнтэй, үр ашигтай үйлчилгээ үзүүлэх боломжтой болгон шинэчлэн зохион байгуулна. Үүнд:

- Үйлчлүүлэгчдийг хүлээж авах хэсэгт компьютерууд байрлуулах,
- Үйлчлүүлэгчид өөрсдийгөө бүртгэх, ажил хайх боломж бүрдүүлэх,
- Ганцаарчилсан зөвлөгөө өгөх, ажил хайх сургалт семинар, бүлгээр зөвлөгөө хийх боломж бүрдүүлэх,
- Ажил хайгч иргэдийг тохирсон ажлын байранд зуучлах /жоб матчинг хийх/,
- Нэгдсэн болон төрөлжсөн бирж ажиллуулах /цагийн ажилд зуучлах болон хувийн зуучлалын байгууллагын үйлчилгээ/,
- Ажлын байрны нэгдсэн зар мэдээ,сүлжээ, сайт бий болгох,
- Хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээ, үйлчилгээний талаарх сурталчилгаа, өдөрлөг зохион байгуулах.

3.4.4. Ажил олгогч нарт зориулсан үйлчилгээг сайжруулах, ажлын байранд зуучлах үйлчилгээнд доорх арга хэмжээг хамруулна .Үүнд:

- Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сан дахь ажлын байрны захиалгын тоо, чанарыг сайжруулах, шинэчлэх үйл явцыг тодорхой болгох,
- Ажлын байрны захиалгыг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд холбогдох боломжтой болгох,
- Ажил олгогчдод шаардлагатай ажилтныг холбож өгөх, мэдээллийн үйлчилгээ /онлайн зуучлалын үйлчилгээ/
- Ажил олгогчид ажлын байрны захилгаа бүртгүүлж, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн сан болон бусад хувийн хэвшлийн ажлын байрны мэдээллийн санг ашиглах нөхцлийг бүрдүүлэх,
- Ажил олгогчийн ажлын байрны шилжилт хөдөлгөөний

мэдээллийг тогтмол хугацаанд авч хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн санг баяжуулах.

3.4.5. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангахад чиглэсэн ажилд зуучлалын үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх гарын авлага, зөвлөмжийг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих газраас боловсруулна.

3.4.6. Аймаг, нийслэлийн хэмжээнд хөдөлмөрийн нэгдсэн болон төрөлжсөн бирж ажиллуулах /цагийн ажилд зуучлах болон хувийн хөдөлмөр зуучлалын байгууллагын үйлчилгээ/ нэгдсэн зар мэдээ, сүлжээ, цахим хуудас бий болгох, сурталчилгаа, өдөрлөг зохион байгуулна.

3.4.7. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн биржүүдийн үйл ажиллагаанд тавигдах шалгуур үзүүлэлтүүдийг Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавих шаардлага, стандартын дагуу тодорхойлж, стандартын шаардлага хангасан дүгнэлтийг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар гаргах ба бүртгэж, гэрчилгээ олгоно.

-----o0o-----



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

2019 оны 03 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар № А/82

Улаанбаатар хот

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛЧИЛГЭЭ, АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГЖИД НОГДОХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хоёрдугаар болон гуравдугаар бүлэгт заасан үйлчилгээ, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Үйлдвэрлэл дээрх сургалтын нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээ"-г нэгдүгээр, "Мэргэжлийн болон давтан, явуулын сургалтын нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээ"-г хоёрдугаар, "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний зардлын жишиг хэмжээ"-г гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээг үндэслэл болгож, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлж, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Б.Нямдаваа/-т даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/18 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

С.ЧИНЗОРИГ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2019 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн
А/82 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**Үйлдвэрлэл дээрх сургалтын нэг суралцагчид ногдох
зардлын жишиг хэмжээ**

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал	Мэргэжлийн чиглэл	Ажилгүй иргэн, сургууль завсардсан хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхэд, ажил олоход хүчдрэлтэй иргэний сургалт		Ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэний сургалт	
		5 ажлын өдөрт ногдох зардлын хэмжээ /мян.төг/	Нийт зардлын дээд хэмжээ /мян. төг/	5 ажлын өдөрт ногдох зардлын хэмжээ /мян.төг/	Нийт зардлын дээд хэмжээ /мян.төг/
52А. Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, ан агнуур	1. Газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл, ан агнуур болон түүнд холбогдох туслах үйл ажиллагаа	75.0	450.0	52.5	315.0
	2. Ойн аж ахуй, мод бэлтгэх	62.5	375.0	43.8	262.8
	3. Бусад	56.3	337.8	39.4	236.4
Б.Уул уурхай, олборлолт	1. Машин механизм, төхөөрөмжийн оператор	97.5	585.0	68.3	409.8
	2. Машин механизм, төхөөрөмжийн засварчин	97.5	585.0	68.3	409.8
	3. Зүтгүүрийн машинч /төмөр замын ажилтан/	90.0	540.0	63.0	378.0

	4. Цооног өрөмлөгч, адилтгах бусад ажилтан	97.5	585.0	68.3	409.8	
	5. Далд ба ил уурхайчин	90.0	540.0	63.0	378.0	
	6. Баяжуулагч	90.0	540.0	63.0	378.0	
	7. Зам, засвар үйлчилгээний ажилтан	77.5	465.0	54.3	325.8	
	8. Хүнд даашын тээврийн хэрэгслийн жолооч	82.5	495.0	57.8	346.8	
	9. Бусад	75.0	450.0	52.5	315.0	
	В.Боловруулах үйлдвэр	1. Хүнсний бүтээгдэхүүн-ий үйлдвэрлэл	60.0	360.0	42.0	252.0
		2.Нэхмэл оёдол болон хувцас үйлдвэрлэл	60.0	360.0	42.0	252.0
		3. Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	60.0	360.0	42.0	252.0
4.Хэвлэх, дахин үйлдвэрлэх ажиллагаа		52.5	315.0	36.8	220.8	
5.Бусад		45.0	270.0	31.5	189.0	
Г.Барилга болон техникийн үйлчилгээ	1.Кран өргөгч цамхаг түүнтэй адилтгах машины оператор	90.0	540.0	63.0	378.0	
	2.Барилгын засал, чимэглэл	82.5	495.0	57.8	346.8	
	3.Барилгын өрөг утсрагч	82.5	495.0	57.8	346.8	
	4.Барилгын бетон арматур	90.0	540.0	63.0	378.0	

5.Барилгын цахилгаанчин	90.0	540.0	63.0	378.0
6.Барилгын гагнуурчин	90.0	540.0	63.0	378.0
7.Барилгын сантехникч	82.5	495.0	57.8	346.8
8.Барилгын мужаан	82.5	495.0	57.8	346.8
9.Барилгын материал үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн оператор	90.0	540.0	63.0	378.0
10.Шилчин	82.5	495.0	57.8	346.8
11.Дээвэрчин	82.5	495.0	57.8	346.8
12.Металл хийц бэлтгэгч, нимгэн төмөрчин	82.5	495.0	57.8	346.8
13.Цахилгаан төхөөрөмжийн механикч /тохируулагч/	82.5	495.0	57.8	346.8
14.Агааржуулалт, агаар сэлгэлтийн механикч	82.5	495.0	57.8	346.8
15.Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн засварчин	82.5	495.0	57.8	346.8

Үйлдвэрлэл дээрх сургалтын нэг суралцагчид ногдох зардлын хэмжээ тус бүрийн 20 хувийг онолын хичээлд, 80 хувийг дадлагын хичээлд зарцуулна.

Үйлдвэрлэл дээрх сургалтын нэг суралцагчид ногдох зардлын хэмжээг “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох хөтөлбөр” -г заасан үйлдвэрлэл дээрх сургалтын зардалд жишиг болгоно.

---oOo---

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2019 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн
А/82 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**Мэргэжлийн болон давтан сургалтын нэг суралцагчид
ногдох зардлын жишиг хэмжээ**

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал	Мэргэжлийн чиглэл	Ажилгүй иргэн, сургууль завсардсан хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхэд, ажил олоход хүдрэлтэй иргэний сургалт		Ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэний сургалт	
		5 ажлын өдөрт ногдох зардлын хэмжээ /мян.төг/	Нийт зардлын дээд хэмжээ /мян.төг/	5 ажлын өдөрт ногдох зардлын хэмжээ /мян.төг/	Нийт зардлын дээд хэмжээ /мян.төг/
А. Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, ан агнуур	1. Үр тариа, гэжээлийн ургамал тариалах	26.7	160.0	21.3	128.0
	2. Фермерийн аж ахуй	26.7	160.0	21.3	128.0
	3. Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах / ногоочин/	26.7	160.0	21.3	128.0
	4. Ойн аж ахуй, мод бэлтгэх	23.3	140.0	18.7	112.0
	5. Малчин	23.3	140.0	18.7	112.0
	6. Бусад	23.3	140.0	18.7	112.0

Б.Уул уурхай, олборлолт	1.Машин механизм, төхөөрмжийн оператор	46.7	280.0	37.3	224.0
	2.Машин механизм, төхөөрмжийн засварчин	40.0	240.0	32.0	192.0
	3.Зүтгүүрийн машинч /төмөр замын ажилтан/	40.0	240.0	32.0	192.0
	4.Цооног өрөмдөгч, адилтгах бусад ажилтан	36.7	220.0	29.3	176.0
	5.Далд ба ил уурхайчин	36.7	220.0	29.3	176.0
	6.Баяжуулагч	33.3	200.0	26.7	160.0
	7.Зам, засвар үйлчилгээний ажилтан	36.7	220.0	29.3	176.0
	8. Бусад	33.3	200.0	26.7	160.0
В.Боловруулах үйлдвэр	1.Хөнгөн үйлдвэр-лэлийн оёдол, эсгүүр	30.0	180.0	24.0	144.0
	2.Хөнгөн үйлдвэр-лэлийн сүлжигч, нэхэгч, кительчин	30.0	180.0	24.0	144.0
	3.Хатгамал, эсгий, даавуу урдал	26.7	160.0	21.3	128.0
	4.Арьс ширэн урдал	26.7	160.0	21.3	128.0
	5.Гутал үйлдвэрлэл /монгол буриад гутал эсгэх оёх /	26.7	160.0	21.3	128.0
	6.Гар урдал бэлэг дурсгал	26.7	160.0	21.3	128.0

	7.Модон эдлэл буюу гэр ахуйн мужаан	30.0	180.0	24.0	144.0
	8.Жижиг эдлэл үйлдвэрлэл /чөдөр, ногт г.м/	26.7	160.0	21.3	128.0
	9.Хүнсний боловсруулах үйлдвэрлэл /мах, сүү/	30.0	180.0	24.0	144.0
	10.Хоол үйлдвэрлэл, тогоч	30.0	180.0	24.0	144.0
	11.Талх нарийн боов	23.3	140.0	18.7	112.0
	12.Сүү цагаан идээ боловсруулах	23.3	140.0	18.7	112.0
	13.Бусад	23.3	140.0	18.7	112.0
	1.Кран өргөгч намхаг түүнтэй ажилтга машины оператор	36.7	220.0	29.3	176.0
	2.Засал, чимэглэл	40.0	240.0	32.0	192.0
	3.Өрөг угсрагч	40.0	240.0	32.0	192.0
	4.Бетон арматур	43.3	260.0	34.7	208.0
	5.Цахилгаанчин	40.0	240.0	32.0	192.0
	6.Гагнуурчин	40.0	240.0	32.0	192.0
	7.Сантехникч	40.0	240.0	32.0	192.0
	8.Барилгын мужаан	40.0	240.0	32.0	192.0
	9.Барилгын материал үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн оператор	40.0	240.0	32.0	192.0
Г.Барилга болон техникийн үйлчилгээ					

10. Шилчин	33.3	200.0	26.7	160.0
11. Дээрчин	33.3	200.0	26.7	160.0
12. Металл хийц бэлтгэгч, нимгэн төмөрчин	40.0	240.0	32.0	192.0
13. Шахилаан төхөөрөмжийн механикч /тохируулагч/	40.0	240.0	32.0	192.0
14. Агааржуулалт, агаар сэлгэлтийн механикч	36.7	220.0	29.3	176.0
15. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн засварчин	33.3	200.0	26.7	160.0
16. Хөдөө аж ахуйн машин механизм, тоног төхөөрөмжийн механикч, засварчин	40.0	240.0	32.0	192.0
17. Барилгын материал үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн засварчин	36.7	220.0	29.3	176.0
18. Бусад	33.3	200.0	26.7	160.0
1. Автомашины засвар	26.7	160.0	21.3	128.0
2. Гэр ахуйн цахилгаан хэрэгслийн засвар	26.7	160.0	21.3	128.0
3. Дархан, мужаан, сийлбэр	23.3	140.0	18.7	112.0
4. Телевизор, гар утасны засварчин	23.3	140.0	18.7	112.0
5. Гутал засвар	23.3	140.0	18.7	112.0
Д. Бөөний болон жижиглэн худалдаа, ахуйн болон засвар үйлчилгээ				

	6.Жижиг эдлэлийн засварчин /цүнх, цаг г.м/	20.0	120.0	16.0	96.0
	7.Үсчин	26.7	160.0	21.3	128.0
	8.Гоо засал	26.7	160.0	21.3	128.0
	9.Зочид буудлын үйлчлэгч, үйлчилгээний ажилтан	23.3	140.0	18.7	112.0
	10.Гэрийн үйлчлэгч, асрагч	20.0	120.0	16.0	96.0
	11.Цэцэрлэгийн багшийн туслах ажилтан	23.3	140.0	18.7	112.0
	12.Аялал жуулчлалын хөтөч,гайлбарлагч	23.3	140.0	18.7	112.0
	13.Худалдагч касс, нярав	23.3	140.0	18.7	112.0
	14.Зөөгч Бармен	23.3	140.0	18.7	112.0
	15.Бусад	20.0	120.0	16.0	96.0

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн (суралцагч)-д ногдох сургалтын зардлын хэмжээ нь тухайн мэргэжлийн болон давтан сургалтын зардлын хэмжээг 30 хувиар нэмэгдүүлэн тооцсонтой тэнцүү байна.

Мэргэжлийн болон давтан сургалтын нэг суралцагчид ногдох зардлын хэмжээ тус бүрийн 30 хувийг онолын хичээлд, 70 хувийг дадлагын хичээлд тус тус зарцуулна.

Мэргэжлийн болон давтан сургалтын нэг суралцагчид ногдох зардлын хэмжээг “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрийн”-ийн мэргэжлийн болон давтан сургалт, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хөдөлмөр эрхлэлтийн сургалтын зардалд жишиг болгоно.

---oOo---

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2019 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн
А/82 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний
зардлын жишиг хэмжээ**

№	Зардлын хэмжээг жишиг болгох арга хэмжээнүүд	Зардлын төрөл, хэмжээ	
		Улаанбаатар хот	Аймгийн төв
1.	“Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг арга хэмжээ	700.0	600.0
		Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт ¹ үзүүлэх нэг сарын зардлын дээд хэмжээ /мян.төг/	
		Улаанбаатар хот	Сумын төв
		250.0	150.0
2.	“Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалтын арга хэмжээ	Зардлын дээд хэмжээ /мян.төг/	
		3 өдөр = 15.0	5 өдөр = 30.0
		Улаанбаатар хот	Сумын төв
		200.0	150.0
		Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалтад нэг иргэнийг хамруулах зардлын дээд хэмжээ /мян.төг/	

¹ Түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг үзүүлэхдээ тухайн зорилтот бүлгийн иргэний ажлын байрны түрээсийн төлбөрийн 40 хүртэл хувийг 6 сарын хугацаатай сар бүр нөхөн олгоно.

3.	“Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн ажил олгогчийн урамшуулал арга хэмжээ	Дээд хэмжээгээр тооцох нэг сарын цалингийн хэмжээ /мян.төг/ 500.0
4.	“Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээ, зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээ, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ арга хэмжээ	Нийтийг хамарсан ажлын зардлын жишиг хэмжээ /мян. төг/ Нэг цагийн ажлын хөлс 3.5 ХАБЭА-д зарцуулах зардал 0.5
5.	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээний нэг хүнд ногдох зардлын дээд хэмжээ /мян.төг/ Ганцаарчилсан 12.0 Бүлгээр 6.0
6.	Ажилд зуучлах үйлчилгээ	Ажилд зуучлах үйлчилгээний ² нэг хүнд ногдох зардлын дээд хэмжээ /мян.төг/ 7.0
7.	“Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ	Хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээний нэг хүнд ногдох зардлын дээд хэмжээ /мян.төг/ 45.0 Хөгжлийн бэрхшээлтэй иргэн 70.0

² Ажилд зуучлах үйлчилгээ, ажлын байрны мэдээлэл авах, солилцохтой холбоотой гарах бичиг хэрэг, харилцаа холбоо, мэдээлэл, сурталчилгааны болон явуулын бирж ажиллуулахад зарцуулна.

8.	“Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээ үзүүлэх арга хэмжээ	Хөтөч, дохионы хэлмэрч, чиглүүлэгч болон орон зайн чиг баримжааны сургагч багшийг бэлтгэх сургалтын зардлын жишиг хэмжээ /мян.төг/ 5 өлөр = 70.0 дээд хэмжээ 180.0
		Хөтөч, дохионы хэлмэрч ажиллуулах нэг цагийн ажлын хөлс /мян.төг/ 3.5
9.	“Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн Гарааны бизнесийг дэмжих арга хэмжээ	Гарааны бизнесийг хөгжүүлэх, сонгон шалгаруулах арга хэмжээг нэг удаа зохион байгуулах зардлын дээд хэмжээ /мян.төг/ 3,000.0
		Шалгарсан төслүүдийг хурдасгуурт хамруулах, ментор (3 сарын хугацаанд)-ын зардлын дээд хэмжээ /мян.төг/ 2,000.0
10.	“Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн Гэрээт малчин өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ	Гэрээт малчин өрхийн орон нутаг руу нүүхэд олгох нэг удаагийн санхүүгийн дэмжлэгийн хэмжээ /мян.төг/ 50-200 км 201-350 км 351-500 км 150.0 төг 350.0 төг 500.0 төг
		Нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн олгох нэг сард ногдох зардлын хэмжээ
		Ажил олгогч малчин 12.5% буюу 52500 төгрөг Гэрээт малчин 11.5% буюу 48300 төгрөг
		Нийт 24% буюу 100800 төгрөг

/10 дахь хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 2 дугаар сарын 05- ны өдрийн А/45 тоот тушаалаар нэмж оруулсан/

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Монгол Улсын нийт хүн ам (мян.хүн)	2,930.2	2,995.9	3,057.7	3,119.9	3,177.8	3,238.4	-
Ажиллах хүч (мян.хүн)	1198.3	1206.5	1243.8	1275.6	1357.4	1358.6	1293.5
Ажиллагчид (мян.хүн)	1103.6	1110.7	1151.2	1147.8	1238.3	1253.0	1188.4
Ажилгүй иргэд (мян.хүн)	94.7	95.8	92.6	127.8	119.0	105.6	105.1
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам (мян.хүн)	738.7	734.9	779.0	831.3	862.9	867.9	838.5
Ажиллах хүчний оролцооны түвшин (хувь)	61.9	62.1	61.5	60.5	61.1	61	60.7
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин (хувь)	57	57.2	56.9	54.5	55.8	56.3	55.7
Ажилгүйдлийн түвшин (хувь)	7.9	7.9	7.5	10.0	8.8	7.8	8.1

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлт	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он
Ажлын байрны захиалгын тоо (оны эцэст өссөн дүнгээр)	104056	219013	114377	77699	57930	62574	64478	71124
Ажилд зуучлагдсан иргэний тоо (тайлант хугацааны эцэст өссөн дүнгээр)	34799	65632	54367	49739	35846	45683	43105	44059
Ажилд зуучлалын гүйцэтгэл (АЗ/АБЗ харьцаа %-иар)	33.4	30.0	47.5	64.0	72.1	73	67	62
Шинэ ажлын байранд орсон иргэний тоо (өссөн дүнгээр)	54695	59816	55909	50725	34520	27284	27146	33325
Бүртгэлтэй ажилгүй иргэний тоо /тухайн тайлант хугацааны эцэст/	35776	42772	36970	32788	34412	25450	24964	20761
Ажилгүйдлийн тэтгэмж авсан хүний тоо	10617	15859	16600	18700	23100	21200	21423	23033
Ажилгүйдлийн тэтгэмжийн хөрөнгө (сая.төг)	7308.3	14929.9	17800.0	22300.0	31600.0	34700.0	34300.0	43,005.0
Гадаацаас ажиллах хүч, мэргэжилтэн авах үйлчилгээ авсан иргэний тоо /оны эхнээс өссөн дүнгээр/	-	-	114548	79447	53271	45624	50136	47421

Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж буй гадаадын ажиллах хүч, мэргэжилтний тоо	10060	8863	7971	6779	5938	7892	4502	4601
Гадаадад ажиллах хүч илгээх үйлчилгээ авсан иргэний тоо	-	-	64600	41072	22464	36574	58078	92517
БНСУ-д илгээсэн Монгол иргэний тоо	2781	2153	1542	1113	944	1058	784	784

Эх сурвалж: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Ажилгүйдлийн тэтгэмжийн мэдээлэл НДЕГ

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ
(2019 он аймаг, нийслэл, дүүгээр)

Монгол Улсын хүн амын тоо (2018 оны жилийн эцсээр)	Ажиллагчид (4-р улирал)		Ажилгүй иргэд (3-р улирал)		Ажилгүйдлийн түвшин /хувиар/ (4-р улирал)	
	Баруун бүс	Баруун бүс	Баруун бүс	Баруун бүс	Баруун бүс	Баруун бүс
Баруун бүс	408,979	143,239	Баруун бүс	13,551	Баруун бүс	13.1
Баян-Өлгий	105,090	22,865	Баян-Өлгий	6,542	Баян-Өлгий	25.7
Говь-Алтай	58,471	24,512	Говь-Алтай	1,683	Говь-Алтай	10.4
Завхан	72,779	27,507	Завхан	1,092	Завхан	4.3
Увс	84,309	34,333	Увс	787	Увс	11.1
Ховд	88,330	34,022	Ховд	3,447	Ховд	13.4
Хангайн бүс	604,353	240,733	Хангайн бүс	19,615	Хангайн бүс	7.2
Архангай	96,720	46,473	Архангай	2,640	Архангай	3.4
Баянхонгор	88,356	27,972	Баянхонгор	4,098	Баянхонгор	6.2
Булган	62,214	27,671	Булган	1,715	Булган	8.8
Орхон	105,987	33,357	Орхон	3,599	Орхон	10.3
Өвөрхангай	117,112	51,818	Өвөрхангай	3,923	Өвөрхангай	9.5
Хөвсгөл	133,964	53,442	Хөвсгөл	3,640	Хөвсгөл	5.2
Төвийн бүс	513,438	212,969	Төвийн бүс	16,038	Төвийн бүс	7.9
Говьсүмбэр	17,796	8,214	Говьсүмбэр	1,456	Говьсүмбэр	3.8
Дархан-Уул	105,923	35,085	Дархан-Уул	8,808	Дархан-Уул	2.5
Дорноговь	69,304	31,381	Дорноговь	147	Дорноговь	11.4

(мянган хүнээр)

Дундговь	46,628	Дундговь	22,887	Дундговь	915	Дундговь	19.4
Өмнөговь	66,722	Өмнөговь	29,903	Өмнөговь	1,887	Өмнөговь	5.9
Сэлэнгэ	111,403	Сэлэнгэ	37,735	Сэлэнгэ	1,584	Сэлэнгэ	8.2
Төв	95,662	Төв	47,764	Төв	1,241	Төв	6.2
Зүүн бүс	220,334	Зүүн бүс	91,197	Зүүн бүс	12,480	Зүүн бүс	7.1
Дорнод	80,984	Дорнод	28,968	Дорнод	7,592	Дорнод	10.1
Сүхбаатар	62,322	Сүхбаатар	28,043	Сүхбаатар	2,745	Сүхбаатар	7.4
Хэнтий	77,028	Хэнтий	34,186	Хэнтий	2,143	Хэнтий	4.2
Улаанбаатар	1,491,375	Улаанбаатар	500,302	Улаанбаатар	64,898	Улаанбаатар	7.3
Хан-Уул	-	Хан-Уул	61,760	Хан-Уул	-	Хан-Уул	10
Багануур Багахангай	-	Багануур Багахангай Налайх	23,311	Багануур Багахангай Налайх	-	Багануур Багахангай Налайх	7.5
Баянзүрх	-	Баянзүрх	122,617	Баянзүрх	-	Баянзүрх	6.9
Налайх	-	Баянгол	75,891	Баянгол	-	Баянгол	1
Баянгол	-	Сүхбаатар	42,766	Сүхбаатар	-	Сүхбаатар	6.5
Сүхбаатар	-	Чингэлтэй	61,212	Чингэлтэй	-	Чингэлтэй	6.2
Чингэлтэй	-	Сонгино-хайрхан	112,745	Сонгино-хайрхан	-	Сонгино-хайрхан	11
Сонгино-хайрхан	-	Улсын дүн	1,188,440	Улсын дүн	126,582	Улсын дүн	8.1
Улсын дүн	3,238,479						

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Хүснэгт 3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдэд хамрагдсан иргэн, зарцуулсан хөрөнгө /2016-2019 оны байдлаар/

№	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ	2016 он		2017 он		2018 он		2019 он	
		Хүний тоо	Хөрөнгө /мян.төг/	Хүний тоо	Хөрөнгө /мян.төг/	Хүний тоо	Хөрөнгө /мян.төг/	Хүний тоо	Хөрөнгө /мян.төг/
1	Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байрыг дэмжих хөтөлбөр	5684	1,481,717.6	9631	1,137,628.9	7677	1,012,529.8	7353	886,615.9
2	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	11690	5,492,971.5	36466	11,615,916.7	38464	11,214,188.1	45728	13,741,806.1
3	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	12113	979,863.2	4281	1,715,697.3	4869	2,652,717.2	8177	5,193,509.3
4	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	4032	4,292,337.4	4886	4,518,801.4	6617	5,802,685.3	6265	5,505,836.4
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	4849	2,398,542.2	5782	3,227,764.0	5617	3,647,059.2	5622	3,542,869.6

6	“Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ” төсөл	2587	658,655.5	2278	1,300,117.6	1527	1,163,646.7	1342	1,283,928.6
	Нийт дүн	40955	15,304,087.35	63324	23,515,925.8	64771	25,492,826.3	74487	30,154,565.9

Эх сурвалж: ХХҮЕГ